Мал тооллогын 2021 оны дүнгээр 305.4 мянган малчид бүртгэгдэж мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байгаа бөгөөд энэ нь нийт ажиллагчидтай харьцуулахад 27.1 хувь буюу ажил эрхэлдэг 4 хүн тутмын нэг нь малчид байна. Малчдын тоо өмнөх оноос 6.6 мянган малчин буюу 2.2 хувиар өсжээ.



Малчдын тоог аймгаар авч үзэхэд 2021 онд өмнөх оноос Баянхонгор, Өвөрхангай, Орхон, Дархан-Уул аймгуудын малчдын тоо 44-158 буюу 0.2-9.9 хувиар буурсан байна. Өмнөговь, Говьсүмбэр, Дундговь, Дорноговь, Говь-Алтай, Дорнод аймгуудын малчдын тоо 31-87 буюу 0.2-2.4 хувиар өссөн байна. Бусад аймгууд болон Улаанбаатар хотод малчдын тоо 149-1 520 буюу 1.2-7.1 хувиар өссөн байна.

ЗУРАГ 9. МАЛЧДЫН ТОО, 2021 он, аймгаар



Улсын хэмжээнд нийт малчдын 42.8 хувь нь дараах 5 аймагт байна. Үүнд: Төв аймагт 19.4 мянга, Баянхонгор аймагт 23.1 мянга, Архангай аймагт 27.0 мянга, Өвөрхангай аймагт 28.3 мянга, Хөвсгөл аймагт 32.8 мянган малчин амьдарч байна.

ХҮСНЭГТ 13. МАЛЧДЫН ТОО, БҮС, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР

Бүс, аймаг, нийслэл	Малчдын тоо					Дүнд эзлэх хувь				
	2017	2018	2019	2020	2021	2017	2018	2019	2020	2021
Бүгд	303 590	288 700	285 482	298 789	305 430	100.0	100.0	100.0	100.0	100.0
Баруун бүс	79 192	72 395	70 478	73 659	76 167	26.1	25.1	24.7	24.7	24.9
Баян-Өлгий	17 200	13 993	13 746	14 414	14 946	5.7	4.8	4.8	4.8	4.9
Говь-Алтай	12 919	12 391	12 287	13 128	13 192	4.3	4.3	4.3	4.4	4.3
Завхан	16 775	15 953	15 644	16 210	16 512	5.5	5.5	5.5	5.4	5.4
Увс	17 173	16 130	15 988	16 577	17 460	5.7	5.6	5.6	5.5	5.7
Ховд	15 125	13 928	12 813	13 330	14 057	5.0	4.8	4.5	4.5	4.6
Хангайн бүс	124 682	120 381	119 170	124 349	127 154	41.1	41.7	41.7	41.6	41.6
Архангай	27 055	25 756	25 688	25 907	27 017	8.9	8.9	9.0	8.7	8.8
Баянхонгор	22 255	21 784	21 771	23 212	23 168	7.3	7.5	7.6	7.8	7.6
Булган	14 472	13 797	13 917	14 186	14 622	4.8	4.8	4.9	4.7	4.8
Орхон	1 396	1 352	1 299	1 421	1 280	0.5	0.5	0.5	0.5	0.4
Өвөрхангай	28 265	28 103	27 101	28 333	28 257	9.3	9.7	9.5	9.5	9.3
Хөвсгөл	31 239	29 589	29 394	31 290	32 810	10.3	10.2	10.3	10.5	10.7
Төвийн бүс	60 290	58 295	57 942	60 690	61 028	19.9	20.2	20.3	20.3	20.0
Говьсүмбэр	1 164	1 115	1 097	1 184	1 213	0.4	0.4	0.4	0.4	0.4
Дархан-Уул	2 295	1 846	1 743	1 887	1 729	0.8	0.6	0.6	0.6	0.6
Дорноговь	7 232	7 033	7 024	7 308	7 350	2.4	2.4	2.5	2.4	2.4
Дундговь	12 222	12 136	12 241	12 505	12 536	4.0	4.2	4.3	4.2	4.1
Өмнөговь	9 635	9 593	9 671	10 219	10 243	3.2	3.3	3.4	3.4	3.4
Сэлэнгэ	8 280	8 088	7 741	8 417	8 566	2.7	2.8	2.7	2.8	2.8
Төв	19 462	18 484	18 425	19 170	19 391	6.4	6.4	6.5	6.4	6.3
Зүүн бүс	36 411	34 508	34 313	36 310	37 031	12.0	12.0	12.0	12.2	12.1
Дорнод	8 710	7 778	7 983	8 486	8 573	2.9	2.7	2.8	2.8	2.8
Сүхбаатар	14 775	14 585	14 496	15 006	15 440	4.9	5.1	5.1	5.0	5.1
Хэнтий	12 926	12 145	11 834	12 818	13 018	4.3	4.2	4.1	4.3	4.3
Улаанбаатар	3 015	3 121	3 579	3 781	4 050	1.0	1.1	1.3	1.3	1.3


III.2. Малчдын нас, хүйс

Малчдыг насны бүлгээр дэлгэрэнгүй байдлаар авч үзвэл, 2021 оны байдлаар нийт малчдын 6.7 хувь (20.6 мянга) нь 15-24 насных, 21.2 хувь (64.8 мянга) нь 25-34 насных, 28.7 хувь (87.7 мянга) нь 35-44 насных, 24.5 хувь (74.9 мянга) нь 45-54 насных, 12.8 хувь (39.2 мянга) 55-64 насных, 6.0 хувь (18.3 мянга) нь 65-аас дээш насных байна.

Малчдын насны бүлэгт 15-34 насныг хэрэв залуу малчид гэж үзвэл нийт малчдын 28.0 хувийг эзэлж байна. Энэ үзүүлэлт 2000 онд 56 хувь байсантай харьцуулахад жилээс жилд малчдын дунд залуу малчдын эзлэх хувь багассаар байгааг илтгэж байна.

35-59 насны малчид 1995 онд нийт малчдын 95.4 мянга буюу 24.4 хувийг, 2020 онд 178.5 мянга буюу 59.7 хувийг эзэлж байсан бол 2021 онд 186.0 мянган буюу 60.9 хувийг эзлэх болж, 1995 оноос 36.5 нэгж хувиар нэмэгдэж, 2020 оноос 1.2 хувиар буурсан байна. Харин 60-аас дээш насны малчид 1995 онд нийт малчдын 69.9 мянга буюу 17.9 хувийг, 2020 онд нийт малчдын 31.2 мянга буюу 10.4 хувийг эзэлж байсан бол 2021 онд 34.0 мянга буюу 11.1 хувийг эзэлж, 1995 оноос 6.8 хувиар буурч, 2020 оноос 0.7 хувиар нэмэгдсэн байна.


ЗУРАГ 10. МАЛЧДЫН НАСНЫ БҮТЭЦ, хувиар



Нийт малчдын 180.4 мянга буюу 59.1 хувь нь эрэгтэй, 125.0 мянга буюу 40.9 хувь нь эмэгтэй малчид байна.


15-24 насны залуу малчдын 72.2 хувь нь эрэгтэй бол 27.8 хувь нь эмэгтэй байна. Харин 65 ба түүнээс дээш насны малчдын 51.9 хувь нь эрэгтэй бол 48.1 хувь нь эмэгтэй байна. Бусад насны бүлгүүдэд мөн адил эрэгтэй малчид давамгайлсаар байна.

ЗУРАГ 11. МАЛЧДЫН НАСНЫ БҮТЭЦ, 2021 ОН, насны бүлэг, хүйсээр



Эрэгтэй малчдын дунд залуу малчид дийлэнх хувийг эзэлж байна. Тухайлбал, 15-24 насны эрэгтэй малчид нийт эрэгтэй малчдынхаа 8.2 хувийг, 25-34 насныхан 22.3 хувийг эзэлж байгаа бол эдгээр насны эмэгтэй малчид нь нийт эмэгтэй малчдынхаа 4.6 болон 19.7 хувийг тус тус эзэлж, эрэгтэй малчдынхаас 2.6-3.7 нэгж хувиар бага хувийн жин эзэлж байна.


ЗУРАГ 12. МАЛЧДЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2021 ОН



III.3. Үндсэн болон туслах малчин

Энэ оны байдлаар мал аж ахуй эрхэлдэг малчдын 287.4 мянга буюу 94.1 хувь нь үндсэн малчин, 18.0 мянга буюу 5.9 хувь нь туслах малчид байна. 15-24 насны малчдын 87.6 хувь нь үндсэн малчин бол 12.4 хувь нь туслах малчин байна. 25 наснаас дээш насны бүлгүүдэд үндсэн малчин 93.7-96.2 хувийг эзэлж байна. Нас нэмэгдэх хэрээр үндсэн малчны хувийн жин нэмэгдэж байна.

ЗУРАГ 13. ҮНДСЭН БОЛОН ТУСЛАХ МАЛЧНЫ ХАРЬЦАА, 2021 ОН



Нийт үндсэн малчдын 74.6 хувь буюу 214.4 мянган малчин нь 25-54 насных байна. Харин нийт туслах малчдын 72.2 хувь буюу 13 мянган малчин нь 25-54 насных байна.

ХҮСНЭГТ 14. ҮНДСЭН БОЛОН ТУСЛАХ МАЛЧИД, 2021 ОН, насны бүлгээр

Насны бүлгээр	Бүгд	Үндсэн малчин			Туслах малчин			Дүнд эзлэх хувь	
		Үндсэн малчин	Эрэгтэй	Эмэгтэй	Туслах малчин	Эрэгтэй	Эмэгтэй	Үндсэн малчин	Туслах малчин
Бүгд	305 430	287 412	176 095	111 317	18 018	4 313	13 705	100.0	100.0
15-24	20 606	18 046	13 235	4 811	2 560	1 633	927	6.3	14.2
25-34	64 839	60 786	39 099	21 687	4 053	1 113	2 940	21.1	22.5
35-44	87 668	82 784	49 630	33 154	4 884	619	4 265	28.8	27.1
45-54	74 897	70 826	42 419	28 407	4 071	527	3 544	24.6	22.6
55-64	39 170	37 407	22 396	15 011	1 763	260	1 503	13.0	9.8
65 ↑	18 250	17 563	9 316	8 247	687	161	526	6.1	3.8

Үндсэн малчдын 61.3 хувь буюу 176.1 мянга нь эрэгтэй, 38.7 хувь буюу 111.3 мянга нь эмэгтэй малчид байна. Үндсэн малчдыг насны бүлгээр нь авч үзвэл 15-24 насны малчдын 73.3 хувь, 25-34 насны малчдын 64.3 хувь, 35-44 насны малчдын 60.0 хувь, 45-54 насны малчдын 59.9 хувь, 55-64 насны малчдын 59.9 хувь, 65 ба түүнээс дээш насны малчдын 53.0 хувийг эрэгтэй малчид эзэлж байна.

III.4. Малчдын боловсролын түвшин

Малчдын боловсролын түвшнийг 2021 оны байдлаар авч үзэхэд 38.8 хувь нь суурь боловсролтой, 25 хувь нь бүрэн дунд, 21.5 хувь нь бага, 6.3 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн, 5.0 хувь нь дээд боловсролтой байгаа бол 3.4 хувь нь боловсролгүй байна.

ХҮСНЭГТ 15. МАЛЧДЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, 2021 ОН, насны бүлгээр

Насны бүлгээр	Бүгд	Боловсролын түвшин					
		Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон тусгай мэргэжлийн	Дээд
Бүгд	305 430	10 338	65 717	118 476	76 405	19 272	15 222
15-24	20 606	669	2 756	8 289	6 481	1 552	859
25-34	64 839	2 515	11 865	18 441	20 059	4 902	7 057
35-44	87 668	3 683	24 362	36 399	18 309	1 488	3 427
45-54	74 897	1 567	9 225	35 130	21 940	5 293	1 742
55-64	39 170	1 126	8 729	15 735	7 934	4 335	1 311
65 ↑	18 250	778	8 780	4 482	1 682	1 702	826
Дүнд эзлэх хувь							
Бүгд	100.0	3.4	21.5	38.8	25.0	6.3	5.0
15-24	100.0	3.2	13.4	40.2	31.5	7.5	4.2
25-34	100.0	3.9	18.3	28.4	30.9	7.6	10.9
35-44	100.0	4.2	27.8	41.5	20.9	1.7	3.9
45-54	100.0	2.1	12.3	46.9	29.3	7.1	2.3
55-64	100.0	2.9	22.3	40.2	20.3	11.1	3.3
65 ↑	100.0	4.3	48.1	24.6	9.2	9.3	4.5

Малчдын боловсролыг насны бүлгээр нь авч үзвэл 25-44 насны нийт 152.4 мянган малчдын 6.2 мянга буюу 4.1 хувь нь боловсролгүй, 36.2 мянга буюу 23.8 хувь нь бага, 54.8 мянга буюу 36.0 хувь нь суурь, 38.4 мянга буюу 25.2 хувь нь бүрэн дунд, 6.4 мянга буюу 4.2 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн, 10.5 мянга буюу 6.9 хувь нь дээд боловсролтой байна.

Харин 45-64 насны нийт 114.1 мянган малчдын 2.7 мянга буюу 2.4 хувь нь боловсролгүй, 18.0 мянга буюу 15.7 хувь нь бага, 51.0 мянга буюу 44.6 хувь нь суурь, 29.9 мянга буюу 26.2 хувь нь бүрэн дунд, 9.6 мянга буюу 8.4 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн, 3.1 мянга буюу 2.7 хувь нь дээд боловсролтой байна.

ХҮСНЭГТ 16. МАЛЧДЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, 2021 ОН, насны бүлгээр, хувиар

Насны бүлгээр	Бүгд	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон тусгай мэргэжлийн	Дээд
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15-24	6.7	6.5	4.2	7.0	8.5	8.1	5.6
25-34	21.2	24.3	18.1	15.6	26.3	25.4	46.4
35-44	28.7	35.6	37.1	30.7	24.0	7.7	22.5
45-54	24.5	15.2	14.0	29.7	28.7	27.5	11.4
55-64	12.8	10.9	13.3	13.3	10.4	22.5	8.6
65 ↑	6.0	7.5	13.4	3.8	2.2	8.8	5.4

15-24 насны залуу малчдыг боловсролын түвшнээр нь авч үзвэл, бага боловсролтой малчдын 4.2 хувь, боловсролгүй малчдын 6.5 хувь, суурь боловсролтой малчдын 7.0 хувь, бүрэн дунд боловсролтой малчдын 8.5 хувь, техникийн болон тусгай мэргэжлийн боловсролтой малчдын 8.1 хувь, дээд боловсролтой малчдын 5.6 хувийг эзэлж байна.

Улсын хэмжээнд нийт 10.3 мянган боловсролгүй малчин байна. Боловсролгүй малчдыг хүйсээр нь авч үзвэл 6.5 мянга буюу 62.8 хувь нь эрэгтэй, 3.8 мянга буюу 37.2 хувийг эмэгтэй малчид эзэлж байна.


ХҮСНЭГТ 17. БОЛОВСРОЛГҮЙ МАЛЧИН, 2021 ОН, хүйсээр

Насны бүлгээр	Бүгд	Эрэгтэй		Эмэгтэй		Эзлэх хувь	Эрэгтэй	Эмэгтэй
		Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй			
Бүгд	10 338	6 493	3 845	100.0	62.8	37.2		
15-24	669	515	154	100.0	77.0	23.0		
25-34	2 515	1 740	775	100.0	69.2	30.8		
35-44	3 683	2 376	1 307	100.0	64.5	35.5		
45-54	1 567	951	616	100.0	60.7	39.3		
55-64	1 126	619	507	100.0	55.0	45.0		
65 ↑	778	292	486	100.0	37.5	62.5		

Боловсролгүй малчдыг насны бүлэг хүйсээр нь авч үзвэл, 65-с дээш насны малчдын 37.5 хувь нь эрэгтэй байгаа нь энэ насны эмэгтэй малчдаас 24.9 нэгж хувиар бага байна. Бусад насны бүлэг тус бүрт эрэгтэй малчид 55.0-77.0 хувийг эзэлж байгаа нь эмэгтэй малчдаас 9.0-54.0 нэгж хувиар илүү байна.


Боловсролгүй малчдыг байршлаар авч үзвэл, Говь-Алтай, Дорноговь, Ховд, Өмнөговь, Хөвсгөл, Баян-Өлгий, Увс, Сүхбаатар, Завхан аймгуудад улсын дунджаас их буюу тухайн аймгийн нийт малчдын 3.4-6.9 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 14. БОЛОВСРОЛГҮЙ МАЛЧДЫН ЭЗЛЭХ ХУВЬ, 2021 ОН, аймаг, нийслэлээр



Бүрэн дунд боловсролтой малчид 76.4 мянга буюу нийт малчдын 25.0 хувийг эзэлж байна. Аймгаар авч үзвэл Завхан, Хэнтий, Архангай, Хөвсгөл, Дорнод, Говьсүмбэр, Төв, Ховд, Булган, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон аймгууд болон Улаанбаатар хотод бүрэн дунд боловсролтой малчид улсын дунджаас их буюу тухайн аймгийн нийт малчдын 25.2-49.5 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 15. БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛТОЙ МАЛЧИД, 2021 ОН, хувиар, аймаг, нийслэлээр




Дээд боловсролтой малчид 15.2 мянга байгаа нь нийт малчдын 5.0 хувийг эзэлж байна. Дээд боловсролтой малчдын дунд хүйсийн ялгаатай байдал ажиглагдахгүй байгаа ба 15-34 насны бүлэгт эрэгтэйчүүд бага зэрэг давамгайлсан байна.

ХҮСНЭГТ 18. ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ МАЛЧИД, 2021 ОН, хүйсээр

Насны бүлгээр	Бүгд	Дээд боловсролтой малчдад эзлэх хувь		Эрэгтэй	Эмэгтэй	
		Эрэгтэй	Эмэгтэй			
Бүгд	15 222	7 610	7 612	100.0	50.0	50.0
15-24	859	472	387	100.0	54.9	45.1
25-34	7 057	3 522	3 535	100.0	49.9	50.1
35-44	3 427	1 517	1 910	100.0	44.3	55.7
45-54	1 742	932	810	100.0	53.5	46.5
55-64	1 311	634	677	100.0	48.4	51.6
65 ↑	826	533	293	100.0	64.5	35.5

Дээд боловсролтой малчдыг аймгаар авч үзвэл, Хөвсгөл, Сэлэнгэ, Булган, Говьсүмбэр, Хэнтий, Дорнод, Төв, Орхон, Дархан-Уул аймгуудын болон Улаанбаатар хотын дээд боловсролтой малчид улсын дунджаас их буюу тухайн аймгийн нийт малчдын 5.1-10.5 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 16. ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ МАЛЧИД, 2021 ОН, хувиар, аймаг, нийслэлээр



III.5. Малчдын гэрлэлтийн байдал

Нийт малчдын 80.6 хувь (246.0 мянга) нь 2021 оны байдлаар гэрлэсэн үүний 93.2 хувь нь гэрлэлтээ батлуулсан, 6.8 хувь нь гэрлэлтээ батлуулаагүй байна. Малчдын 13.3 хувь нь (40.5 мянга) огт гэрлээгүй, 4.8 хувь нь (14.8 мянга) бэлэвсэн, 0.8 хувь нь (2.3 мянга) цуцалсан, 0.6 хувь нь (1.9 мянга) гэрлэлтээ тусгаарласан байна.


15-24 насны малчдын 71.6 хувь нь огт гэрлээгүй бол 65 ба түүнээс дээш насны малчдын 31.8 хувь нь бэлэвсэн байна.

ХҮСНЭГТ 19. МАЛЧДЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, 2021 он, насны бүлэг, гэрлэлтийн байдлаар

Насны бүлгээр	Бүгд	Огт гэрлээгүй	Гэрлэсэн батлуулсан	Гэрлэсэн батлуулаагүй	Тусгаарласан	Цуцалсан	Бэлэвсэн
Бүгд	305 430	40 495	229 214	16 813	1 861	2 294	14 753
15-24	20 606	14 748	4 557	1 264	12	15	10
25-34	64 839	14 154	43 456	6 568	202	220	239
35-44	87 668	5 920	74 860	4 448	510	738	1 192
45-54	74 897	3 428	63 862	3 008	665	830	3 104
55-64	39 170	1 624	31 099	1 248	375	415	4 409
65 ↑	18 250	621	11 380	277	97	76	5 799
Дүнд эзлэх хувь							
Бүгд	100.0	13.3	75.0	5.5	0.6	0.8	4.8
15-24	100.0	71.6	22.1	6.1	0.1	0.1	0.0
25-34	100.0	21.8	67.0	10.1	0.3	0.3	0.4
35-44	100.0	6.8	85.4	5.1	0.6	0.8	1.4
45-54	100.0	4.6	85.3	4.0	0.9	1.1	4.1
55-64	100.0	4.1	79.4	3.2	1.0	1.1	11.3
65 ↑	100.0	3.4	62.4	1.5	0.5	0.4	31.8

Огт гэрлээгүй 15-34 насны малчдын 85.4 хувь нь эрэгтэй 14.6 хувь нь эмэгтэй байна.

ЗУРАГ 17. МАЛЧДЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, 2021 он, насны бүлэг, гэрлэлтийн байдлаар




III.6. Малчдын нийгмийн даатгалын хамрагдалт

Үндэсний статистикийн хорооноос явуулдаг “Ажиллах хүчний судалгаа”-ны дүнгээр 2021 онд манай улсад нийт 1.1 сая ажиллагчид байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангийн мэдээллээс үзвэл, нийгмийн даатгалд даатгуулагчдын тоо 2021 онд 1019.1 мянга байгаагийн 862.1 (84.6%) мянга нь албан журмын даатгуулагчид, 157.0 (15.4%) мянга нь сайн дурын даатгуулагчид байна. Нийт даатгуулагчийн тоо өмнөх оноос 5.9 (0.6%) мянган хүнээр нэмэгджээ.

Мал тооллогын 2021 оны дүнгээр, нийт малчдын 35.2 хувь нь буюу 107.4 мянган малчин нийгмийн даатгалд хамрагдсан гэж бүртгэгдсэн нь өмнөх оноос 13.0 мянга буюу 13.8 хувиар өссөн байна.

Малчдын нийгмийн даатгалд хамрагдалтыг аймгаар авч үзвэл, Дорноговь, Баянхонгор, Дундговь, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Булган, Дархан-Уул, Говь-Алтай, Ховд, Говьсүмбэр аймгуудад нийт малчдын 36.2-48.1 хувь нь нийгмийн даатгалд хамрагдсан нь улсын дунджаас дээгүүр байна.

ЗУРАГ 18. МАЛЧДЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХАМРАГДАЛТ, 2021 ОН, хувиар, аймаг, нийслэлээр



Улсын хэмжээнд албан журмын нийгмийн даатгал төлдөг нийт ажиллагчдын 51.3 хувь нь эрэгтэй, 48.7 хувь нь эмэгтэй ажиллагчид байгаа бол нийгмийн даатгал төлдөг малчдын 55.5 хувь нь эрэгтэй, 44.5 хувь нь эмэгтэй байна.

ХҮСНЭГТ 20. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛДӨГ АЖИЛЛАГЧИД БОЛОН МАЛЧИД, 2021 ОН


	Бүгд	Хүйсээр			
		Эрэгтэй		Эмэгтэй	
		мянган хүн	%	мянган хүн	%
Нийт ажиллагчид*	1 125.6	592.8	52.7	532.8	47.3
Албан журмын нийгмийн даатгал төлдөг ажиллагчид**	862.1	442.6	51.3	419.5	48.7
Сайн дурын даатгуулагч**	157.0	56.0	35.7	101.0	64.3
Малчид	305.4	180.4	59.1	125.0	40.9
Нийгмийн даатгал төлдөг малчид	107.4	59.7	55.5	47.8	44.5

* Ажиллах хүчний судалгаа, Үндэсний статистикийн хороо

** Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар


Эрэгтэй малчдын 33.0 хувь, эмэгтэй малчдын 38.2 хувь нь нийгмийн даатгал төлж байна. Малчдын нийгмийн даатгалд хамрагдалт бага байгаа хэдий ч насны бүлгээр задлавал, нийгмийн даатгал төлдөг 45-54 насны малчдын 34.4 мянга буюу 32 хувь, 35-44 насны малчдын 31.5 мянга буюу 29.4 хувь, 25-34 насны малчдын 16.8 мянга буюу 15.7 хувь, 55-64 насны малчдын 14.9 мянга буюу 13.9 хувь, 65 ба түүнээс дээш насны малчдын 5.9 мянга буюу 5.5 хувь, 15-24 насны малчдын 3.6 мянга буюу 3.4 хувь тус тус байна.

ЗУРАГ 19. НИЙГМИЙН ДААТГАЛД ХАМРАГДДАГ МАЛЧДЫН ЭЗЛЭХ ХУВЬ, 2021 он, хүйсээр



Харин 15-24 насны залуу малчдын 82.4 хувь нь нийгмийн даатгалд хамрагддаггүй, дөнгөж 17.6 хувь нь нийгмийн даатгалд хамрагдаж байна. Хүйсээр задлан харахад 25-34 насны эмэгтэй малчдын 26.0 хувь, эрэгтэй малчдын 20.5 хувь, 35-44 насны эмэгтэй малчдын 36.7 хувь, эрэгтэй малчдын 29.4 хувь, 45-54 насны эмэгтэй малчдын 45.1 хувь, эрэгтэй малчдын 39.8 хувь нь нийгмийн даатгалд хамрагдсан байна.

ЗУРАГ 20. НИЙТ МАЛЧДАД НИЙГМИЙН ДААТГАЛД ХАМРАГДДАГ МАЛЧДЫН ЭЗЛЭХ ХУВЬ, 2021 ОН, насны бүлэг, хүйсээр




Нийгмийн даатгалд хамрагдсан малчдыг боловсролын түвшингээр авч үзэхэд, 2021 оны байдлаар боловсролын түвшин нэмэгдэх тусам нийгмийн даатгалд хамрагдалт нэмэгдэж байна.

Тухайлбал, боловсролгүй малчдын нийгмийн даатгалд хамрагдалт 26.1 хувь болж, өмнөх оноос 3.9 нэгж хувиар бага, боловсролтой малчид 29.1 хувь болж, өмнөх оноос 3.8 нэгж

хувиар, суурь боловсролтой малчид 35.7 хувь болж, өмнөх оноос 3.5 нэгж хувиар, бүрэн дунд боловсролтой малчид 37.4 хувь болж, өмнөх оноос 3.3 нэгж хувиар, техникийн болон тусгай мэргэжлийн боловсролтой малчид 39.2 хувь болж, өмнөх оноос 2.3 нэгж хувиар, дээд боловсролтой малчид 47.2 хувь болж, өмнөх оноос 3.6 нэгж хувиар тус тус өссөн байна.

ЗУРАГ 21. НИЙГМИЙН ДААТГАЛД ХАМРАГДАЛТ, хувиар, боловсролын түвшнээр




III.7. Малчдын эрүүл мэндийн даатгалын хамрагдалт

Нийт малчдын 59.4 хувь нь буюу 181.6 мянган малчин 2021 онд эрүүл мэндийн даатгалд хамрагдсан ба өмнөх онтой харьцуулахад 1.5 мянгаар буурсан байна.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг насны бүлгээр авч үзвэл, 15-24 насны малчдын 48.4 хувь нь буюу 10.0 мянган малчин, 25-34 насны малчдын 54.2 хувь нь буюу 35.2 мянган малчин, 35-44 насны малчдын 61.1 хувь нь буюу 53.6 мянган малчин, 45-54 насны малчдын 65.6 хувь нь буюу 49.1 мянган малчин, 55-64 насны малчдын 60 хувь нь буюу 23.5 мянган малчин, 65-аас дээш насны малчдын 55.9 хувь нь буюу 10.2 мянган малчин эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна.


ЗУРАГ 22. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛД ХАМРАГДАЛТ, 2021 ОН, хувиар, насны бүлгээр



Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан нийт малчдын 29.5 хувь нь 35-44 насны малчид, 27.1 хувь нь 45-54 насны малчид, 19.4 хувь нь 25-34 насны малчид, 12.9 хувь нь 55-64 насны малчид, 5.5 хувь нь 15-24 насны малчид, 5.6 хувь нь 65-аас дээш насны малчид байна. 25-54 насны малчдын дунджаар 25.3 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан нь бусад

насныхаас өндөр байна. Эрүүл мэндийн даатгалын хамрагдалт 15-24, 65-аас дээш насныханд бага байна.

ЗУРАГ 23. МАЛЧДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛД ХАМРАГДАЛТ, 2021 ОН, хувиар, аймаг, нийслэлээр



Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан малчдыг аймгаар авч үзвэл, Дархан-Уул, Дундговь, Увс, Дорноговь, Баянхонгор, Өмнөговь, Сүхбаатар, Булган, Өвөрхангай, Ховд, Говьсүмбэр, Говь-Алтай аймгуудын эрүүл мэндийн даатгалд хамрагдсан малчид улсын дунджаас их буюу тухайн аймгийн нийт малчдын 59.7-70.9 хувийг эзэлж байна.


III.8. Малчдын гар утас болон интернэтийн хэрэглээ

2020 онд 277.5 мянган малчин гар утас, 66.6 мянган малчин интернэт хэрэглэдэг байсан бол 2021 оны байдлаар нийт малчдын 94.6 хувь нь буюу 288.9 мянган малчин гар утас хэрэглэж байгаа нь өмнөх оноос 11.4 мянгаар өссөн бол нийт малчдын 42.1 хувь нь буюу 108.7 мянган малчин интернэт хэрэглэж байгаа нь өмнөх оноос 42.1 мянгаар өссөн байна.

ХҮСНЭГТ 21. МАЛЧДЫН ГАР УТАС БОЛОН ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭЭ, 2021 ОН, насны бүлгээр


Насны бүлгээр	Гар утас		Өөрчлөлт	Интернет		Өөрчлөлт
	2020	2021		2020	2021	
Бүгд	277 485	288 924	104.1	66 601	108 741	163.3
15-24	21 550	19 655	109.6	8 365	10 780	128.9
25-34	61 754	61 796	99.9	20 492	30 254	147.6
35-44	81 373	83 588	97.4	20 456	33 526	163.9
45-54	64 989	70 965	91.6	12 283	23 348	190.1
55-64	33 417	36 588	91.3	3 986	8 402	210.8
65 ↑	14 402	16 332	113.4	1 019	2 431	238.6

ЗУРАГ 24. МАЛЧДЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, 2021 ОН, насны бүлгээр




Гар утастай малчдыг насны бүлгээр авч үзвэл, 15-24 насны малчдын 95.4 хувь нь буюу 19.7 мянган малчин, 25-34 насны малчдын 95.3 хувь нь буюу 61.8 мянган малчин, 35-44 насны малчдын 95.3 хувь нь буюу 83.6 мянган малчин, 45-54 насны малчдын 94.8 хувь нь буюу 71.0 мянган малчин, 55-64 насны малчдын 93.4 хувь нь буюу 36.6 мянган малчин, 65-аас дээш насны малчдын 89.5 хувь нь буюу 16.3 мянган малчин гар утастай байна.

ЗУРАГ 25. НИЙТ МАЛЧДАД ГАР УТАСТАЙ МАЛЧДЫН ЭЗЛЭХ ХУВЬ, 2021 ОН, аймаг, нийслэлээр



Дорноговь, Булган, Ховд, Завхан, Баянхонгор, Увс, Дундговь, Өвөрхангай, Төв, Дорнод, Сэлэнгэ, Хэнтий, Говь-Алтай, Дархан-Уул, Орхон, Улаанбаатар хот, Өмнөговь, Говьсүмбэр аймгууд гар утас хэрэглэдэг малчдын эзлэх хувь 2021 онд 95.5-98.8 болж, улсын хэмжээний хэрэглээнээс их байна. Харин Баян-Өлгий, Сүхбаатар, Архангай, Хөвсгөл аймгуудад улсын хэмжээний дундаж хэрэглээнээс бага буюу 74.4-94.4 хувьтай байна.


ЗУРАГ 26. МАЛЧДЫН ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭЭ, 2021 ОН, хувиар, насны бүлгээр



Интернэт хэрэглэдэг малчдыг насны бүлгээр авч үзвэл, 15-24 насны малчдын 52.3 хувь нь буюу 10.8 мянган малчин, 25-34 насны малчдын 46.7 хувь нь буюу 30.3 мянган малчин, 35-44 насны малчдын 38.2 хувь нь буюу 33.5 мянган малчин, 45-54 насны малчдын 31.2 хувь нь буюу 23.3 мянган малчин, 55-64 насны малчдын 21.5 хувь нь буюу 8.4 мянган малчин, 65-аас дээш насны малчдын 13.3 хувь нь буюу 2.4 мянган малчин интернэт ашиглаж байна.

Интернэт хэрэглэдэг нийт малчдын 27.8 хувь нь 25-34 насных, 30.8 хувь нь 35-44 насных, 21.5 хувь нь 45-54 насных, 9.9 хувь нь 15-24 насных, 7.7 хувь нь 55-64 насных, 2.2 хувь нь 65 ба түүнээс дээш насны малчид байна.

ЗУРАГ 27. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭДЭГ МАЛЧИД, 2021 он, хувиар, аймаг, нийслэлээр



Малчдын интернэтийн хэрэглээг аймгаар авч үзвэл, Өвөрхангай, Говь-Алтай, Баянхонгор, Дархан-Уул, Булган, Дундговь, Хэнтий, Ховд, Улаанбаатар хот, Дорноговь, Төв, Орхон, Өмнөговь, Дорнод, Сэлэнгэ аймгууд малчдын интернэт хэрэглэдэг хувь малчдын дундаж хэрэглээнээс өндөр буюу нийт малчдын 36.3-49.1 хувь нь хэрэглэдэг байна.

III.9. Зээлтэй малчид


Нийт малчдын 39.4 хувь нь буюу 120.4 мянган малчин 2021 оны байдлаар зээлтэй ба өмнөх онтой харьцуулахад 4.5 мянгаар буурсан байна. Зээлтэй малчдын тоог насны бүлгээр нь өмнөх онтой харьцуулбал 45-64 нас, 65 ба түүнээс дээш насны бүлэгт 0.1 мянгаар өссөн бол 15-44 насны бүлгүүдэд 0.1-1.7 мянгаар буурсан байна.

ХҮСНЭГТ 22. ЗЭЭЛТЭЙ МАЛЧИД, 2021 ОН, ХУВИАР, НАСНЫ БҮЛГЭЭР

Насны бүлэг	Нийт малчид	Зээлтэй малчин		Зээлтэй малчдын нийт малчдад эзлэх хувь	Зээлтэй малчдын насны бүтэц, хувиар
		2020	2021		
Бүгд	305 430	124 896	120 402	39.4	100.0
15-24	20 606	4 797	3 780	18.3	3.1
25-34	64 839	27 222	24 938	38.5	20.7
35-44	87 668	40 581	38 924	44.4	32.3
45-54	74 897	32 719	32 832	43.8	27.3
55-64	39 170	15 173	15 393	39.3	12.8
65 ↑	18 250	4 404	4 535	24.8	3.8

Зээлтэй малчдыг насны бүлгээр авч үзвэл, 15-24 насны малчдын 18.3 хувь нь буюу 3.7 мянган малчин, 25-34 насны малчдын 38.5 хувь нь буюу 24.9 мянган малчин, 35-44 насны малчдын 44.4 хувь нь буюу 38.9 мянган малчин, 45-54 насны малчдын 43.8 хувь нь буюу 32.8 мянган малчин, 55-64 насны малчдын 39.3 хувь нь буюу 15.3 мянган малчин, 65-аас дээш насны малчдын 24.8 хувь нь буюу 4.5 мянган малчин зээлтэй байна.

ЗУРАГ 28. МАЛЧДАД ЗЭЭЛТЭЙ МАЛЧДЫН ЭЗЛЭХ ХУВЬ, 2021 ОН, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР



Малчдын зээл авсан байдлыг аймгаар авч үзвэл, Дорнод, Хөвсгөл, Увс, Сэлэнгэ, Хэнтий, Булган, Төв, Дорноговь, Баянхонгор, Дундговь, Говьсүмбэр зэрэг аймгийн малчдын 40.0-58.9 хувь нь зээлтэй байна.

III.10. Хоршоо, нөхөрлөлийн гишүүн малчид

2021 оны байдлаар давхардсан тоогоор малчдын 47.5 хувь нь буюу 145.0 мянган малчин хоршоо, нөхөрлөл, малчдын бүлгийн гишүүн байна. Үүнээс, 23.0 хувь нь буюу 70.2 мянган малчин хоршооны гишүүн, 7.6 хувь нь буюу 23.1 мянган малчин нөхөрлөлийн гишүүн, 14.5 хувь нь буюу 44.4 мянган малчин малчдын бүлгийн гишүүн, 2.4 хувь нь буюу 7.4 мянган малчин нь бусад бүлгийн гишүүн байна.

Хоршоо, нөхөрлөл, малчдын болон бусад бүлгийн гишүүн малчдыг насны бүлгээр авч үзвэл, 15-24 насны малчдын 35.2 хувь нь буюу 7.3 мянган малчин, 25-34 насны малчдын 42.6 хувь нь буюу 27.6 мянган малчин, 35-44 насны малчдын 49.7 хувь нь буюу 43.6 мянган малчин, 45-54 насны малчдын 51.3 хувь нь буюу 38.4 мянган малчин, 55-64 насны малчдын 49.8 хувь нь буюу 19.5 мянган малчин, 65-аас дээш насны малчдын 47.2 хувь нь буюу 8.6 мянган малчин хоршоо, нөхөрлөл, малчдын бүлэг болон бусад ямар нэг бүлгийн гишүүн байна.


Хоршоо, нөхөрлөл, малчдын бүлэг болон бусад байгууллагын гишүүн малчдын 48.2 хувь нь 25-54 насныхан байна. Тухайлбал, 19.2 хувь нь 35-44 насных, 16.9 хувь нь 45-54 насных, 12.1 хувь нь 25-34 насны малчид байна.

ХҮСНЭГТ 23. ХОРШОО, НӨХӨРЛӨЛ, МАЛЧДЫН БҮЛЭГ, БУСАД БАЙГУУЛЛАГЫН ГИШҮҮН МАЛЧИД, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2021 ОН, ДАВХАРДСАН ТООГООР

Насны бүлэг	Малчид	Хоршооны гишүүн	Нөхөрлөлийн гишүүн	Малчдын бүлгийн гишүүн	Бусад	Малчдад эзлэх хувь			
						Хоршооны гишүүн	Нөхөрлөлийн гишүүн	Малчдын бүлгийн гишүүн	Бусад
Бүгд	305 430	70 179	2 3065	44 360	7 442	23.0	7.6	14.5	2.4
15-24	20 606	3 162	1 205	2 499	392	15.3	5.8	12.1	1.9
25-34	64 839	12 708	4 427	8 991	1 493	19.6	6.8	13.9	2.3
35-44	87 668	21 132	6 948	13 287	2 232	24.1	7.9	15.2	2.5
45-54	74 897	19 013	6 168	11 301	1 950	25.4	8.2	15.1	2.6
55-64	39 170	9 644	3 062	5 838	979	24.6	7.8	14.9	2.5
65 ↑	18 250	4 520	1 255	2 444	396	24.8	6.9	13.4	2.2

Хоршоо, нөхөрлөл, малчдын бүлгийн гишүүн малчдыг (давхардсан тоогоор) аймгаар авч үзвэл, Улаанбаатар хот болон, Орхон, Сүхбаатар, Сэлэнгэ, Баян-Өлгий, Дархан-Уул, Булган, Дорнод, Ховд, Архангай, Өвөрхангай, Увс, Баянхонгор, Говь-Алтай, Хөвсгөл, Дорноговь, Дундговь аймгийн малчид бусад аймагтай харьцуулахад хоршоо, нөхөрлөл, малчдын бүлгийн гишүүн байх нь бага буюу тус аймгийн нийт малчдын 9.9-52.6 хувь нь гишүүн байна.

ЗУРАГ 29. ХОРШОО, НӨХӨРЛӨЛ, МАЛЧДЫН БҮЛГИЙН ГИШҮҮН МАЛЧДЫН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2021 ОН, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, ДАВХАРДСАН ТООГООР



III.11. Малчин өрхийн хүүхдүүдийн цэцэрлэг, сургуульд хамрагдсан байдал

Малчин өрхөд 2021 оны байдлаар 6-гаас доош насны 69.7 мянган хүүхэд байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0.6 мянгаар буурсан байна. 6-18 насны 164.1 мянган хүүхэд байгаа нь өмнөх онтой харьцуулбал 7.7 мянгаар өссөн байна.

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан 10.5 мянган хүүхэд байгаа нь өмнөх оноос 9.3 мянгаар буурсан, ерөнхий боловсролын сургуульд хамрагддаг 125.4 мянган хүүхдийг өмнөх онтой харьцуулахад 2.3 мянгаар буурсан ба их дээд сургуульд хамрагдсан хүүхдийн тоо 19.8 мянга байгаа нь өмнөх оноос 614-өөр өссөн байна.

ХҮСНЭГТ 24. МАЛЧИН ӨРХИЙН ХҮҮХДҮҮДИЙН ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛЬД ХАМРАГДСАН БАЙДАЛ, 2021 ОН

	6-аас доош насны нийт хүүхэд	Сургуулийн өмнөх боловсролд хамрагддаг хүүхэд		6-18 насны нийт хүүхэд	Ерөнхий боловсролын сургуульд хамрагддаг хүүхэд	Их дээд сургуульд хамрагддаг хүүхэд
		Сургуулийн өмнөх боловсролд хамрагддаг хүүхэд	Сургуулийн өмнөх боловсролд хамрагддаг хүүхэд			
2019	58 616	28 478	164 259	139 897	29 269	
2020	70 316	19 786	156 398	127 680	19 215	
2021	69 685	10 511	164 144	125 353	19829	
Өөрчлөлт	(631)	(9 275)	7 746	(2 327)	614	

Малчин өрхөд байгаа 6-аас доош насны 69.7 мянган хүүхдийн 10.5 мянган хүүхэд буюу 15.1 хувь нь сургуулийн өмнөх боловсрол буюу цэцэрлэгт хамрагдсан байна.

Малчин өрхийн хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдаж буй байдлыг аймгаар авч үзвэл, Баянхонгор, Орхон, Өвөрхангай, Говь-сүмбэр, Дорноговь, Сэлэнгэ, Төв, Сүхбаатар, Хэнтий Увс аймгууд болон Улаанбаатар хотод улсын дунджаас дээгүүр 15.3-26.4 хувь байна. Бусад аймагт улсын дунджаас доогуур 6.8-14.9 хувь байна.

ХҮСНЭГТ 25. МАЛЧИН ӨРХИЙН ХҮҮХДҮҮДИЙН ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛИЙН ХАМРАГДАЛТ, 2021 ОН, бүс, аймаг, нийслэлээр

Бүс, аймаг, нийслэл	6-аас доош насны нийт хүүхэд	Сургуулийн өмнөх боловсролд хамрагддаг хүүхэд		6-18 насны нийт хүүхэд	Ерөнхий боловсролын сургуульд хамрагддаг хүүхэд	Их, дээд сургуульд хамрагддаг хүүхэд
		Сургуулийн өмнөх боловсролд хамрагддаг хүүхэд	Сургуулийн өмнөх боловсролд хамрагддаг хүүхэд			
Бүгд	69 685	10 511	164 144	125 353	19 829	
Баруун бүс	21 247	2 577	50 697	37 680	5 185	
Баян-Өлгий	5 716	852	13 080	9 620	846	
Говь-Алтай	3 040	329	7 150	5 375	772	
Завхан	3 302	335	8 562	6 364	1 216	
Увс	5 105	783	11 559	8 790	1 021	
Ховд	4 084	278	10 346	7 531	1 330	
Хангайн бүс	26 974	4 138	64 903	49 194	8 186	
Архангай	5 816	807	14 175	11 438	2 207	
Баянхонгор	5 243	967	11 255	8 273	1 020	
Булган	2 792	343	7 337	5 403	1 182	
Орхон	6 009	1 067	14 459	10 958	1 902	
Өвөрхангай	216	45	616	500	93	
Хөвсгөл	6 898	909	17 061	12 622	1 782	
Төвийн бүс	12 125	1 844	28 494	22 330	3 899	
Говьсүмбэр	270	69	675	491	86	
Дархан-Уул	323	30	938	722	142	
Дорноговь	1 369	218	3 228	2 481	376	
Дундговь	2 619	318	5 473	4 264	902	
Өмнөговь	1 915	181	4 347	3 160	673	
Сэлэнгэ	1 859	298	4 765	3 618	648	
Төв	3 770	730	9 068	7 594	1 072	
Зүүн бүс	8 815	1 855	18 324	14 839	2 324	
Дорнод	2 262	313	4 555	3 489	596	
Сүхбаатар	3 582	944	7 145	6 329	949	
Хэнтий	2 971	598	6 624	5 021	779	
Улаанбаатар	524	97	1 726	1 310	235	

Эх үүсвэр: Хүн ам, өрхийн мэдээллийн сан

Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн 2021 оны тооллого

Малчин өрхөд 2021 оны 6-18 насны 164.1 мянган хүүхэд байгаагийн 125.3 мянган хүүхэд буюу 76 хувь нь ерөнхий боловсролын сургуульд хамрагдаж байна.

Малчин өрхийн хүүхдүүдийн ерөнхий боловсролд хамрагдалтыг аймгаар авч үзвэл, Дорноговь, Дархан-уул, Дундговь, Архангай, Өвөрхангай, Төв, Сүхбаатар аймгуудад улсын дунджаас их буюу 76.9-88.6 хувь байна.

Малчин өрхөд их, дээд сургуульд хамрагддаг 19.8 мянган хүүхэд байгаагийн 2.2 мянга буюу 11.1 хувь нь Архангай, 1.9 мянга буюу 9.5 хувь нь Өвөрхангай, 1.7 мянга буюу 8.9 хувь нь Хөвсгөл, 1.3 мянга буюу 6.7 хувь нь Ховд, 1.2 мянга буюу 6.1 хувь нь Завхан, 1.1 мянга буюу 5.9 хувь нь Булган аймагт байна.

III.12. Малчин өрх дэх хөгжлийн бэрхшээлтэй иргэд

Малчин өрхөд 2021 оны байдлаар 25.9 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэд амьдарч байгаа ба өмнөх онтой харьцуулахад 483 хүнээр өссөн байна.

ХҮСНЭГТ 26. МАЛЧИН ӨРХИЙН АМ БҮЛ ДЭХ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр

	Хөгжлийн бэрхшээлтэй	Хөдөлгөөний	Сэтгэцийн	Харааны	Сонсголын	Ярианы	Хавсарсан	Бусад
2019	26 652	6 265	5 500	3 488	2 257	1 011	1 610	6 532
2020	25 472	5 931	5 161	3 352	2 148	982	1 529	6 369
2021	25 955	5 949	5 329	3 398	2 166	1 006	1 540	6 607
Өөрчлөлт	483	18	168	46	18	24	11	238

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 5.9 мянга буюу 22.9 хувь нь хөдөлгөөний, 5.3 мянга буюу 20.5 хувь нь сэтгэцийн, 3.4 мянга буюу 13.1 хувь нь харааны, 2.2 мянга буюу 8.3 хувь нь сонсголын, 1.0 мянга буюу 3.9 хувь нь ярианы, 1.5 мянга буюу 5.9 хувь нь хавсарсан хэлбэрийн, 6.6 мянга буюу 25.5 хувь нь бусад хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй байна.

ХҮСНЭГТ 27. МАЛЧИН ӨРХИЙН АМ БҮЛ ДЭХ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД, 2021 ОН, бүс, аймаг, нийслэлээр, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр

Бүс, аймаг, нийслэл	Хөгжлийн бэрхшээлтэй	Хөдөлгөөний	Сэтгэцийн	Харааны	Сонсголын	Ярианы	Хавсарсан	Бусад
Бүгд	25 995	5 949	5 329	3 398	2 166	1 006	1 540	6 607
Баруун бүс	8 419	1 833	1 521	955	595	351	532	2 632
Баян-Өлгий	2 074	532	269	153	99	85	169	767
Говь-Алтай	1 489	299	261	194	111	56	81	487
Завхан	1 945	420	427	168	169	81	76	604
Увс	1 945	320	358	324	139	81	144	579
Ховд	966	262	206	116	77	48	62	195
Хангайн бүс	9 510	2 337	1 928	1 335	887	373	675	1 975
Архангай	1 885	526	395	239	208	86	124	307
Баянхонгор	1 846	437	418	241	151	64	129	406
Булган	872	215	192	149	83	26	47	160
Орхон	161	37	46	20	10	3	7	38
Өвөрхангай	1 938	499	357	271	169	92	87	463
Хөвсгөл	2 808	623	520	415	266	102	281	601
Төвийн бүс	4 572	1 048	1 119	584	355	151	178	1 137
Говьсүмбэр	100	25	21	10	18	3	2	21
Дархан-Уул	208	25	45	26	21	7	2	82
Дорноговь	694	184	167	75	49	28	37	154
Дундговь	894	211	211	117	68	31	41	215
Өмнөговь	703	167	157	96	58	15	26	184

Бүс, аймаг, нийслэл	Хөгжлийн бэрхшээлтэй	Хөдөлгөө- ний	Сэтгэцийн	Харааны	Сонсго- лын	Ярианы	Хавсарсан	Бусад
Сэлэнгэ	703	129	185	84	49	25	19	212
Төв	1 270	307	333	176	92	42	51	269
Зүүн бүс	3 179	666	681	488	302	125	122	795
Дорнод	1 069	231	235	158	107	38	49	251
Сүхбаатар	1 152	212	235	180	111	49	38	327
Хэнтий	958	223	211	150	84	38	35	217
Улаанбаатар	315	65	80	36	27	6	33	68


Эх үүсвэр: Хүн ам, өрхийн мэдээллийн сан

Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн 2021 оны тооллого


Малчин өрхөд 16-аас доош насны хөгжлийн бэрхшээлтэй 2.1 мянган хүүхэд байна. Энэ нь малчин өрхөд амьдардаг нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 8.3 хувийг эзэлж байна. Эдгээр хүүхдүүдийн 24.7 хувь нь хөдөлгөөний, 19.7 хувь нь сэтгэцийн, 11.7 хувь нь харааны, 9.4 хувь нь хавсарсан, 8.6 хувь нь ярианы, 4.8 хувь нь сонсголын, 21.0 хувь нь бусад хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй байна.




СҮРГИЙН БҮТЭЦ



МАЛЫН ТОО, сая толгой



100 ЭХЭЭС БОЙЖУУЛСАН ТӨЛ



IV. МАЛЫН ТОО

IV.1. Мал, тэжээвэр амьтдын тоо, сүргийн бүтэц

Мал тооллогын 2021 оны жилийн эцсийн дүнгээр малын тоо толгой 67.3 сая болж, өмнөх оноос 275.3 мянган толгойгоор буюу 0.4 хувиар өссөн бөгөөд төрлөөр нь авч үзвэл, адуу 4.3 сая, үхэр 5 сая, тэмээ 454 мянга, хонь 31.1 сая, ямаа 26.5 сая толгой тоологдлоо.


Малын тооны өөрчлөлтийг төрлөөр авч үзвэл, 2021 онд хонь 1.0 (3.5%) сая, адуу 230.6 (5.6%) мянга, үхэр 290.2 (6.1%) мянган толгойгоор тус тус өсөж, тэмээ 18.9 (4.0%) мянган, ямаа 1.3 (4.6%) сая толгойгоор тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 28. МАЛЫН ТОО, төрлөөр

Он	Бүгд					
	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	
мянган толгой						
1930	23 676.2	1 566.9	1 887.3	480.9	15 660.3	4 080.8
1940	26 204.8	2 358.1	2 722.8	643.4	15 384.2	5 096.3
1950	22 702.2	2 317.0	1 987.8	844.2	12 574.6	4 978.6
1960	23 000.5	2 502.7	1 905.5	859.1	12 101.9	5 631.3
1970	22 574.9	2 317.9	2 107.8	633.5	13 311.7	4 204.0
1980	23 771.4	1 985.4	2 397.1	591.5	14 230.7	4 566.7
1990	25 856.9	2 262.0	2 848.7	537.5	15 083.0	5 125.7
2000	30 227.5	2 660.8	3 097.6	322.9	13 876.3	10 269.8
2010	32 729.5	1 920.3	2 176.0	269.6	14 480.4	13 883.2
2011	36 335.8	2 112.9	2 339.7	280.1	15 668.5	15 934.6
2012	40 920.9	2 330.4	2 584.6	305.8	18 141.4	17 558.7
2013	45 144.3	2 619.4	2 909.5	321.5	20 066.4	19 227.6
2014	51 982.6	2 995.8	3 413.9	349.3	23 214.8	22 008.9
2015	55 979.8	3 295.3	3 780.4	368.0	24 943.1	23 592.9
2016	61 549.2	3 635.5	4 080.9	401.3	27 856.6	25 574.9
2017	66 219.0	3 939.8	4 388.5	434.1	30 109.9	27 346.7
2018	66 460.2	3 940.1	4 380.9	459.7	30 554.8	27 124.7
2019	70 969.3	4 214.8	4 753.2	472.4	32 267.3	29 261.7
2020	67 068.5	4 093.9	4 732.0	472.9	30 049.4	27 720.3
2021	67 343.8	4 324.4	5 022.2	454.0	31 087.0	26 456.1

Нийт 901.3 мянган сарлаг 2021 онд тоологдсон нь нийт үхэр сүргийн 17.9 хувийг эзэлж байна. Сарлагийн тоо өмнөх оноос 0.4 хувь буюу 400 толгойгоор буурсан байна.

ЗУРАГ 30. САРЛАГИЙН ТОО, мянган толгой



Малын тоо 2021 онд Орхон, Сэлэнгэ, Завхан, Баян-Өлгий, Дорноговь, Архангай Булган, Хэнтий, Дорнод, Ховд, Сүхбаатар, Увс, Хөвсгөл аймгуудад 17.6-442.6 мянгаар өссөн бол Дархан-Уул, Говьсүмбэр, Улаанбаатар, Төв, Говь-Алтай, Өмнөговь, Өвөрхангай, Дундговь, Баянхонгор аймгуудын малын тоо 5.3-712.8 мянгаар буурсан байна.

ХҮСНЭГТ 29. МАЛЫН ТОО, бүс, аймаг, нийслэлээр, малын төрлөөр

Бүс, аймаг, нийслэл	2020	2021	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
	мянган толгой						
Бүгд	67 068.5	67 343.8	4 324.4	5 022.2	454.0	31 087.0	26 456.1
Баруун бүс	15 845.2	16 448.0	785.3	950.0	111.9	6 885.7	7 715.2
Баян-Өлгий	2 224.7	2 379.0	113.4	181.9	5.9	1 014.0	1 063.8
Говь-Алтай	3 310.8	2 990.5	115.5	69.6	43.7	886.0	1 875.8
Завхан	3 607.8	3 755.2	252.7	245.2	8.3	1 919.5	1 329.5
Увс	3 409.3	3 726.4	157.1	245.7	26.4	1 798.4	1 498.9
Ховд	3 292.6	3 597.0	146.6	207.6	27.6	1 267.8	1 947.3
Хангайн бүс	22 752.4	22 432.0	1 429.6	2 033.9	70.1	10 749.5	8 149.0
Архангай	5 399.9	5 562.2	416.3	722.2	1.7	2 935.1	1 487.0
Баянхонгор	3 839.9	3 127.1	136.6	197.9	45.5	951.8	1 795.3
Булган	3 396.0	3 622.3	285.7	293.7	1.5	1 918.9	1 122.5
Орхон	137.0	154.6	15.7	24.3	0.1	59.6	54.9
Өвөрхангай	4 479.1	4 022.7	269.6	239.7	19.0	2 000.9	1 493.5
Хөвсгөл	5 500.6	5 943.2	305.6	556.1	2.4	2 883.2	2 195.9
Төвийн бүс	16 691.0	15 811.4	967.7	885.3	253.6	7 087.0	6 617.7
Говьсүмбэр	451.0	432.2	24.3	17.8	1.1	219.4	169.6
Дархан-Уул	360.6	355.3	22.1	50.9	0.1	163.8	118.4
Дорноговь	2 551.5	2 706.8	183.8	118.1	48.3	1 158.5	1 198.1
Дундговь	3 741.1	3 170.5	158.7	65.7	39.4	1 533.4	1 373.3
Өмнөговь	2 880.8	2 513.8	102.0	31.3	160.6	626.7	1 593.2
Сэлэнгэ	1 818.5	1 886.7	119.9	281.6	0.5	849.7	635.0
Төв	4 887.5	4 746.0	356.8	320.0	3.7	2 535.5	1 530.1
Зүүн бүс	11 311.2	12 209.0	1 079.9	1 068.5	18.4	6 195.7	3 846.5
Дорнод	2 749.7	3 051.1	368.5	353.2	6.5	1 470.2	852.7
Сүхбаатар	3 893.6	4 202.9	364.6	308.2	7.7	2 179.0	1 343.4
Хэнтий	4 667.9	4 955.0	346.8	407.1	4.1	2 546.5	1 650.4
Улаанбаатар	468.7	443.3	62.0	84.5	0.1	169.0	127.7

Малын тоог төрлөөр нь 2020 онтой харьцуулан авч үзэхэд (Хавсралт хүснэгт 8):

Адууны тоо Дундговь, Төв, Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор аймгуудад хамгийн ихээр буюу 7.7-26.6 мянгаар буурч, Архангай, Булган, Сүхбаатар, Хөвсгөл, Дорнод аймгууд 28.6-44.1 мянгаар өссөн байна.

Үхрийн тоо Улаанбаатар, Говь-Алтай, Дундговь, Өвөрхангай, Баянхонгор аймгуудад хамгийн ихээр буюу 5.0-47.8 мянгаар буурч, Хэнтий, Увс, Архангай, Дорнод, Хөвсгөл аймгуудад 32.4-55.0 мянгаар өссөн байна.


Тэмээний тоо Говь-Алтай, Дундговь, Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор аймгуудад хамгийн ихээр буюу 0.2-10.0 мянгаар буурч, Архангай, Баян-Өлгий, Увс, Ховд, Дорноговь аймгуудад 0.4-3.0 мянгаар өссөн байна.

Хонины тоогоор Өмнөговь, Говь-Алтай, Өвөрхангай, Баянхонгор, Дундговь аймгууд хамгийн ихээр буюу 55.9-257.8 мянгаар буурч, Дорнод, Увс, Сүхбаатар, Хэнтий, Хөвсгөл аймгууд 167.1-260.4 мянгаар өссөн байна.

Ямааны тоогоор Говь-Алтай, Дундговь, Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор аймгууд хамгийн ихээр буюу 247.4-423.9 мянгаар буурч, Дорнод, Сүхбаатар, Увс, Хөвсгөл, Ховд аймгууд 41.8-125.3 мянгаар өссөн байна.

Улсын хэмжээнд нийт малын тоогоор 500.0 мянгаас дээш малтай сумдад Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Хэнтий аймгийн Хэрлэн, Өмнөдэлгэр сумдууд орж байна. 400.0-500.0 мянга хүртэл толгой малтай сумдад Архангай аймгийн Батцэнгэл, Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Хэнтий аймгийн Баянхутаг, Батноров, Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Дундговь аймгийн Эрдэнэдалай, Сүхбаатар аймгийн Мөнххаан, Баруун-Урт, Архангай аймгийн Эрдэнэмандал, Хөвсгөл аймгийн Цагаан-Уул, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, сумууд багтаж байна.

ЗУРАГ 31. МАЛЫН ТОО, 2021 он, аймаг, нийслэлээр



Харин 50.0 мянгаас бага малтай 11 сум, дүүрэг байгаагаас хамгийн бага малтай сумдад Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум 22.4, Улаанбаатар хотын Багахангай дүүрэг 25.7, Сэлэнгэ аймгийн Шаамар сум 26.0, Хөвсгөл аймгийн Цагаан-нуур сум 27.8, Цагаан-Үүр сум 32.4, Сэлэнгэ аймгийн Хүдэр сум 35.8, Дархан-Уул аймгийн Дархан сум 36.0, Шарын гол сум 39.0, Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг 42.9, Баян-Өлгий аймгийн Өлгий сум 44.9, Говьсүмбэр аймгийн Шивээговь сум 49.0 мянган малтай байна.

Малын тоог бодод шилжүүлснээр 2021 онд 18.5 сая болж өмнөх оноос 507.4 мянган малаар өссөн байна. Говь-Алтай, Өмнөговь, Өвөрхангай, Дундговь, Баянхонгор аймгуудад бодод шилжүүлсэн малын тоо 54.2-176.5 мянгаар буурсан байхад Увс, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Хөвсгөл аймгуудад 93.6-144.3 мянгаар өссөн байна.

IV.2. Малын тоогоор 2021 онд тэргүүлсэн аймаг

Нийт малын тоогоор Хөвсгөл аймаг 5.9 сая мал тоолуулж улсдаа тэргүүллээ. Адууны тоогоор Архангай аймаг 416.3 мянган адуу, үхрийн тоогоор Архангай аймаг 722.2 мянган үхэр, тэмээний тоогоор Өмнөговь аймаг 160.6 мянган тэмээ, хонины тоогоор Архангай

аймаг 2.9 сая хонь, ямааны тоогоор Хөвсгөл аймаг 2.2 сая ямаа тус тус тоолуулж улсдаа тэргүүлээ.


ЗУРАГ 32. МАЛЫН ТООГООР 2021 ОНД ТЭРГҮҮЛСЭН АЙМАГ, малын төрлөөр



IV.3. Малын тоогоор тэргүүлсэн сумд

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум 661.8 мянган толгой мал тоолуулж улсдаа тэргүүлсэн бол Хэнтий аймгийн Хэрлэн сум 529.2 мянган толгой, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сум 523.1 мянган толгой, Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сум 494.1 мянган толгой, Архангай аймгийн Эрдэнэмандал сум 485.5 мянган толгой мал тоолуулж эхний 5 байрт орлоо.


ЗУРАГ 33. НИЙТ МАЛЫН ТООГООР 2021 ОНД ТЭРГҮҮЛСЭН 5 СУМ



IV.3.1. Адууны тоогоор тэргүүлсэн 5 сум

Хамгийн олон адуутай 5 сумдыг дурдвал, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум 50.5 мянга, Баруун-Урт сум 46.5 мянга, Сүхбаатар сум 43.8 мянга, Дорнод аймгийн Матад сум 43.2 мянга, Сүхбаатар аймгийн Мөнххаан сум 40.1 мянган адуу тоолуулж, тэргүүлжээ.


ЗУРАГ 34. АДУУНЫ ТОО, 2021 ОН, НИЙСЛЭЛ, АЙМАГ, СУМ, ДҮҮРГЭЭР



IV.3.2. Үхрийн тоогоор тэргүүлсэн 5 сум

Архангай аймгийн Өндөр-Улаан сум 72.1 мянга, Их тамир сум 68.5 мянга, Чулуут сум 65.2 мянга, Цэнхэр сум 63.3 мянга, Тариат сум 58.3 мянган үхэр тоолуулж, тэргүүлжээ.


ЗУРАГ 35. ҮХРИЙН ТОО, 2021 ОН, НИЙСЛЭЛ, АЙМАГ, СУМ, ДҮҮРГЭЭР



IV.3.3. Тэмээний тоогоор тэргүүлсэн 5 сум

Өмнөговь аймгийн Ханбогд сум 33.1 мянга, Мандал-Овоо сум 21.3 мянга, Баянхонгор аймгийн Баянлиг сум 17.4 мянга, Өмнөговь аймгийн Манлай сум 16.2 мянга, Дундговь аймгийн Өлзийт сум 14.6 мянган тэмээ тоолуулж, тэргүүлжээ.


ЗУРАГ 36. ТЭМЭЭНИЙ ТОО, 2021 ОН, НИЙСЛЭЛ, АЙМАГ, СУМ, ДҮҮРГЭЭР



IV.3.4. Хонины тоогоор тэргүүлсэн 5 сум

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум 335.2 мянга, Архангай аймгийн Эрдэнэмандал сум 313.9 мянга, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сум 286.4 мянга, Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сум 281.4 мянга, Хэнтий аймгийн Хэрлэн сум 276.8 мянган хонь тоолуулж, тэргүүлжээ.


ЗУРАГ 37. ХОНИНЫ ТОО, 2021 ОН, НИЙСЛЭЛ, АЙМАГ, СУМ, ДҮҮРГЭЭР



IV.3.5. Ямааны тоогоор тэргүүлсэн 5 сум

Хамгийн олон ямаа тоолуулсан 5 сумдад, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум 246.4 мянга, Өмнөговь аймгийн Номгон сум 218.6 мянга, Ховд аймгийн Булган сум 192.9 мянга, Дундговь аймгийн Эрдэнэдалай сум 191.1 мянга, Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сум 188.1 мянган ямаа тоолуулж, тэргүүлжээ.

ЗУРАГ 38. ЯМААНЫ ТОО, 2021 ОН, НИЙСЛЭЛ, АЙМАГ, СУМ, ДҮҮРГЭЭР



IV.4. Өрхийн аж ахуйн болон аж ахуйн нэгж, байгууллагын малын тоо

Улсын хэмжээнд 2021 онд тоологдсон нийт малын 99.5 хувь нь буюу 67.0 сая мал нь өрхийн аж ахуй, 0.5 хувь нь буюу 352.7 мянган толгой нь аж ахуйн нэгж, байгууллагынх байна.

Өрхийн аж ахуйн буюу хувийн малын тоо 2021 онд 67.0 сая толгой болж, өмнөх оноос 281.5 мянган толгой буюу 0.4 хувиар өссөн. Адууны 99.4 хувь, үхрийн 99.0 хувь, тэмээний 99.4 хувь, хонины 99.4 хувь, ямааны 99.7 хувь нь өрхийн аж ахуйд байна. Өрхийн аж ахуйн нийт малын 46.1 хувийг хонь, 39.4 хувийг ямаа, 7.4 хувийг үхэр, 6.4 хувийг адуу, 0.7 хувийг тэмээ эзэлж байна.

ХҮСНЭГТ 30. ӨРХИЙН АЖ АХУЙН БУЮУ ХУВИЙН МАЛЫН ТОО, малын төрлөөр

Төрөл	2017	2018	2019	2020	2021
	мянган толгой				
Бүгд	65 857.4	66 107.1	70 583.6	66 709.6	66 991.1
Адуу	3 916.9	3 916.2	4 190.5	4 068.5	4 298.8
Үхэр	4 351.4	4 340.0	4 710.7	4 688.2	4 974.0
Тэмээ	431.3	456.7	469.5	469.9	451.1
Хонь	29 906.0	30 358.6	32 047.1	29 850.8	30 892.2
Ямаа	27 251.8	27 035.6	29 165.8	27 632.2	26 374.9

Аж ахуйн нэгж, байгууллагын малын тоо 2021 онд 352.7 мянган толгой болж, өмнөх оноос 6.2 мянган толгой буюу 1.7 хувиар буурчээ. Адууны 0.6 хувь, үхрийн 1.0 хувь, тэмээний 0.6 хувь, хонины 0.6 хувь, ямааны 0.3 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагад байна. Аж ахуйн нэгж, байгууллагын нийт малын 55.2 хувийг хонь, 23.0 хувийг ямаа, 13.7 хувийг үхэр, 7.3 хувийг адуу, 0.8 хувийг тэмээ эзэлж байна.

ХҮСНЭГТ 31. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН МАЛЫН ТОО, төрлөөр

Төрөл	2017	2018	2019	2020	2021
	мянган толгой				
Бүгд	361.6	353.0	385.7	358.9	352.7
Адуу	22.9	23.9	24.3	25.4	25.7
Үхэр	37.0	40.9	42.5	43.8	48.2
Тэмээ	2.8	3.0	2.9	3.0	2.9
Хонь	203.9	196.2	220.1	198.6	194.8
Ямаа	95.0	89.1	95.9	88.0	81.2

IV.5. Малтай өрхийн бүлэглэлт

Малтай 246.3 мянган өрхийг 2021 оны байдлаар малын тоогоор нь бүлэглэвэл, 11 хүртэлх малтай 13.3 мянган өрх буюу нийт малтай өрхийн 5.4 хувь, 11-30 малтай 22.4 мянган өрх буюу 9.1 хувь, 31-50 малтай 18.0 мянган өрх буюу 7.3 хувь, 51-100 малтай 33.2 мянган өрх буюу 13.5 хувь, 101-200 малтай 51.9 мянган өрх буюу 21.1 хувь, 201-500 малтай 67.0 мянган өрх буюу 27.2 хувь, 501-ээс дээш малтай 40.6 мянган өрх буюу 16.5 хувийг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 32. МАЛТАЙ ӨРХИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ, малын төрлөөр

Бүлэглэлт	Малтай өрхийн тоо		Малын тоо, мянган толгой						
	2020	2021	2020	2021					
					Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Бүгд	242 024	246 302	66 709.6	66 991.1	4 298.8	4 974.0	451.1	30 892.2	26 374.9
<11	12 618	13 266	73.2	78.9	8.7	56.3	0.3	5.1	8.4
11-30	20 487	22 357	419.1	457.6	53.8	176.0	1.8	93.1	132.8
31-50	16 840	17 954	685.9	731.1	79.4	176.1	4.0	203.9	267.8
51-100	32 411	33 189	2 421.3	2 474.5	238.7	424.8	14.6	822.2	974.1
101-200	51 185	51 895	7 516.4	7 595.7	564.0	808.7	43.6	2 909.9	3 269.5
201-500	67 958	67 036	21 810.7	21 462.0	1 294.1	1 486.6	137.0	9 193.7	9 350.5
501-999	30 327	29 857	20 651.4	20 388.7	1 138.4	1 096.4	147.9	9 992.0	8 014.1
1000-1499	8 454	8 964	9 737.6	10 349.6	633.2	524.8	78.0	5 717.0	3 396.6
1500-2000	1 195	1 231	2 012.6	2 066.4	157.9	129.5	14.0	1 167.3	597.7
2001<	549	553	1 381.5	1 386.6	130.7	94.9	9.9	787.8	363.4

200 хүртэлх малтай өрхийн тоо 2021 онд 138.7 мянга болж өмнөх оноос 5.1 мянган өрхөөр буюу 3.8 хувиар өссөн бол 201-500 хүртэл малтай өрх 67.0 мянга болж өмнөх оноос 922 өрхөөр буюу 1.4 хувиар, 501-999 малтай өрх 29.9 мянга болж өмнөх оноос 470 өрхөөр буюу 1.5 хувиар буурч, 1000-аас дээш малтай өрх 10.7 мянга болж өмнөх оноос 550 өрхөөр буюу 5.4 хувиар өссөн.

ХҮСНЭГТ 33. МАЛТАЙ НЭГ ӨРХӨД НОГДОХ МАЛЫН ТОО, малын тооны бүлэглэлтээр, малын төрлөөр


Бүлэглэлт	2020	2021					
			Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Бүгд	276	272	17	20	2	125	107
<11	6	6	1	4	-	-	1
11-30	20	21	2	8	-	4	6
31-50	41	41	4	10	-	11	15
51-100	75	75	7	13	-	25	29
101-200	147	146	11	16	1	56	63
201-500	321	320	19	22	2	137	139
501-1000	681	683	38	37	5	335	268
1001-1500	1 152	1155	71	59	9	638	379
1501-2000	1 684	1679	128	105	11	948	486
2001 <	2 516	2508	236	172	18	1 425	657

Малтай нэг өрхөд улсын дунджаар 272 толгой мал ногдож байгаа нь өмнөх оноос 4 толгой малаар буурсан байна. Малтай нэг өрхөд дунджаар адуу 17, үхэр 20, тэмээ 2, хонь 125, ямаа 107 ногдож байна.

Малтай нэг өрхөд ногдох малын 85.3 хувь нь бог мал, 14.7 хувь нь бод мал байна. Мөн 500 хүртэлх малтай өрхөд ямааны тоо хонины тооноос давж байгаа бол 500-аас дээш малтай өрхүүдийн хувьд хонины тоо ямаанаас давж байна.

Малтай нэг өрхөд ногдох малын тоо Говь-Алтай, Хөвсгөл, Увс, Төв, Архангай, Ховд, Өмнөговь, Булган, Дорнод, Дундговь, Говь-Сүмбэр, Сүхбаатар, Хэнтий, Дорноговь аймгуудад 272-457 толгойд хүрч, улсын дунджаас 0-185 толгойгоор дээгүүр, Улаанбаатар хот болон бусад аймгуудад 85-270 толгой болж, улсын дунджаас 2-187 толгойгоор бага байна.

ЗУРАГ 39. МАЛТАЙ НЭГ ӨРХӨД НОГДОХ МАЛЫН ТОО, аймаг, нийслэлээр



IV.6. Малчин өрхийн малын бүлэглэлт

Амьжиргааны гол эх үүсвэр нь мал аж ахуй болсон малчин өрхийн эзэмшилд 2021 оны байдлаар нийт малын 90.4 хувь буюу 60.9 сая толгой мал байгаа бөгөөд малын тоо өмнөх онтой харьцуулахад 764.1 мянга буюу 1.3 хувиар өссөн байна.

Малын төрлөөр авч үзэхэд, нийт тэмээний 95.1 хувь буюу 431.9 мянган толгой, хонины 91.2 хувь буюу 28.4 сая толгой, ямааны 90.8 хувь буюу 24.0 сая толгой, адууны 88.2 хувь буюу 3.8 сая толгой, үхрийн 85.4 хувь буюу 4.3 сая толгой нь малчин өрхийн эзэмшилд байна.

Малчин өрхийг малын тоо толгойгоор нь бүлэглэвэл, 2020 онд 181.1 мянган малчин өрхийн 43.6 мянган өрх буюу 24.1 хувь нь 100 хүртэл малтай, 38.3 мянган өрх буюу 21.2 хувь нь 101-200 хүртэл малтай, 59.8 мянган өрх буюу 33.0 хувь нь 201-500 малтай, 29.3 мянган өрх буюу 16.2 хувь нь 501-999 малтай, 10.0 мянган өрх буюу 5.5 хувь нь 1000-аас дээш малтай байсан бол 2021 онд нийт 188.6 мянган малчин өрхийн 49.3 мянган өрх буюу 26.1 хувь нь 100 хүртэл малтай, 40.2 мянган өрх буюу 21.3 хувь нь 101-200 хүртэл малтай, 59.6 мянган өрх буюу 31.6 хувь нь 201-500 малтай, 28.9 мянган өрх буюу 15.3 хувь нь 501-999 малтай, 10.6 мянган өрх буюу 5.6 хувь нь 1000-аас дээш малтай болсон байна.

1000-аас дээш малтай 10.6 мянган малчин өрх нийт малын 22.2 хувь буюу 13.5 сая толгой малыг эзэмшдэг бол 201-ээс цөөн тооны малтай 89.5 мянган өрх нь нийт малын 13.7 хувь буюу 8.3 сая толгой малыг эзэмшиж байна.

201-ээс дээш малтай малчин өрх 2020 онд нийт малчин өрхийн 54.8 хувийг эзэлж байсан бол 2021 онд 52.5 хувийг эзэлж, 4.7 нэгж хувиар буурчээ.

ХҮСНЭГТ 34. МАЛЧИН ӨРХИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ, малын төрлөөр

Бүлэглэлт	Малчин өрхийн тоо		Малын тоо, мянган толгой						
	2020	2021	2020	2021	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Бүгд	181 052	188 605	60 141.1	60 905.2	3 815.2	4 290.7	431.9	28 351.6	24 015.8
<11	3 764	4 435	24.5	29.0	3.2	19.2	0.1	2.7	3.8
11-30	9 925	11 682	207.5	244.4	25.3	95.3	1.1	52.4	70.4
31-50	9 357	10 799	382.6	442.1	44.9	115.4	2.4	122.5	156.9
51-100	20 549	22 393	1 551.2	1 683.6	159.9	307.8	10.9	548.9	656.1
101-200	38 316	40 195	5 684.5	5 930.4	435.1	643.6	38.3	2 238.5	2 574.9
201-500	59 783	59 637	19 397.2	19 273.5	1 146.0	1 326.1	130.8	8 198.3	8 472.2
501-999	29 337	28 894	20 008.4	19 756.5	1 095.0	1 053.3	146.7	9 664.0	7 797.5
1000-1499	8 320	8 833	9 578.7	10 191.9	623.7	514.6	77.8	5 626.8	3 349.0
1500-2000	1 166	1 201	1 964.1	2 016.8	154.5	123.4	14.0	1 140.4	584.5
2001<	535	536	1 342.4	1 337.0	127.5	92.0	9.9	757.1	350.6

Жилийн дөрвөн улирлын туршид малаа малладаг, малын ашиг шим нь амьжиргааны эх үүсвэр болж байгаа нэг малчин өрхөд дунджаар 2021 оны байдлаар 323 мал, харин бодод шилжүүлснээр тооцвол 87.4 бод мал ногдож байна.

Нэг малчин өрхөд 2021 онд дунджаар 323 толгой мал ногдож, үүний дотор адуу 20, үхэр 23, тэмээ 2, хонь 150, ямаа 127 ногдож байгаа нь өмнөх онтой харьцуулахад ямаа 11, үхэр 1 толгойгоор тус тус буурсан байна.

Нэг малчин өрхөд ногдох малын тоо 2020 онд өмнөх оноос 38 толгойгоор буурч байсан бол, 2021 онд өмнөх оноос 9 толгойгоор буурчээ. Малын тооны бүлэглэлтээр авч үзэхэд, 200-аас доош малтай өрхийн хувьд ижил түвшинд байгаа бол 201-500 малтай өрхийнх 1 толгойгоор буурч, 501-999 малтай өрхийн хувьд 2 толгой, 1000-1499 малтай өрхийн хувьд 3 толгойгоор өсөж, 1500-2000 малтай өрхийнх 6 толгой, 2001-ээс дээш малтай өрхийн хувьд 14 толгой малаар буурсан байна.


ХҮСНЭГТ 35. МАЛЧИН НЭГ ӨРХӨД НОГДОХ МАЛЫН ТОО, малын тооны бүлэглэлтээр, төрлөөр

Бүлэглэлт	2020	2021	Малын тоо, мянган толгой				
			Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Бүгд	332	323	20	23	2	150	127
<11	7	7	1	4	-	1	1
11-30	21	21	2	8	-	4	6
31-50	41	41	4	11	-	11	15
51-100	75	75	7	14	-	25	29
101-200	148	148	11	16	1	56	64
201-500	324	323	19	22	2	137	142
501-999	682	684	38	36	5	334	270
1000-1499	1 151	1 154	71	58	9	637	379
1500-2000	1 685	1 679	129	103	12	950	487
2001<	2 509	2 495	238	172	18	1 412	654

Малчин нэг өрхөд ногдох малын тоо Ховд, Булган, Төв, Говь-Алтай, Дорнод, Өмнөговь, Сүхбаатар, Хэнтий, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь аймгуудад 323-505 толгойд хүрч,

улсын дунджаас 4-186 толгойгоор дээгүүр, бусад аймаг, Улаанбаатар хотод 115-313 толгой болж, улсын дунджаас 6-204 толгойгоор доогуур байна.


ЗУРАГ 40. МАЛЧИН НЭГ ӨРХӨД НОГДОХ МАЛЫН ТОО, аймаг, нийслэлээр



IV.7. Сүргийн бүтэц

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувийн жинг 2021 оны байдлаар авч үзвэл, хонь 46.2 хувь, ямаа 39.3 хувь, үхэр 7.5 хувь, адуу 6.4 хувь, тэмээ 0.7 хувийг эзэлж байна. 1950 оноос хойш 70 жилийн хугацаанд тэмээний тоо толгой 46.2 хувиар буурч хонь, адуу, үхэр, ямааны тоо толгой 3.1 дахин нэмэгджээ.

ЗУРАГ 41. СҮРГИЙН БҮТЭЦ




Сүүлийн 31 жилийн хугацаанд мал сүргийн бүтэц хэрхэн өөрчлөгдсөнийг авч үзэхэд, ямааны эзлэх хувь 19.5 нэгж хувиар өсөж, харин хониных 12.2 нэгж хувиар, үхрийнх 3.6 нэгж хувиар, адууных 2.3 нэгж хувиар, тэмээн сүргийнх 1.4 нэгж хувиар тус тус буурчээ.

Ямаан сүргийн эзлэх хувь 2021 онд өмнөх оноос 2.0 нэгж хувиар буурч, харин үхэр сүргийн эзлэх хувь 0.4 нэгж хувиар, адуун сүргийн эзлэх хувь 0.3 нэгж хувиар, хонин сүргийн эзлэх хувь 1.4 нэгж хувиар, тэмээн сүргийн эзлэх хувь 0.03 нэгж хувиар өссөн байна.

Малын тоо толгой сүүлийн жилүүдэд нэмэгдсэн ч таван төрлийн малын харьцаа, сүргийн бүтцэд томоохон өөрчлөлт гарсан байна.


Монгол Улсын мал тооллогын 1926-1992 оны 66 жилийн үр дүнгээс үзэхэд сүрэгт бод мал дунджаар 21.7 хувь, бог мал дунджаар 78.3 хувийг эзэлдэг байсан бол 2021 оны байдлаар бод мал дунджаар 14.6 хувь, бог мал дунджаар 85.4 хувийг эзэлж байгаа нь бод малын хувийн жин 7.1 нэгж хувиар буурч, бог малынх 7.1 нэгж хувиар нэмэгджээ.

ЗУРАГ 42. НИЙТ МАЛД БОД МАЛ, БОГ МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ



Манай улсын хонь, ямааны харьцаа 1990 он хүртэл 75:25 буюу 3 хонинд нэг ямаа ногдож, зохистой харьцааг хадгалж байсан. Гэвч сүүлийн жилүүдэд сүргийн бүтцэд болон малын бэлчээр ашиглалтад зохистой энэ уламжлалт харьцаа алдагдсаар 30 орчим жил болж байна. Тухайлбал, ямааны тоо толгойн эрс өсөлт 1993 оноос эхэлж, ноолуур үнэд орсонтой холбогдон 1994-2003 онд хонины тоотой ижил түвшинд болж, 2003-2009 оны ямааны тоо хонины тооноос давж, 2009-2015 онд хонины тоо толгойтой дүйцэж, 50:50 харьцаатай болсон байна.

ЗУРАГ 43. БОГ МАЛД ХОНЬ, ЯМААНЫ ЭЗЛЭХ ХУВЬ



Дөрвөн бог мал тутмын гурав нь хонь, нэг нь ямаа гэсэн харьцаатай өсгөн үржүүлж ирсэн олон жилийн уламжлалыг сүүлийн 15 жилийн дундажтай харьцуулан авч үзэхэд 2 хонь, 2 ямаа гэсэн харьцаатай болон өөрчлөгдсөн байна.

Тухайн сүргийн малын доторх нас, хүйс тус бүрийн эзлэх хувиар илэрхийлэгдэх мал сүргийн бүтэц нь мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлд чухал үзүүлэлт болдог. Мал сүргийн бүтцийг аймгаар авч үзвэл, 1942 оны үед зөвхөн Өмнөговь аймагт ямааны тоо хониныхоосоо илүү байсан бол 1994 онд Баянхонгор, 1996 онд Говь-Алтай, 1998 онд Ховд аймагт ямааны тооны давамгайлал эхэлж, 2021 оны байдлаар Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Өмнөговь, Ховд, Дорноговь аймгуудад ямааны тоо хонины тооноос давсан байна.

Сүргийн бүтцийг 2021 оны байдлаар авч үзвэл, нийт сүргийн 28.8 хувь буюу 19.4 сая толгой нь төл, өсвөр насны мал; 24.8 хувь буюу 16.6 сая толгой нь нас гүйцсэн эр мал; 45.7 хувь буюу 30.8 сая толгой нь хээлтэгч мал, 0.9 хувь буюу 587.5 мянган толгой нь хээлтүүлэгч мал байна.

ХҮСНЭГТ 36. СҮРГИЙН БҮТЭЦ, 2021 ОН, малын төрлөөр

	Бүгд	Төл, өсвөр насны мал	Нас гүйцсэн эр мал	Хээлтэгч	Хээлтүүлэгч
	мянган толгой				
Бүгд	67 343.8	19 386.7	16 585.1	30 784.5	587.5
Адуу	4 324.4	1 778.5	901.2	1 481.8	162.9
Үхэр	5 022.2	2 193.4	725.3	2 035.2	68.3
Тэмээ	454.0	190.6	88.6	169.5	5.4
Хонь	31 087.0	9 189.9	6 949.8	14 752.2	195.0
Ямаа	26 456.1	6 034.3	7 920.2	12 345.7	155.9
дүнд эзлэх хувь					
Бүгд	100.0	28.8	24.6	45.7	0.9
Адуу	100.0	41.1	20.8	34.3	3.8
Үхэр	100.0	43.7	14.4	40.5	1.4
Тэмээ	100.0	42.0	19.5	37.3	1.2
Хонь	100.0	29.6	22.4	47.5	0.6
Ямаа	100.0	22.8	29.9	46.8	0.6

Малын нас, хүйсээр нийт сүрэгт эзлэх хувийн жинг өмнөх онтой харьцуулж үзэхэд 2021 онд төл, өсвөр насны малын сүрэгт эзлэх хувь 1.8 нэгж хувиар буурч, хээлтүүлэгчийн эзлэх хувь 0.1 нэгж хувиар, нас гүйцсэн эр малын эзлэх хувь 0.2 нэгж хувиар, хээлтэгч малын эзлэх хувь тус бүр 1.5 нэгж хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 37. СҮРГИЙН БҮТЭЦ, хувиар

	1966-1968**	2017	2018	2019	2020	2021
	Адуу					
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Төл, өсвөр насны	31.6	42.5	39.7	41.8	41.6	41.1
Нас гүйцсэн эр	37.7	22.9	23.9	21.7	21.2	20.8
Хээлтэгч	27.9	31.1	32.8	32.9	33.5	34.3
Хээлтүүлэгч	2.8	3.5	3.6	3.6	3.7	3.8
	Үхэр					
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Төл, өсвөр насны	46.5	45.1	43.8	44.6	45.9	43.7
Нас гүйцсэн эр	9.2	14.7	14.9	14.1	13.9	14.4

	1966-1968**	2017	2018	2019	2020	2021
Хээлтэгч	42.5	38.9	40.1	40.0	38.9	40.5
Хээлтүүлэгч	1.8	1.3	1.2	1.3	1.3	1.4
	Тэмээ					
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Төл, өсвөр насны	31.7	43.3	43.5	43.8	44.5	42.0
Нас гүйцсэн эр	13.0	20.8	20.4	19.7	18.9	19.5
Хээлтэгч	54.0	34.8	35.0	35.4	35.5	37.3
Хээлтүүлэгч	1.3	1.1	1.1	1.1	1.1	1.2
	Хонь					
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Төл, өсвөр насны	34.5	32.4	29.0	31.9	31.1	29.6
Нас гүйцсэн эр	12.2	22.1	23.9	21.8	21.8	22.4
Хээлтэгч	51.9	44.9	46.6	45.7	46.5	47.5
Хээлтүүлэгч	1.4	0.6	0.6	0.6	0.6	0.6
	Ямаа					
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Төл, өсвөр насны	31.7	28.6	21.8	26.4	25.6	22.8
Нас гүйцсэн эр	13.0	28.3	32.2	29.5	29.4	29.9
Хээлтэгч	54.0	42.6	45.5	43.6	44.5	46.8
Хээлтүүлэгч	1.3	0.5	0.5	0.5	0.5	0.6

** жилийн дундаж

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн 1966-1968 оны үеийнхтэй харьцуулж үзвэл, сүргийн бүтцэд гарсан нэг томоохон өөрчлөлт нь үхэр сүрэг, бог малд эр, сувай малын нөөцтэй болсон явдал юм. Бог малд эр, сувай малын эзлэх хэмжээ 1966-1968 онд 12.2-13.0 хувь байсан бол 2020 онд 21.8-29.4 хувь болж 9.6-16.4 пунктээр нэмэгджээ. Үхэр сүрэгт нас гүйцсэн эр мал 1966-1968 онд 9.2 хувийг эзэлж байсан бол 2021 онд 14.6 хувь болж 5.4 пунктээр нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 38. НАС ГҮЙЦСЭН ЭР МАЛЫН ТОО

	1966-1968	2000-2002	2017-2021	<u>2017-2021</u> <u>1966-1968</u>
	мянган толгой			Хувь
Үхэр	187.2	361.5	671.2	3.6'
Хонь	1 562.4	2 648.4	6 900.1	4.4'
Ямаа	544.3	2 745.2	8 229.8	15.1'


' дахин их

Сүрэгт нас гүйцсэн эр малын нөөц ихэссэн нь махны үйлдвэрлэл нэмэгдүүлэхэд эергээр нөлөөлөх боловч бас анхаарах зүйл байна. 2017-2021 оны дунжийг 1966-1968 оны дундажтай харьцуулахад нас гүйцсэн эр малын тоо үхэрт 3.6 дахин, хонинд 4.4 дахин, ямаанд 15.1 дахин нэмэгджээ. Эр ямааны тоо 15.1 дахин өссөн нь ноолуурын үйлдвэрлэл нэмэгдүүлэхэд сайн нөлөөтэй ч бэлчээрийн даац, ноолуурын чанарт зэрэгт сөрөг нөлөөтэй байна.

Говь-Алтай, Дундговь, Говьсүмбэр, Ховд, Увс, Өмнөговь, Баянхонгор, Баян-Өлгий, Дорноговь, Өвөрхангай, Завхан, Төв, Хөвсгөл аймгуудад бод малын эзлэх хувь улсын дунджаас бага буюу 7.6-14.6 хувийг эзэлж байна.

Манай улсын нийт бог малд ямааны эзлэх хувийн жин 46.0 хувь байгаа бол Дундговь, Орхон, Дорноговь, Баян-Өлгий, Ховд, Баянхонгор, Говь-Алтай, Өмнөговь аймгуудад 47.2-71.8 хувь болж улсын дунджаас дээгүүр байна.


ЗУРАГ 44. МАЛ СҮРГИЙН БҮТЭЦ, аймгаар



IV.8. Хээлтэгч мал

Энэ оны эцэст 30.8 сая толгой хээлтэгч мал тоологдсон нь 2020 оноос 1.1 сая толгой буюу 3.7 хувиар өссөн байна. Төрлөөр авч үзвэл, гүү 1.5 сая, үнээ 2.0 сая, ингэ 169 мянга, эм хонь 14.8 мянга, эм ямаа 12.3 мянган толгой байна.

ЗУРАГ 45. ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО, сая толгойгоор



Өмнөх оноос эм ямаа 25.2 мянган толгой буюу 0.2 хувиар, ингэ 1.6 мянган толгой буюу 0.9 хувиар, эм хонь 793.5 мянган толгой буюу 5.7 хувиар, гүү 110.2 мянган толгой буюу 8.0 хувиар, үнээ 196.3 мянган толгой буюу 10.7 хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 39. ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО, малын төрлөөр

	2017	2018	2019	2020	2021
	мянган толгой				
Бүгд	28 242.4	29 777.8	30 963.5	29 657.6	30 784.5
Гүү	1 226.6	1 291.6	1 388.8	1 371.6	1 481.8
Үнээ	1 707.8	1 755.3	1 900.6	1 838.9	2 035.2
Ингэ	151.0	161.0	167.4	167.9	169.5
Эм хонь	13 519.7	14 223.4	14 748.3	13 958.7	14 752.2
Эм ямаа	11 637.2	12 346.6	12 758.5	12 320.5	12 345.7

Улсын дүнгээр нийт малд хээлтэгч малын эзлэх хувийн жин 45.7 болж өмнөх оноос 1.5 нэгж хувиар өссөн байна. Төрлөөр авч үзэхэд адуун сүргийн 34.3 хувь, үхэр сүргийн 40.5 хувь, тэмээн сүргийн 37.3 хувь, хонин сүргийн 47.5 хувь, ямаан сүргийн 46.7 хувийг тус тус эзэлж байна. Сүрэгт хээлтэгч малын эзлэх хувийн жин үнээнийх 1.6 нэгж хувиар, ингэнийх 1.8 нэгж хувиар, гүүнийх 0.8 нэгж хувиар, эм хонь 1.0 нэгж хувиар, эм ямааных 2.3 нэгж хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 40. СҮРЭГТ ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ, малын төрлөөр

	2017	2018	2019	2020	2021
Бүгд	42.6	44.8	43.6	44.2	45.7
Гүү	31.1	32.8	33.0	33.5	34.3
Үнээ	38.9	40.1	40.0	38.9	40.5
Ингэ	34.8	35.0	35.4	35.5	37.3
Эм хонь	44.9	46.6	45.7	46.5	47.5
Эм ямаа	42.6	45.5	43.6	44.4	46.7

Эрдэмтэн, судлаачид мал аж ахуйн нөхөн үйлдвэрлэлийг хэвийн хэмжээнд байлгахад бод малын хувьд хээлтэгч мал сүргийн 50.0-55.0 хувь, бог малын хувьд сүргийн 60.0-65.0 хувийг эзэлж байвал зохимжтой гэж үздэг байна.

Баруун бүсийн нийт малын 42.5 хувь, Хангайн бүсийн 46.3 хувь, Төвийн бүсийн 48 хувь, Зүүн бүсийн 45.9 хувь, Улаанбаатар хотын нийт малын 48.3 хувийг хээлтэгч мал эзэлж байна. Хээлтэгч малын тоо Улаанбаатарт 8.5 (3.8%) мянга буурсан бол Төвийн бүсэд 98.7 (1.3%) мянга, Хангайн бүсэд 179.8 (1.8%) мянга, Баруун бүсэд 469.8 (7.2%) мянга, Зүүн бүсэд 387.1 (7.4%) мянгаар өмнөх оноос өссөн байна.

ХҮСНЭГТ 41. ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО, бүс, аймаг, нийслэлээр, малын төрлөөр

Бүс, аймаг, нийслэл	2020	2021	мянган толгой				
			Гүү	Үнээ	Ингэ	Эм хонь	Эм ямаа
Бүгд	29 657.6	30 784.5	1 481.8	2 035.2	169.5	14 752.2	12 345.7
Баруун бүс	6 512.4	6 982.2	249.0	365.3	38.9	3 012.5	3 316.5
Баян-Өлгий	885.5	956.9	35.9	69.7	1.9	418.0	431.3
Говь-Алтай	1 380.4	1 428.8	44.0	30.9	16.4	424.6	913.0
Завхан	1 457.7	1 519.3	76.3	90.8	2.5	808.6	541.2
Увс	1 453.6	1 595.4	47.0	96.7	9.1	813.6	628.9
Ховд	1 335.3	1 481.7	45.8	77.1	9.1	547.6	802.1
Хангайн бүс	10 215.2	10 395.1	505.8	828.4	27.3	5 118.8	3 914.8
Архангай	2 385.8	2 449.9	142.1	289.4	0.6	1 355.7	662.2
Баянхонгор	1 630.5	1 660.1	55.6	89.1	17.7	510.4	987.3
Булган	1 609.9	1 650.4	100.6	119.5	0.5	911.8	518.1
Орхон	63.2	68.1	5.4	10.7	0.0	27.0	24.9
Өвөрхангай	1 986.9	1 933.8	105.3	99.7	7.9	967.7	753.2

Бүс, аймаг, нийслэл	2020	2021	мянган толгой				
			Гүү	Үнээ	Ингэ	Эм хонь	Эм ямаа
Хөвсгөл	2 538.8	2 632.7	96.7	220.0	0.7	1 346.2	969.1
Төвийн бүс	7 490.0	7 588.7	352.9	377.8	96.0	3 518.1	3 243.8
Говьсүмбэр	217.4	214.7	8.8	7.6	0.5	112.2	85.7
Дархан-Уул	172.1	171.6	7.5	21.4	0.0	83.2	59.5
Дорноговь	1 083.4	1 167.3	62.0	46.5	19.3	526.3	513.2
Дундговь	1 672.9	1 621.9	65.3	31.6	16.5	803.5	705.0
Өмнөговь	1 233.6	1 248.4	40.5	13.9	58.2	317.6	818.2
Сэлэнгэ	840.5	876.0	39.8	117.4	0.2	416.1	302.4
Төв	2 270.1	2 288.9	129.1	139.4	1.3	1 259.2	759.8
Зүүн бүс	5 217.1	5 604.1	351.5	422.4	7.2	3 018.0	1 805.2
Дорнод	1 234.3	1 391.7	121.8	137.6	2.5	725.8	404.0
Сүхбаатар	1 744.3	1 871.0	117.0	121.2	3.0	1 024.1	605.6
Хэнтий	2 238.5	2 341.4	112.6	163.5	1.6	1 268.1	795.5
Улаанбаатар	222.8	214.3	22.7	41.4	0.0	84.9	65.3

Оны эхний эх малын 74.1 хувь буюу 22.0 сая эх мал 2021 онд төллөж, өмнөх оноос 2.7 сая толгой буюу 11.1 хувиар буурчээ. Малын төрлөөр, өмнөх онтой харьцуулан авч үзэхэд төллөсөн гүү 36.4 мянга, ингэ 7.1 мянга, хонь 1265.4 мянга, ямаа 1648.7 мянгаар тус тус буурсан бол үнээ 7 мянгаар нэмэгдсэн байна. Төллөсөн 22 сая малын 50.9 хувь нь хонь, 37.7 хувь нь ямаа, 6.6 хувь нь үнээ, 4.4 хувь нь гүү, 0.3 хувь нь ингэ байна.

ХҮСНЭГТ 42. ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО, бүс, аймаг, нийслэлээр, малын төрлөөр

Бүс, аймаг, нийслэл	2020	2021	мянган толгой				
			Гүү	Үнээ	Ингэ	Эм хонь	Эм ямаа
Бүгд	24 719.0	22 946.6	1 006.1	1 461.2	75.3	11 714.0	8 690.0
Баруун бүс	6 139.0	5 424.2	178.6	275.8	18.9	2 419.5	2 531.5
Баян-Өлгий	900.2	882.6	30.1	58.0	1.2	383.6	409.6
Говь-Алтай	1 291.7	742.0	20.9	17.6	7.1	251.2	445.3
Завхан	1 305.2	1 225.5	55.5	65.5	1.2	648.2	455.2
Увс	1 336.2	1 341.0	36.6	74.3	4.5	686.7	538.8
Ховд	1 305.8	1 233.2	35.6	60.4	4.9	449.8	682.5
Хангайн бүс	8 410.3	6 969.5	315.3	537.6	7.9	3 756.4	2 352.3
Архангай	2 014.2	1 938.1	96.7	193.0	0.3	1 104.7	543.3
Баянхонгор	1 595.4	371.3	15.9	43.4	4.7	155.9	151.5
Булган	1 278.6	1 377.4	74.9	86.6	0.3	761.7	453.7
Орхон	52.4	59.3	4.2	8.1	0.0	23.7	23.3
Өвөрхангай	1 590.7	1 157.3	55.0	57.4	2.2	630.1	412.5
Хөвсгөл	1 878.9	2 066.3	68.5	149.1	0.4	1 080.3	767.9
Төвийн бүс	5 544.8	4 905.7	203.9	274.5	38.1	2 538.0	1 851.1
Говьсүмбэр	178.4	175.4	6.2	6.1	0.2	92.0	71.0
Дархан-Уул	147.4	151.2	6.1	18.1	0.0	74.6	52.4
Дорноговь	804.0	816.4	38.1	36.2	9.7	397.3	335.1
Дундговь	1 181.6	972.1	29.9	17.0	6.8	523.2	395.2
Өмнөговь	622.9	260.7	9.9	4.6	20.5	97.0	128.6
Сэлэнгэ	675.7	742.2	28.4	89.8	0.1	342.6	281.4
Төв	1 934.8	1 787.7	85.3	102.8	0.8	1 011.3	587.5
Зүүн бүс	4 439.8	4 489.4	264.0	323.3	3.5	2 400.7	1 497.9
Дорнод	1 022.7	1 066.9	90.0	104.1	1.3	550.1	321.4
Сүхбаатар	1 428.5	1 432.6	84.9	88.1	1.3	786.6	471.6
Хэнтий	1 988.7	1 990.0	89.1	131.1	0.9	1 064.1	704.9
Улаанбаатар	185.1	185.7	14.4	33.1	0.1	76.1	62.0

Төллөсөн хээлтэгч өмнөх оноос Улаанбаатар хот, Хэнтий, Дархан-Уул, Сүхбаатар, Увс, Орхон, Дорноговь, Дорнод, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл аймгуудад 0.6-187.4 мянган толгойгоор нэмэгдэж, харин Говьсүмбэр, Баян-Өлгий, Ховд, Архангай, Завхан, Төв, Дундговь, Өмнөговь, Өвөрхангай, Говь-Алтай, Баянхонгор аймгуудад 3.0-1224.1 мянган толгойгоор буурчээ.

IV.9. Төл бойжилт

Гарсан төлийн 92.3 хувь буюу 20.3 сая төл бойжив. Бойжсон төлийн тоо өмнөх оноос 2.5 сая толгой буюу 10.8 хувиар, бойжилтын хувь 0.4 нэгж хувиар тус тус буурсан байна.

Бойжсон төлийн тоо өмнөх оноос Зүүн бүсэд 157.4 мянга буюу 3.9 хувиар өсөж харин Баруун бүсэд 737.4 мянга буюу 12.5 хувь, Хангайн бүсэд 873.5 мянга буюу 11.9 хувиар, Төвийн бүсэд 1001.4 мянга буюу 18.8 хувиар, Улаанбаатар хотод 1.4 мянга буюу 0.8 хувиар тус тус буурчээ.

ХҮСНЭГТ 43. БОЙЖУУЛСАН ТӨЛ, бүс, аймаг, нийслэлээр, төрлөөр

Бүс, аймаг, нийслэл	2017	2018	2019	2020	2021
	мянган толгой				
Бүгд	22 642.0	19 403.3	23 587.0	22 777.8	20 321.6
Баруун бүс	5 718.1	4 541.7	5 107.5	5 918.0	5 180.7
Баян-Өлгий	856.8	749.6	809.2	888.1	860.8
Говь-Алтай	1 307.0	919.0	1 123.4	1 236.8	635.7
Завхан	1 235.1	1 000.8	1 305.5	1 233.6	1 189.0
Увс	1 112.6	991.9	1 038.9	1 283.3	1 298.7
Ховд	1 206.5	880.2	830.5	1 276.1	1 196.5
Хангайн бүс	8 196.1	6 543.5	8 706.7	7 323.3	6 449.9
Архангай	1 796.7	1 582.7	1 964.7	1 635.6	1 777.9
Баянхонгор	1 488.6	744.7	1 438.1	1 485.7	265.3
Булган	1 296.3	1 045.3	1 311.9	1 179.8	1 357.0
Орхон	50.0	34.7	53.4	51.1	59.1
Өвөрхангай	1 890.5	1 338.7	2 000.6	1 357.1	1 024.1
Хөвсгөл	1 674.0	1 797.3	1 938.0	1 614.0	1 966.4
Төвийн бүс	5 209.8	4 557.5	5 713.8	5 324.0	4 322.6
Говьсүмбэр	170.2	138.0	166.9	165.0	139.6
Дархан-Уул	119.4	123.1	143.0	147.4	146.0
Дорноговь	655.3	659.7	760.3	803.2	796.3
Дундговь	1 249.1	1 173.7	1 410.9	1 122.9	613.6
Өмнөговь	664.3	400.0	787.7	612.5	250.4
Сэлэнгэ	530.0	595.7	608.5	672.9	730.4
Төв	1 821.6	1 467.3	1 836.5	1 800.2	1 646.3
Зүүн бүс	3 343.9	3 594.1	3 891.5	4 034.6	4 192.0
Дорнод	657.2	827.3	884.4	1 012.3	1 063.6
Сүхбаатар	1 189.1	1 274.5	1 328.6	1 399.1	1 420.2
Хэнтий	1 497.6	1 492.2	1 678.5	1 623.2	1 708.2
Улаанбаатар	174.1	166.5	167.5	177.9	176.5


Гарсан унаганы 94.2 хувь, тугалын 95.4 хувь, ботгоны 94.7 хувь, хурганы 93.2 хувь, ишигний 90.2 хувийг бойжуулсан байна. Өмнөх онтой харьцуулахад, бойжуулсан ботго 20.9 мянган толгойгоор, тугал 64.0 мянган толгойгоор, хурга 851.5 мянган толгойгоор, ишиг 1 497.6 мянган толгойгоор, унага 22.1 мянган толгойгоор тус тус буурчээ.

ХҮСНЭГТ 44. ТӨЛ БОЙЖИЛТ, малын төрлөөр

	2017	2018	2019	2020	2021
	мянган толгой				
Бүгд	22 642.0	19 403.3	23 587.0	22 777.8	20 321.6
Унага	878.2	762.2	966.1	941.4	919.3
Тугал	1 296.0	1 228.4	1 391.4	1 442.0	1 378.0
Ботго	71.0	74.1	73.7	85.8	64.9
Хурга	11 104.9	10 142.7	11 854.0	11 309.0	10 457.5
Ишиг	9 291.9	7 195.9	9 301.9	8 999.6	7 502.0
төл бойжилтын хувь					
Бүгд	96.2	91.3	94.4	91.9	92.3
Унага	96.7	92.3	95.4	92.8	94.2
Тугал	96.8	94.6	96.8	94.9	95.4
Ботго	98.2	96.5	97.4	96.1	94.7
Хурга	96.6	92.6	94.9	92.0	93.2
Ишиг	95.6	88.8	93.2	91.2	90.2
100 эхээс бойжуулсан төл, толгой					
Бүгд	86	69	79	74	69
Унага	79	62	75	68	67
Тугал	82	72	79	76	75
Ботго	51	49	46	51	39
Хурга	88	75	83	77	75
Ишиг	84	62	75	71	61


Төл бойжилт Дундговь, Баянхонгор, Говьсүмбэр, Говь-Алтай, Хэнтий, Өвөрхангай, Төв, Архангай аймгуудад улсын дунджаас бага буюу 63.0-91.7 хувьтай бусад аймаг, Улаанбаатар хотод улсын дунджаас дээгүүр буюу 95.0-99.6 хувьтай байна.

ЗУРАГ 46. ТӨЛ БОЙЖИЛТЫН ХУВЬ, аймаг, нийслэлээр



100 эхээс 1990 онд 83 төл, 2000 онд 59 төл, 2010 онд 39 төл, 2020 онд 74 төл бойжуулж байсан бол 2021 онд 69 төл бойжуулж, 2020 оноос 5 төлөөр буурчээ.

ЗУРАГ 47. 100 ЭХЭЭС БОЙЖУУЛСАН ТӨЛ, аймаг, нийслэлээр



100 эхээс бойжуулсан төлийн тоо Баянхонгор аймагт 53, Өмнөговь аймагт 49, Дундговь аймагт 32, Говь-Алтай аймагт 23, Өвөрхангай аймагт 17, Говьсүмбэр аймагт 5 толгойгоор улсын дунджаас доогуур байна. Харин бусад аймаг, нийслэлд улсын дунджаас 4-28 толгойгоор илүү байна.

IV.10. Хээл хаялт, сувайралт

Эх мал хээл хаяж сувайрах нь арчилгаа маллагаа, байгаль цаг уурын байдал, хээлтэгч хээлтүүлэгчийн тохиргоо болон хээлтүүлэг хийгээгүй зэргээс шалтгаалдаг.

Энэ онд 7.6 сая мал хээл хаяж, сувайрсны улмаас төл өгөөгүй байна. Хээл хаяж, сувайрсан малын тоо өмнөх оноос 1449.3 мянган толгой буюу 23.4 хувиар нэмэгдсэн байна. Төл өгөөгүй хээлтэгч малын 87.9 хувь буюу 6.7 сая нь сувайрсан хээлтэгч, 12.1 хувь буюу 0.9 сая нь хээл хаясан эх мал байна.

ХҮСНЭГТ 45. ХЭЭЛ ХАЯЖ, СУВАЙРСАН ЭХ МАЛЫН ТОО


Бүгд	Хээл хаяж, сувайрсан					Сувайрсан				
	2017	2018	2019	2020	2021	2017	2018	2019	2020	2021
	мянган толгой									
Бүгд	3 314.1	6 794.4	5 199.3	6 182.4	7 631.6	2 792.2	5 740.8	4 225.2	5 050.7	6 706.7
Гүү	210.4	375.9	290.2	361.7	397.7	180.4	309.1	250.5	303.5	346.0
Үнээ	250.0	372.6	327.0	361.5	406.7	216.7	327.0	288.0	311.4	364.3
Ингэ	2.9	5.1	4.7	5.4	12.8	2.6	4.7	4.5	5.1	12.4
Эм хонь	1 279.8	2 525.8	1 944.7	2 476.6	2 815.3	1 092.2	2 227.2	1 671.2	2 097.6	2 517.1
Эм ямаа	1 571.0	3 514.9	2 632.6	2 977.2	3 999.1	1 300.3	2 872.8	2 011.0	2 333.1	3 466.8

2021 онд оны эхний хээлтэгч малын 25.7 хувь нь хээл хаяж, сувайрчээ. Энэ үзүүлэлт 2020 оноос 5.8 нэгж хувиар өссөн байна. Эм ямааны 32.5 хувь, гүүний 29.0 хувь, үнээний 22.1 хувь, эм хонины 20.2 хувь, ингэний 7.6 хувь нь хээл хаяж, сувайрчээ.

Бүсээр 2021 оны байдлаар авч үзэхэд хээл хаяж, сувайрсан эх малын 44.6 хувь нь Хангайн бүсэд, 30.5 хувь нь Төвийн бүсэд, 14.4 хувь нь Баруун бүсэд, 9.9 хувь нь Зүүн бүсэд, 0.6 хувь нь Улаанбаатар хотод байна.

Сувайрсан эх малын 44.7 хувь нь Хангайн бүс, 31.4 хувь нь Төвийн бүс, 13.9 хувь нь Баруун бүс, 9.6 хувь нь Зүүн бүсэд, 0.5 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

ЗУРАГ 48. ОНЫ ЭХНИЙ ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТООНД ХЭЭЛ ХАЯСАН, СУВАЙРСАН МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ



Харин хээл хаясан эх малын 43.9 хувь нь Хангайн бүс, 24.4 хувь нь Төвийн бүс, 18.6 хувь нь Баруун бүс, 12.1 хувь нь Зүүн бүсэд, 1.0 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

ХҮСНЭГТ 46. ХЭЭЛ ХАЯЖ, СУВАЙРСАН ЭХ МАЛ, бүс, аймаг, нийслэлээр

Бүс, аймаг, нийслэл	Сувайрсан					Хээл хаясан				
	2017	2018	2019	2020	2021	2017	2018	2019	2020	2021
	мянган толгой									
Бүгд	2 792.2	5 40.8	4 25.2	5 50.7	6 706.7	521.9	1 53.6	974.0	1 31.6	924.9
Баруун бүс	404.4	1 65.0	845.5	584.6	929.2	82.3	331.5	408.8	126.5	172.2
Баян-Өлгий	14.7	38.9	35.8	22.8	21.0	12.1	46.3	63.0	9.4	8.5
Говь-Алтай	92.2	480.2	309.8	202.7	524.7	14.1	46.0	80.2	26.4	86.7
Завхан	95.0	305.0	151.1	185.3	200.8	15.4	56.9	32.8	43.8	22.0
Увс	98.2	114.1	132.8	112.1	91.9	25.9	83.7	92.8	34.4	35.1
Ховд	104.2	326.9	216.0	61.7	90.7	14.7	98.5	140.0	12.4	19.8
Хангайн бүс	1 194.5	2 96.7	1 48.0	2 55.1	2 997.7	283.6	451.3	328.2	746.2	406.4
Архангай	214.8	379.8	321.2	462.5	399.8	75.3	121.0	98.9	215.0	125.2
Баянхонгор	180.1	897.1	420.6	306.3	1 086.7	22.4	43.6	39.4	33.9	51.0
Булган	224.5	339.2	230.2	283.3	248.3	58.7	70.5	41.2	116.3	50.7
Орхон	7.5	11.0	4.4	5.7	7.8	1.8	2.8	1.0	0.8	1.2
Өвөрхангай	145.0	451.3	262.2	546.9	745.3	24.9	153.0	54.7	137.9	86.3
Хөвсгөл	422.7	518.2	509.5	650.3	509.8	100.4	60.4	93.0	242.2	92.0
Төвийн бүс	762.7	1 19.4	1 23.6	1 62.3	2 104.3	89.3	170.7	89.7	124.3	225.4
Говьсүмбэр	12.1	16.5	22.1	19.9	25.9	2.3	6.9	2.7	6.9	9.0
Дархан-Уул	14.8	18.3	11.5	14.5	16.4	5.0	4.1	2.2	1.1	2.5
Дорноговь	97.6	145.9	138.2	162.5	196.3	7.3	11.1	6.9	7.2	29.0
Дундговь	99.9	146.8	214.4	497.9	576.5	2.5	26.2	8.2	13.5	60.4
Өмнөговь	276.3	593.4	360.4	538.1	890.1	2.3	11.2	2.0	2.9	5.0
Сэлэнгэ	74.5	75.1	77.4	75.6	75.3	26.9	9.6	17.6	21.6	15.6
Төв	187.6	323.5	199.6	253.9	323.9	43.0	101.7	50.1	71.1	103.9
Зүүн бүс	402.4	532.2	586.2	620.6	642.6	61.1	94.5	137.7	127.1	111.7
Дорнод	73.7	72.0	137.6	138.2	146.4	17.7	14.2	25.8	27.5	21.7
Сүхбаатар	129.8	154.5	142.4	157.4	170.9	13.2	30.2	42.5	29.3	32.4
Хэнтий	199.0	305.8	306.2	325.0	325.3	30.2	50.1	69.4	70.2	57.6
Улаанбаатар	28.1	27.4	21.9	28.1	33.0	5.7	5.6	9.5	7.6	9.3

IV.11. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо

Хээлтүүлэгч 587.5 мянган мал 2021 онд тоологдож өмнөх оноос 31.9 мянган толгойгоор буюу 5.7 хувиар өссөн.

ХҮСНЭГТ 47. ХЭЭЛТҮҮЛЭГЧ МАЛЫН ТОО, малын төрлөөр

	1966-1968*	2017	2018	2019	2020	2021
	мянган толгой					
Бүгд	337.0	518.7	512.5	560.6	555.6	587.5
Азарга	64.0	136.6	141.8	150.8	153.1	162.9
Бух	36.3	55.0	53.4	59.8	61.8	68.3
Буур	6.3	4.8	5.0	5.2	5.0	5.4
Хуц	173.9	177.2	174.4	189.8	183.7	195.0
Ухна	56.5	145.0	138.0	154.9	152.0	155.9

* жилийн дундаж

Үржлийн нормоор нэг буурт 20-25 ингэ, нэг азарганд 12-15 гүү, нэг бухад 35-45 үнээ, нэг хуцанд 25-30 эм хонь, нэг ухнад 25-30 эм ямаа ногддог.

Сүүлийн жилүүдэд хээлтэгч, хээлтүүлэгчийн тохиргоо алдагдаж, бод малын хувьд үржлийн нормоор, харин бог малын хувьд үржлийн норм алдагдсанаас, эх малын сувайралт гарахад нөлөөлж байна.

ХҮСНЭГТ 48. ХЭЭЛТЭГЧ, ХЭЭЛТҮҮЛЭГЧИЙН ТОХИРОО, малын төрлөөр

	Үржлийн норм	1966-1968*	2017	2018	2019	2020	2021
Гүү	12-15	10	9	9	9	9	9
Үнээ	35-45	24	31	32	32	30	30
Ингэ	20-25	29	31	30	32	33	31
Эм хонь	25-30	39	76	78	78	76	76
Эм ямаа	25-30	40	80	84	82	81	79

*жилийн дундаж

1966-1968 оны дунджаар нэг хуц, ухнад 39-40 эм хонь, ямаа ногддог байсан нь үржлийн нормтой ойролцоо байжээ.

Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой байхад 2021 онд улсын дунджаар 1 хуцанд 76 эм хонь, 1 ухнад 79 эм ямаа ногдож байгаа нь норм 2.5-2.6 дахин хэтэрч, хээлтэгч хээлтүүлэгчийн тохиргоо алдагдсан хэвээр байна.

IV.12. Малын хэрэглээний зарлага

Оны эхний нийт малын 25.4 хувьтай тэнцэх 17.0 сая малыг 2021 онд хэрэглээнд зарцуулсан байна. Малын хэрэглээний зарлага өмнөх оноос 7.6 сая толгой буюу 30.8 хувиар буурсан байна. Малын зарлагыг төрлөөр авч үзвэл, адууны зарлага өмнөх оноос 384.7 мянган толгой буюу 40.3 хувь, үхрийнх 420.0 мянган толгой буюу 31.8 хувиар, тэмээнийх 19.3 мянган толгой буюу 23.9 хувь, хониных 4.2 сая толгой буюу 33.7 хувь, ямааных 2.5 сая толгой буюу 26.1 хувиар тус тус буурсан байна.

Малтай нэг өрх 2020 онд дунджаар 102 толгой малыг өөрийн болон бусдын хэрэглээнд зориулан зарцуулж байсан бол 2021 онд 69 толгой мал зарцуулжээ.

ХҮСНЭГТ 49. МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА, малын төрлөөр

Төрөл	2017	2018	2019	2020	2021
	мянган толгой				
Бүгд	14 105.8	16 526.7	17 960.3	24 614.6	17 034.0
Адуу	463.4	597.0	633.3	955.0	570.3
Үхэр	802.7	1 002.2	943.7	1 319.4	899.4
Тэмээ	33.4	45.3	58.9	80.9	61.6
Хонь	7 091.8	8 729.1	9 653.3	12 508.1	8 296.5
Ямаа	5 714.5	6 153.0	6 671.0	9 751.1	7 206.2
Оны эхний малд эзлэх хувь					
Бүгд	22.9	25.0	27.0	34.7	25.4
Адуу	12.7	15.2	16.1	22.7	13.9
Үхэр	19.7	22.8	21.5	27.8	19.0
Тэмээ	8.3	10.4	12.8	17.1	13.0
Хонь	25.5	29.0	31.6	38.8	27.6
Ямаа	22.3	22.5	24.6	33.3	26.0

Хэрэглээнд зарцуулсан малын 91.0 хувийг бог мал, 9.0 хувийг бод мал эзэлж байгаа бөгөөд оны эхэнд байсан адууны 13.9 хувь, үхрийн 19.0 хувь, тэмээний 13.0 хувь, хонины 27.6 хувь, ямааны 26.0 хувийг хүнсний хэрэглээнд зарцуулжээ.

ХҮСНЭГТ 50. МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА, бүс, аймаг, нийслэл, малын төрлөөр

Бүс, аймаг, нийслэл	2017	2018	2019	2020	2021					
	мянган толгой					Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Бүгд	14 105.8	16 526.7	17 960.3	24 614.6	17 034.0	570.3	899.4	61.6	8 296.5	7 206.2
Баруун бүс	3 663.4	4 479.5	4 243.0	5 891.6	4 191.4	102.0	161.9	13.5	1 770.7	2 143.3
Баян-Өлгий	671.7	737.8	722.9	846.5	696.4	14.3	33.2	0.6	296.7	351.5
Говь-Алтай	797.9	1 056.1	981.4	1 493.2	677.9	18.4	15.8	6.0	209.6	428.1
Завхан	825.7	861.7	988.5	1 378.6	992.7	34.6	39.0	1.0	492.5	425.6
Увс	592.2	818.8	789.5	1 123.9	967.7	16.7	37.3	3.3	488.1	422.3
Ховд	776.0	1 005.2	760.7	1 049.4	856.6	17.9	36.6	2.6	283.8	515.7
Хангайн бүс	5 351.9	5 418.9	6 454.5	9 516.8	5 359.2	174.4	318.8	10.8	2 830.6	2 024.6
Архангай	1 177.4	1 073.0	1 215.9	1 986.0	1 443.8	51.0	109.3	0.0	841.3	442.3
Баянхонгор	931.9	744.6	1 001.8	2 167.0	165.5	7.5	21.2	6.0	94.1	36.6
Булган	1 051.3	985.5	949.4	1 253.5	1 101.1	41.8	59.6	0.2	583.4	416.1
Орхон	41.3	36.3	40.3	39.9	40.9	1.2	3.9	0.0	15.1	20.6
Өвөрхангай	1 121.7	1 268.6	1 732.9	2 293.1	1 151.8	44.2	43.0	4.5	553.8	506.3
Хөвсгөл	1 028.3	1 310.8	1 514.2	1 777.4	1 456.2	28.6	81.8	0.2	742.9	602.6
Төвийн бүс	3 329.4	3 886.6	4 071.3	5 388.2	4 287.2	148.6	201.4	34.3	2 042.2	1 860.8
Говьсүмбэр	94.0	109.4	136.7	151.3	118.7	3.0	3.3	0.2	59.9	52.2
Дархан-уул	83.3	124.3	100.8	131.9	148.2	4.0	14.8	0.0	69.5	59.9
Дорноговь	362.7	494.3	495.6	644.9	603.6	17.8	19.8	6.5	287.7	271.9
Дундговь	632.3	865.4	1 129.5	1 441.8	693.1	23.0	15.3	6.8	383.2	264.8
Өмнөговь	324.3	393.9	377.7	711.1	487.7	12.7	3.5	20.2	121.4	329.9
Сэлэнгэ	457.0	551.0	459.3	530.9	648.5	16.6	60.0	0.0	266.4	305.4
Төв	1 375.8	1 348.4	1 371.7	1 776.2	1 587.4	71.5	84.6	0.5	854.2	576.6
Зүүн бүс	1 637.9	2 578.3	3 061.8	3 675.2	3 009.8	137.3	183.2	2.8	1 579.8	1 106.7
Дорнод	295.9	500.8	625.1	875.8	753.6	45.1	53.2	1.1	379.0	275.3
Сүхбаатар	601.7	1 010.1	1 181.8	1 273.4	1 067.5	48.6	55.6	1.1	579.8	382.3
Хэнтий	740.2	1 067.4	1 254.8	1 526.0	1 188.7	43.5	74.4	0.6	621.0	449.2
Улаанбаатар	123.1	163.3	129.7	142.8	186.3	8.0	34.1	0.2	73.2	70.9

Хэрэглээнд зарцуулсан малын 31.5 хувь нь Хангайн бүсэд, 25.2 хувь нь Төвийн бүсэд, 24.6 хувь нь Баруун бүсэд, 17.7 хувь нь Зүүн бүсэд, 1.1 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

ХҮСНЭГТ 51. ЗАХ ЗЭЭЛД ХУДАЛДАН БОРЛУУЛСАН БОЛОН АЖ АХУЙН ДОТООДОД ХЭРЭГЛЭСЭН МАЛЫН ТОО, малын төрлөөр

	Зах зээлд худалдан борлуулсан					Аж ахуйн дотоодод хэрэглэсэн				
	2017	2018	2019	2020	2021	2017	2018	2019	2020	2021
	мянган толгой									
Бүгд	11 96.2	11 313.1	14547.0	19 704.9	14 951.9	3 879.1	3 593.9	3 817.2	4 334.5	3 748.6
Адуу	462.6	492.9	663.2	906.8	667.9	117.1	116.8	122.1	142.1	125.9
Үхэр	693.9	755.1	898.8	1 191.7	952.1	221.8	218.2	216.9	248.1	227.3
Тэмээ	28.0	35.0	53.2	72.2	60.3	9.7	10.4	10.8	12.5	11.5
Хонь	5 633.2	5 924.1	7 690.2	9 790.9	7 181.6	1 796.4	1 748.2	1 897.6	2 128.1	1 791.0
Ямаа	4 478.6	4 106.0	5 241.6	7 743.2	6 090.1	1 734.0	1 500.3	1 569.8	1 803.7	1 592.8


Нийт 15.0 сая толгой малыг 2021 онд зах зээлд худалдан борлуулж, 3.7 сая толгой малыг аж ахуйн дотоодод хэрэглэсэн байна. Малтай нэг өрх дунджаар 2021 онд 61 толгой мал худалдан борлуулж, 15 толгой малыг өөрийн хүнсэндээ хэрэглэсэн байна.

IV.13. Том малын зүй бус хорогдол

Манай улсын мал аж ахуй нь цаг агаарын нөхцөлөөс ихээхэн хамааралтай байдаг. Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөөс хамаарч Монгол Улсын агаар мандлын гаралтай аюултай болон гамшигт үзэгдэл, түүний дотор ган зудын хамрах хүрээ нэмэгдэж, бэлчээрийн мал аж ахуйн эмзэг байдлыг нэмэгдүүлж байна.


Байгалийн гамшгаас гадна хүний буруутай үйл ажиллагаа, аймаг, орон нутгийн малчдын хувийн бэлтгэл, бэлчээрийн даац алдагдаж нөөц хүрэлцэхгүй байгаа, малын өвчин, мал эмнэлгийн үйлчилгээ, мал сүргийн бүтцийн зохистой харьцаа алдагдсан, малын чанар чансаа муудсан зэрэг хүчин зүйл нь малын өсөлтөд сөргөөр нөлөөлж, мал хорогдолд нөлөөлсөөр байна.

ЗУРАГ 49. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, мянган толгой



Манай улсад хамгийн их хэмжээгээр том малын зүй бус хорогдол гарсан жил нь 2010 он бөгөөд оны эхний малын 23.4 хувь буюу 10.3 сая толгой мал зүй бусаар хорогдож байжээ. 1918 оноос хойших 100 жилийн хугацаанд том малын зүй бус хорогдлыг авч үзвэл, 18 удаа томоохон зуд тохиолдож, тохиолдол тутамд 2 саяас дээш толгой малаар хорогдож, эдийн засаг, нийгмийн амьдралд ихээхэн хохирол учирч байжээ.

ЗУРАГ 50. ОНЫ ЭХНИЙ МАЛД ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ



Оны эхний малын 4.2 хувь буюу 3.0 сая толгой мал 2021 онд хорогдсон байгаа нь өмнөх онтой харьцуулахад 948.2 мянган толгой буюу 45.9 хувиар өссөн байна. Хорогдсон нийт малын 37.3 хувийг хонь, 51.8 хувийг ямаа, 6.3 хувийг үхэр, 3.9 хувийг адуу, 0.7 хувийг тэмээ эзэлж байна.

ХҮСНЭГТ 52. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, малын төрлөөр

	2017	2018	2019	2020	2021
Малын зүй бус хорогдол, мянган толгой					
Бүгд	888.0	2 635.4	1 117.6	2 064.1	3 012.3
Адуу	43.9	164.9	58.1	107.3	118.4
Үхэр	94.4	233.8	75.3	143.8	188.4
Тэмээ	1.1	3.2	2.1	4.4	22.2
Хонь	407.6	968.7	488.2	1018.7	1 123.5
Ямаа	341.1	1 264.8	493.9	789.8	1 559.9
Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь					
Бүгд	1.4	4.0	1.7	2.9	4.2
Адуу	1.2	4.2	1.5	2.5	2.8
Үхэр	2.3	5.3	1.7	3.0	4.0
Тэмээ	0.3	0.7	0.5	0.9	4.7
Хонь	1.5	3.2	1.6	3.2	3.5
Ямаа	1.3	4.6	1.8	2.7	5.3
Зүй бусаар хорогдсон нийт малд эзлэх хувь					
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0
Адуу	4.9	6.3	5.2	5.2	3.9
Үхэр	10.6	8.9	6.7	7.0	6.3
Тэмээ	0.1	0.1	0.2	0.2	0.7
Хонь	45.9	36.8	43.7	49.4	37.3
Ямаа	38.4	48.0	44.2	38.3	51.8

Нийт хорогдлын 46.8 хувь нь Хангайн бүсэд, 30.4 хувь нь Төвийн бүсэд, 12.8 хувь нь Баруун бүсэд, 9.4 хувь нь Зүүн бүсэд, 0.5 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

2021 онд гарсан нийт хорогдлын 71.1 хувь нь Баянхонгор, Дундговь, Өвөрхангай, Говь-Алтай, Хэнтий аймгуудад гарчээ. Баянхонгор аймагт оны эхний малын 27.0 хувь, Дундговь аймагт 16.3 хувь, Өвөрхангай аймагт 10.9 хувь, Говь-Алтай аймагт 9.2 хувь, Хэнтий аймагт 7.7 хувь нь хорогдсон байна.

ХҮСНЭГТ 53. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, малын төрлөөр, бүс, аймаг, нийслэлээр, малын төрлөөр

Бүс, аймаг, нийслэл	2017	2018	2019	2020	2021	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
	мянган толгой									
Бүгд	888.0	2 635.4	1 117.6	2 064.1	3 012.3	118.4	188.4	22.2	1 123.5	1 559.9
Баруун бүс	130.2	706.3	417.5	185.6	386.4	12.4	14.6	1.0	114.8	243.6
Баян-Өлгий	17.8	71.0	60.4	9.7	10.1	1.1	1.1	0.0	3.0	4.8
Говь-Алтай	10.9	151.2	57.7	30.5	278.1	6.0	5.9	0.7	74.9	190.6
Завхан	40.6	181.0	22.5	97.1	49.0	3.4	4.5	0.0	18.9	22.1
Увс	30.6	127.8	145.0	29.8	13.8	0.8	1.2	0.1	5.7	6.0
Ховд	30.3	175.3	131.9	18.5	35.5	1.0	1.8	0.1	12.3	20.2
Хангайн бүс	472.3	1 206.3	328.8	1 300.6	1 411.0	58.7	117.3	13.0	485.6	736.5
Архангай	129.5	319.4	63.8	416.7	171.9	8.7	24.5	0.1	86.9	51.7
Баянхонгор	22.4	338.4	41.0	123.8	812.6	30.5	61.7	8.0	220.9	491.6
Булган	85.4	115.9	26.2	172.0	29.6	1.7	2.3	0.0	15.4	10.2
Орхон	5.4	6.4	0.5	1.2	0.6	0.0	0.1	0.0	0.1	0.3
Өвөрхангай	29.3	352.3	103.6	210.4	328.7	14.6	21.6	4.8	130.4	157.3
Хөвсгөл	200.3	73.9	93.8	376.5	67.6	3.2	7.1	0.1	31.9	25.3
Төвийн бүс	184.2	435.8	112.3	203.5	915.0	33.4	33.5	8.1	387.6	452.4
Говьсүмбэр	2.9	39.5	5.7	14.7	39.7	1.0	1.0	0.0	16.8	20.9
Дархан-Уул	19.1	3.7	0.9	2.3	3.0	0.1	0.5	0.0	1.2	1.2
Дорноговь	5.6	18.9	8.7	11.0	37.4	1.4	2.0	0.1	14.2	19.7
Дундговь	3.4	75.4	14.2	33.1	491.1	10.1	8.8	1.9	228.7	241.5
Өмнөговь	11.3	62.0	8.1	21.0	129.7	5.1	2.9	5.9	28.5	87.4
Сэлэнгэ	69.6	14.6	6.7	5.9	13.8	0.9	3.3	0.0	5.0	4.6
Төв	72.4	221.6	68.1	115.6	200.4	14.8	15.1	0.2	93.2	77.1
Зүүн бүс	93.0	271.8	254.2	363.2	284.4	12.4	20.1	0.1	130.3	121.4
Дорнод	9.1	6.6	7.4	16.4	8.6	0.4	2.2	0.0	2.7	3.2
Сүхбаатар	12.9	76.0	46.6	49.2	43.4	2.1	4.6	0.0	17.0	19.7
Хэнтий	70.9	189.2	200.2	297.7	232.4	9.9	13.3	0.0	110.6	98.6
Улаанбаатар	8.3	15.1	4.7	11.2	15.5	1.6	2.9	0.0	5.1	5.9

Зүй бусаар мал нь хорогдсон нийт өрхийн 12.8 хувь нь 50 хүртэлх малтай, 12.1 хувь нь 51-100 малтай, 21.1 хувь нь 101-200 малтай, 33.0 хувь нь 201-500 малтай, 15.8 хувь нь 501-1000 малтай, 5.3 хувь нь 1000-аас дээш малтай өрх байна.


ХҮСНЭГТ 54. МАЛТАЙ ӨРХИЙН ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, 2021 ОН, өрхийн бүлэглэлтээр

Бүлэглэлт	Малтай өрх			Малын хорогдол гарсан өрх		Оны эхний малд зүй бус хорогдлын эзлэх хувь
	Өрхийн тоо	Оны эхний малын тоо, мянган толгой	Оны эцсийн малын тоо, мянган толгой	Өрхийн тоо	Хорогдсон малын тоо, мянган толгой	
Бүгд	246 302	66 709.6	66 991.1	65 059	2 799.5	4.2
<11	13 266	73.2	78.9	1 170	18.0	24.6
11-30	22 357	419.1	457.6	3 600	79.6	19.0
31-50	17 954	685.9	731.1	3 527	82.1	12.0
51-100	33 189	2 421.3	2 474.5	7 845	220.1	9.1
101-200	51 895	7 516.4	7 595.7	13 732	490.8	6.5
201-500	67 036	21 810.7	21 462.0	21 453	1 038.7	4.8
501-1000	29 857	20 651.4	20 388.7	10 265	608.9	2.9
1001-1500	8 964	9 737.6	10 349.6	2 883	202.4	2.1
1501-2000	1 231	2 012.6	2 066.4	403	34.7	1.7
2001<	553	1 381.5	1 386.6	181	24.2	1.8

Харин малтай өрхийн зүй бусаар хорогдсон малын 6.4 хувь нь 50 хүртэлх малтай, 7.9 хувь нь 51-100 малтай, 17.5 хувь нь 101-200 малтай, 37.1 хувь нь 201-500 малтай, 21.8 хувь нь 501-1000 малтай, 9.3 хувь нь 1000-аас дээш малтай өрхөд тус тус ногдож байна.

Нийт хорогдсон малын 19.7 хувь буюу 593.8 мянга нь цас, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюулаар, 1.0 хувь буюу 29.5 мянга нь өвчнөөр, 1.8 хувь буюу 53.3 мянга нь зэрлэг амьтанд бариулснаар, 77.5 хувь буюу 2.3 сая нь малын хариулга, арчилгаа маллагаатай холбоотой бусад шалтгааны улмаас 2021 онд хорогджээ.


ЗУРАГ 51. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУСААР ХОРОГДЛЫН ШАЛТГААН, 2021 он



Өвчнөөр хорогдсон мал 2021 онд өмнөх оноос 25.4 мянга буюу 86.2 хувиар буурсан байна. Өвчнөөр хорогдсон малын 46.8 хувь нь буюу 13.8 мянга нь хонь, 35.4 хувь нь буюу 10.4 мянга нь ямаа, 13.1 хувь нь буюу 3.9 мянга нь үхэр, 4.3 хувь нь буюу 1.3 мянга нь адуу, 0.4 хувь нь буюу 107 нь тэмээ байна.


Өмнөх онтой харьцуулахад өвчний хорогдолд хонины эзлэх хувь 8.7 нэгж хувиар, адууных 1.3 нэгж хувиар буурч, үхрийнх 5.8 нэгж хувь, ямааных 4.0 нэгж хувь, тэмээнийх 0.2 хувиар нэмэгдсэн байна.

ЗУРАГ 52. ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ, малын төрлөөр



Өвчнөөр хорогдсон малын 23.5 хувь нь Төв аймагт, 16.6 хувь нь Хөвсгөл аймагт, 11.3 хувь нь Хэнтий аймагт, 7.5 хувь нь Булган, Өвөрхангай аймагт, 5.9 хувь нь Дундговь аймагт хорогдсон байна.

ЗУРАГ 53. ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ, 2021 ОН, аймаг, нийслэлээр толгойгоор



Цас, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул мөн геологийн болон биологийн аюулт үзэгдлээр 2021 онд 593.8 мянган толгой мал хорогдсон нь өмнөх оноос 366.4 мянган толгой буюу 2.6 дахин өссөн байна.

ХҮСНЭГТ 55. ГЭНЭТИЙН АЮУЛ, АЮУЛТ ҮЗЭГДЛЭЭР ХОРОГДСОН МАЛЫН ТОО, малын төрлөөр

	2017	2018	2019	2020	2021
	мянган толгой				
Бүгд	208.9	641.6	287.2	227.5	593.8
Адуу	10.2	45.8	13.2	8.8	19.1
Үхэр	21.4	52.5	13.1	12.1	20.5
Тэмээ	0.3	0.7	0.6	0.5	2.5
Хонь	93.0	243.1	128.7	113.6	256.2
Ямаа	84.1	299.5	131.7	92.5	295.5

* 2019 оноос гэнэтийн аюул буюу байгалийн аюулт үзэгдлээр хорогдсон цаг агаарын аюулт үзэгдлээс гадна геологийн гаралтай болон биологийн гаралтай аюулт үзэгдлийг нэгтгэн ангилсан.

Гэнэтийн аюул, аюулт үзэгдлээр хорогдсон малын 92.9 хувь нь бог мал байна. Гэнэтийн аюул, аюулт үзэгдлээр хорогдсон малын 69.2 хувь нь Төв, Архангай, Хөвсгөл, Булган, Хэнтий аймагт хорогдсон байна.

IV.14. Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал

Монгол Улсад анх бий болгон баталгаажуулсан "Унаган үүлдэр, омгийн мал" болон импортлон үржүүлж буй буюу "Бусад үүлдэр"-ын малын тоо, тэдгээрийн эрлийз ба сайжирсан малын тооны мэдээллийг мал тооллогоор цуглуулж, нэгтгэж байна. Мэдээлэл цуглуулалтын 2019 оны маягтад Монгол Улсад үржүүлж байгаа мал сүргийн мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 12 сарын 225-ныдрийн А/501 дугаар тушаалын 2-р хавсралтын дагуу мал сүргийн кодын дагуу шинэчлэн тогтоосон болно.

Цэвэр үүлдрийн мал 2021 онд 6.2 сая, эрлийз мал 134.0 мянга, нутгийн шилдэг омгийн мал 25.2 мянга, сайжруулсан нутгийн үүлдрийн хонь 967.6 мянган толгой тоологдов.

ХҮСНЭГТ 56. ЦЭВЭР ҮҮЛДРИЙН БОЛОН ЭРЛИЙЗ, НУТГИЙН ШИЛДЭГ ОМГИЙН МАЛЫН ТОО, малын төрлөөр

	2017	2018	2019	2020	2021
	мянган толгой				
Цэвэр үүлдрийн	2 370.3	2 389.6	5 544.4	5 662.0	6 190.2
Ухэр	90.5	70.9	168.6	184.9	193.7
Хонь	2 052.9	2 141.6	3 249.8	3 329.8	3 641.8
Ямаа	226.9	177.1	2 126.0	2 147.3	2 354.6
Эрлийз	403.9	339.5	142.3	156.0	134.0
Ухэр	120.8	105.4	119.1	137.3	117.3
Хонь	27.4	13.6	23.2	18.7	16.5
Ямаа	255.7	220.5	0.0	0.1	0.2
Нутгийн шилдэг омгийн	2 214.2	2 414.6	20.5	24.5	25.2
Адуу	141.7	122.4	0.9	1.4	1.7
Ухэр	4.3	20.9	18.9	22.3	19.7
Тэмээ	24.8	28.3	0.0	0.0	-
Хонь	424.0	469.8	0.6	0.8	3.8
Ямаа	1 619.4	1 773.2	0.0	0.0	0.1
Сайжруулсан нутгийн үүлдрийн	570.3	640.0	953.1	1 024.7	967.6
Хонь	570.3	640.0	953.1	1 024.7	967.6

* Монгол Улсад үржүүлж байгаа мал сүргийн мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 12 сарын 225-ныдрийн А/501 дугаар тушаалын 2-р хавсралтын дагуу мал сүргийн кодын дагуу шинэчлэн тогтоосон болно.

Нийт малын 9.2 хувийг цэвэр үүлдрийн мал, 0.2 хувийг эрлийз мал эзэлж байна. Нийт хонин сүргийн 3.1 хувийг сайжруулсан нутгийн үүлдрийн хонь тус тус эзэлж байна.

IV.15. Тэжээвэр амьтад

2021 онд 30.6 мянган гахай, 1158.4 мянган шувуу, 2450 цаа буга, 25 илжиг, 380 туулай, 13.4 мянган бүл зөгий тоологдсон бөгөөд өмнөх онтой харьцуулахад гахай 6.0 мянган толгой, шувуу 161.2 мянган толгой, зөгий 1543 бүл, туулай 10 толгойгоор нэмэгдэж, илжиг 5 толгой, цаа буга 677 толгойгоор буурсан байна.

ХҮСНЭГТ 57. ТЭЖЭЭВЭР АМЬТАД, ТЭДГЭЭРИЙГ ӨСГӨН ҮРЖҮҮЛДЭГ ӨРХИЙН ТОО

	2017	2018	2019	2020	2021
Гахай, мянган толгой	31.9	27.8	20.9	24.5	30.6
Шувуу, мянган толгой	705.1	886.0	898.7	997.2	1 158.4
Цаа буга	2 229	2 399	2 639	3 127	2 450
Илжиг	44	38	40	30	25
Зөгий, бүл	9 122	9 791	10 832	11 833	13 376
Туулай	508	150	456	370	380
Гахайтай өрхийн тоо, мянган өрх	0.8	0.8	0.6	0.8	1.0
Шувуутай өрхийн тоо, мянган өрх	1.4	1.3	1.4	1.4	1.5

Тэжээвэр амьтдын дотор гахай, шувууны аж ахуйг илүүтэй эрхэлж байна. 2021 онд гахайг 1.0 мянган өрх, шувууг 1.5 мянган өрх өсгөн үржүүлсэн байна.

ХҮСНЭГТ 58. ТЭЖЭЭВЭР АМЬТАД, бүс, аймаг, нийслэлээр

Бүс, аймаг, нийслэл	Гахай					Мэгж				
	2017	2018	2019	2020	2021	2017	2018	2019	2020	2021
	толгой									
Бүгд	31 870	27 819	20 892	24 531	30 577	6 639	5 910	4 608	5 952	7 664
Баруун бүс	772	795	411	474	635	254	229	137	254	330
Говь-Алтай	500	471	89	100	96	143	128	24	45	21
Завхан	69	54	123	144	139	38	19	33	83	63
Увс	77	161	188	205	274	30	68	78	114	205
Ховд	126	109	11	25	126	43	14	2	12	41
Хангайн бүс	2 285	2 050	1 374	2 058	2 932	686	639	553	679	984
Архангай	209	167	226	416	393	107	73	94	199	97
Баянхонгор	35	134	37	61	238	13	85	-	15	44
Булган	958	835	570	874	1 262	260	218	237	250	527
Орхон	524	607	68	263	252	109	171	22	29	66
Өвөрхангай	281	219	123	182	229	95	71	21	46	51
Хөвсгөл	278	88	350	262	558	102	21	179	140	199
Төвийн бүс	9 520	10 104	8 618	10 856	14 777	2 319	2 532	2 154	2 850	4 336
Говьсүмбэр	241	263	112	151	323	86	98	22	63	93
Дархан-уул	1 030	1 135	954	1 947	2 906	228	295	252	519	893
Дорноговь	240	194	195	159	179	78	87	112	63	50
Дундговь	130	90	71	46	131	38	45	31	11	76
Өмнөговь	163	149	81	140	167	57	62	11	49	48
Сэлэнгэ	4 559	3 868	3 084	4 069	6 472	1 277	1 234	1 028	1 444	1 971
Төв	3 157	4 405	4 121	4 344	4 599	555	711	698	701	1 205
Зүүн бүс	1 347	1 280	1 506	2 059	1 968	546	412	551	744	495
Дорнод	542	655	423	849	701	194	219	122	282	214
Сүхбаатар	157	80	141	177	194	57	26	54	52	59
Хэнтий	648	545	942	1 033	1 073	295	167	375	410	222
Улаанбаатар	17 946	13 590	8 983	9 084	10 265	2 834	2 098	1 213	1 425	1 519


Өсгөн үржүүлж байгаа гахайны 33.6 хувь нь Улаанбаатар хотод, 48.3 хувь нь Төвийн бүсэд, 6.4 хувь нь Зүүн бүсэд, 9.6 хувь нь Хангайн бүсэд, 2.1 хувь нь Баруун бүсэд ногдож байна. Шувууны 43.7 хувь нь Төвийн бүсэд, 52.9 хувь Улаанбаатар хотод байна.

ХҮСНЭГТ 59. ТЭЖЭЭВЭР АМЬТАД, бүс, аймаг, нийслэлээр /Хүснэгт 62. үргэлжлэл/

Бүс, аймаг, нийслэл	Цууу					Өндөглөгч				
	2017	2018	2019	2020	2021	2017	2018	2019	2020	2021
	толгой									
Бүгд	705 085	886 031	898 716	997 152	1 158 371	443 508	672 324	675 859	811 159	945 916
Баруун бүс	6 302	748	844	1 730	4 586	6 175	596	681	1 624	4 358
Баян-Өлгий	580	216	120	245	191	509	158	93	226	175
Говь-Алтай	82	41	70	20	20	66	12	57	18	18
Завхан	148	126	436	1 118	4 012	136	117	390	1 100	3 840
Увс	42	200	218	277	323	39	168	141	235	290
Ховд	5 450	165	-	70	40	5 425	141	-	45	35
Хангайн бүс	6 406	5 328	9 145	14 209	21 558	3 123	3 742	8 417	13 630	20 807
Архангай	68	80	34	64	6 020	47	67	32	53	6 018
Баянхонгор	1 994	127	80	4 033	4 097	174	117	75	4 030	4 097
Булган	1 907	3 333	6 592	8 001	9 335	1 034	2 237	6 217	7 708	9 010
Орхон	1 372	1 024	1 269	1 222	1 291	1 052	745	1 043	1 025	1 082
Өвөрхангай	549	462	150	199	169	493	387	105	172	142
Хөвсгөл	516	302	1 020	690	646	323	189	945	642	458
Төвийн бүс	165 695	338 574	314 928	371 519	506 076	159 940	279 945	296 591	366 616	405 334
Говьсүмбэр	2 996	54	381	170	144	2 846	42	327	143	106
Дархан-Уул	10 831	9 476	16 437	15 458	25 713	10 140	3 955	5 571	14 576	24 453
Дорноговь	1 608	2 242	5 852	5 751	28 604	1 479	2 134	1 441	5 645	15 761
Дундговь	76	46	68	46	51	57	38	59	29	32
Өмнөговь	257	78	138	625	1 222	204	60	91	541	1 095
Сэлэнгэ	11 443	11 130	12 300	12 459	14 719	8 986	8 582	9 865	10 250	11 910
Төв	138 484	315 548	279 752	337 010	435 623	136 228	265 134	279 237	335 432	351 977
Зүүн бүс	14 843	6 625	6 947	16 204	13 834	14 195	6 028	6 365	15 091	12 877
Дорнод	13 906	6 202	6 723	12 832	11 281	13 339	5 716	6 168	12 003	10 579
Сүхбаатар	114	96	74	153	808	93	75	63	123	733
Хэнтий	823	327	150	3 219	1 745	763	237	134	2 965	1 565
Улаанбаатар	511 839	534 756	566 852	593 490	612 317	260 075	382 013	363 805	414 198	502 540




ХӨДӨӨ АЖ АХУЙН ЭДЭЛБЭР ГАЗАР, сая га



МАЛЫН ТЭЖЭЭЛ, мянган тонн, төрлөөр



БЭЛТГЭСЭН БУСАД ТЭЖЭЭЛ, мянган тонн, төрлөөр



V. БЭЛЧЭЭРИЙН ХҮРЭЛЦЭЭ

V.1. Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж

Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн газрын 2021 оны газрын нэгдмэл сангийн тайланд манай улсын хадлан, бэлчээрийн талбай 111.3 сая га байгаа нь өмнөх оноос 0.1 сая га-гаар буурсан байна.


Нийт малыг хонин толгойд шилжүүлснээр 2021 онд 100 га хадлан, бэлчээрийн талбайд 106 толгой мал ногдож байгаа нь өмнөх оноос 3-аар өссөн байна.

ХҮСНЭГТ 60. БЭЛЧЭЭРИЙН ХҮРЭЛЦЭЭ ХАНГАМЖ

	2017	2018	2019	2020	2021
Хадлан, бэлчээрийн талбай, сая га	112.1	112.1	112.0	111.4	111.3
Хонин толгойд шилжүүлсэн малын тоо, сая тол	110.8	111.1	119.0	114.4	117.6
100 га бэлчээр хадлангийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо	99	99	106	103	106

Сүүлийн 5 жилд хадлан бэлчээрийн талбай 2017-2021 онд 0.1-0.7 сая га-гаар багасаж, хонин толгойд шилжүүлсэн нийт малын тоо 2017 оноос 6.8 сая толгойгоор өссөн бол 2021 онд өмнөх оноос 6.6 сая толгойгоор өссөн байна.

ЗУРАГ 54. 100 ГА БЭЛЧЭЭРИЙН ТАЛБАЙД НОГДОХ ХОНИН ТОЛГОЙД ШИЛЖҮҮЛСЭН МАЛЫН ТОО




Сүүлийн 18 жилд буюу 2003-2021 онд хадлан, бэлчээрийн талбай 113.1-111.3 сая га болж 1.8 сая га-гаар багасаж, хонин толгойд шилжүүлсэн нийт малын тоо 46.2-117.6 сая толгой болж 71.4 саяар буюу 1.5 дахин өссөн.

100 га бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо Ховд, Баян-Өлгий, Өвөрхангай, Говьсүмбэр, Увс, Төв, Хэнтий, Сэлэнгэ, Хөвсгөл, Булган, Архангай, Дархан-Уул, Улаанбаатар хот, Орхон аймгуудад улсын дунджаас 107.0-896.9 өндөр байна.

Харин Өмнөговь, Дорноговь, Говь-Алтай, Дорнод, Баянхонгор, Дундговь, Завхан, Сүхбаатар, аймагт улсын дунджаас доогуур байна. Дээрх байдлаас үзэхэд төвлөрсөн хот, суурин газар, мал ихтэй бүс нутаг, аймагт бэлчээрийн даац хэтэрсэн байна.

ЗУРАГ 55. 100 ГА ХАДЛАН, БЭЛЧЭЭРИЙН ТАЛБАЙД НОГДОХ ХОНИН ТОЛГОЙД ШИЛЖҮҮЛСЭН МАЛЫН ТОО, толгой



V.2. Малын тэжээлийн үйлдвэрлэл, хангамж

Малчид, аж ахуйн нэгжүүдийн 2021 онд үйлдвэрийн аргаар боловсруулснаас бусад гар аргаар бэлтгэсэн тэжээлийн хэмжээ, тэжээлийн нэгжид шилжүүлснээр 1109.3 мянган тонн тэжээл үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 49.0 хувь буюу 364.9 мянган тонноор өссөн байна.

Өмнөх онтой харьцуулахад байгалийн хадлан 534.4 мянган тонн буюу 45.1 хувиар, бэлтгэсэн дарш 1.6 мянган тонн буюу 19.6 хувиар, эрдэс тэжээл 52.0 мянган тонн буюу 57.5 хувиар, гар тэжээл 21.4 мянган тонн буюу 50.8 хувиар тус тус өссөн бол, сүрэл 0.5 мянган тонн буюу 10.5 хувиар буурчээ.

ХҮСНЭГТ 61. БЭЛТГЭСЭН ТЭЖЭЭЛ, нэр төрлөөр

	2017	2018	2019	2020	2021
	мянган тонн				
Бэлтгэсэн хадлан	1 008.1	1 229.4	1 369.2	1 186.2	1 720.6
Ашигласан сүрэл	8.5	10.6	9.4	5.2	4.6
Гар тэжээл	52.3	51.7	58.4	42.2	63.6
Бэлтгэсэн дарш	1.5	5.0	23.0	8.0	9.6
Бэлтгэсэн эрдэс тэжээл	77.9	94.6	121.3	90.5	142.5
Үйлдвэрлэсэн тэжээл-бүгд, (тэж.нэгж)	611.5	757.4	849.7	744.4	1 109.3

Бэлтгэсэн хадланг аймгаар авч үзвэл, Говьсүмбэр, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Дундговь, Баянхонгор аймгуудад өмнөх оноос 0.1-8.5 мянган тонноор буурсан байна. Бусад аймгуудад 2.1-117.4 мянган тонноор өсчээ.

ХҮСНЭГТ 62. БЭЛТГЭСЭН ТЭЖЭЭЛ, бүс, аймаг, нийслэлээр

Бүс, аймаг, нийслэл	2017	2018	2019	2020	2021
	мянган тонн				
БҮГД	611.5	757.4	849.7	744.4	1 109.3
Баруун бүс	122.4	134.7	153.9	137.7	229.3
Баян-Өлгий	33.3	38.4	53.8	47.3	52.2
Говь-Алтай	8.2	9.3	9.4	9.9	7.8
Завхан	11.0	10.4	12.7	11.2	16.2
Увс	32.2	33.5	39.8	35.8	42.3
Ховд	37.6	43.1	38.2	33.5	110.9
Хангайн бүс	178.4	249.4	297.0	225.5	299.6
Архангай	32.3	37.0	41.1	32.0	43.7
Баянхонгор	9.9	9.5	7.4	10.4	8.5
Булган	35.9	50.9	53.1	58.6	69.1
Орхон	3.6	4.3	5.0	4.9	6.3
Өвөрхангай	28.3	40.8	49.0	31.7	48.5
Хөвсгөл	68.4	106.8	141.4	88.0	123.6
Төвийн бүс	183.2	229.2	229.7	237.8	349.6
Говьсүмбэр	2.0	2.7	1.7	1.6	1.8
Дархан-Уул	24.5	27.8	18.2	15.8	30.1
Дорноговь	3.9	3.9	4.2	7.4	9.1
Дундговь	9.6	10.0	9.3	6.2	9.3
Өмнөговь	7.6	8.4	6.8	5.4	5.8
Сэлэнгэ	68.7	87.0	111.4	106.8	144.2
Төв	66.9	89.3	78.1	94.6	149.4
Зүүн бүс	109.8	124.4	148.5	122.8	191.4
Дорнод	30.2	39.5	52.1	48.7	59.8
Сүхбаатар	20.7	14.6	30.7	16.4	17.7
Хэнтий	58.9	70.3	65.6	57.7	114.0
Улаанбаатар	17.5	19.8	20.6	20.6	39.3

Тэжээл бэлтгэлтийн хэмжээг /тэжээлийн нэгжээр/ аймгаар нь авч үзвэл, Баянхонгор, Говь-Алтай аймгуудад өмнөх оноос 1.9-2.1 мянган тонноор буурсан байна. Бусад аймгуудад 0.3-77.4 мянган тонноор өссөн байна.

ХҮСНЭГТ 63. ҮЙЛДВЭРЛЭСЭН ТЭЖЭЭЛИЙН ХАНГАМЖ

	2017	2018	2019	2020	2021
Хонин толгойд шилжүүлсэн мал, мянган толгой	110 801.8	111 131.5	118 987.5	114 411.4	117 572.1
Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл, тэжээлийн нэгж, кг	5.5	6.8	7.1	6.5	9.4

Энэ онд хонин толгойд шилжүүлсэн малын тоо 117572.1 мянган толгой болж өмнөх оноос 3160.7 мянган толгой буюу 2.8 хувиар өссөн байна. 2021 онд хонин толгойд шилжүүлсэн нэг малд 9.4 кг тэжээл ногдож, 2020 оноос 2.9 кг буюу 45.3 хувиар өссөн байна.

V.3. Хашаа, худгийн тооллого

ҮСХ-ноос хашаа, худгийн тооллогыг 3 жил тутамд жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллоготой хамтатган явуулж байна. 2021 оны тооллогоор хүн, мал ундаалах зориулалт бүхий 62.5 мянган худаг, 378 усан сан тоологдлоо.

Тоологдсон худгийн 47.8 хувь буюу 29.9 мянга нь инженерийн хийцтэй худаг байна. Нийт худгийн 37.0 хувь буюу 23.1 мянган худаг нь бэлчээрт байршилтай байна.

ХҮСНЭГТ 64. ХУДАГ, УСАН САНГИЙН ТОО, тооллого явагдсан оноор

	2012	2015	2018	2021
	мянган ширхэг			
Худаг – бүгд	29.5	42.1	48.4	62.5
Инженерийн хийцтэй	8.1	15.4	19.1	29.9
Энгийн уурхайн	21.4	26.7	29.3	32.7
Бэлчээрт байршилтай	21.5	21.7	18.8	23.1
Ашиглагддаггүй	0.6	1.1	0.3	0.3
Усан сан	0.2	0.3	0.6	0.4
Багтаамж /мянган м ³ /	98.8	109.8	15.7	4.6

Энэ онд 82.9 сая толгой малын багтаамж бүхий 249.9 мянган хашаа тоологдсон байна. Нийт тоологдсон хашааны 20.3 хувь буюу 50.8 мянга нь 10.2 сая малын багтаамжтай дулаан байр, 53.5 хувь буюу 133.8 мянга нь 47.9 сая малын багтаамжтай саравчтай хашаа, 26.1 хувь буюу 65.3 мянга нь 24.9 сая малын багтаамжтай саравчгүй хашаа тус тус байна. Нийт хашааны 8.1 хувь буюу 20.3 мянга нь 3.7 сая малын багтаамжтай бод малын хашаа байна.

ХҮСНЭГТ 65. МАЛЫН ХАШААНЫ ТОО, ХАНГАМЖ, тооллого явагдсан оноор

	2012	2015	2018	2021
	мянган ширхэг			
Хашаа-бүгд	167.1	209.0	222.5	249.9
Багтаамж /сая толгой/	55.2	66.8	76.7	82.9
Дулаан байр	20.1	33.6	42.5	50.8
Багтаамж /сая толгой/	3.6	6.1	8.2	10.2
Саравчтай хашаа	102.5	119.1	122.9	133.8
Багтаамж /сая толгой/	35.5	40.1	46.1	47.9
Саравчгүй хашаа	44.4	56.4	57.2	65.3
Багтаамж /сая толгой/	16.1	20.6	22.4	24.9
Нийт хашаанаас				
Бодын	31.7	21.9	23.2	20.3
Багтаамж /сая толгой/	7.8	3.7	4.0	3.7
Хашааны хангамж:				
Бог малын /хувь/	132.9	130.1	133.0	137.7
Бод малын /хувь/	148.5	97.2	91.4	73.2

V.4. Мал эмнэлгийн үйлчилгээ

Мал эмнэлгийн ерөнхий газрын мэдээгээр 2021 онд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд давхардсан тоогоор 41.7 сая толгой мал хамрагдаж, нэг малд 165.9 төгрөг, лабораторийн оношилгоо, шинжилгээнд давхардсан тоогоор 0.9 сая толгой мал хамрагдаж, нэг малд 2.4 мянган төгрөг, гоц халдварт өвчнөөс сэргийлэх

вакцинжуулалтад давхардсан тоогоор 26.2 сая толгой мал хамрагдаж, нэг малд 604.8 төгрөгийг тус тус зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 66. МАЛ ЭМНЭЛГИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭ

	2017	2018	2019	2020	2021
Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ					
Хамрагдсан малын тоо, мян.тол	31 572.3	32 165.1	37 696.1	39 187.0	41 743.2
Зарцуулсан зардал, сая төгрөг	5 748.3	5 391.4	5 570.5	5 286.0	6 928.1
1 малд ногдох зардал, төг	182.0	167.6	147.7	134.8	165.9
Лабораторийн оношилгоо, шинжилгээ					
Хамрагдсан малын тоо, мян.тол	529.9	552.1	520.6	542.0	986.3
Зарцуулсан зардал, сая төгрөг	858.7	905.3	912.4	1 060.7	2 389.2
1 малд ногдох зардал, төг	1 620.5	1 639.7	1 753.0	1 957.0	2 422.4
Гоц халдварт өвчний вакцинжуулалтын зардал					
Хамрагдсан малын тоо, мян.тол	47 868.3	36 701.7	30 905.5	32 080.7	26 232.8
Зарцуулсан зардал, сая төгрөг	17 056.5	12 780.0	21 026.0	14 549.1	15 907.0
1 малд ногдох зардал, төг	356.3	348.2	680.3	453.5	604.8

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газар

V.5. Малын индексжүүлсэн даатгалын үйлчилгээ

Үндэсний статистикийн хороо нь Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн Банктай хамтран 2005 оны 7-р сараас эхлэн "Малын Индексжүүлсэн Даатгал" (МИД) төслийг Хэнтий, Баянхонгор, Увс аймгуудад хэрэгжүүлснээс хойших хугацаанд уг төслийн нэгжтэй хамтран ажиллаж байсан. Үндэсний Статистикийн Хороо нь 2015 оноос эхлэн Статистикийн тухай хууль болон Малын Индексжүүлсэн Даатгал (МИД)-ын хуулийн дагуу хагас жилийн малын түүвэр судалгааг албан ёсоор явуулж эхэлсэн.

Ийнхүү ҮСХ нь малчдад олгох даатгалын нөхөн төлбөрийн хэмжээг тооцоход шаардагдах мэдээллээр хангах зорилгоор хагас жилийн малын түүвэр судалгааг улсын хэмжээнд зохион байгуулдаг.

ХҮСНЭГТ 67. ДААТГАЛД ХАМРАГДСАН ӨРХ, малын тоо

	2017	2018	2019	2020	2021
Даатгуулсан өрхийн тоо	24 148.0	33 719.0	32 337	28 527.0	34 709.0
Малчин өрхөд эзлэх хувь	14.2	11.7	18.8	15.8	18.4
Даатгуулсан малын тоо, мян.тол	5 686.4	7 835.3	7 462.4	7 109.4	7 400.0
Оны эхний малд эзлэх хувь	9.3	11.8	11.2	10.0	11.0
Даатгалд төлсөн хураамж, сая.төг	2 329.1	3 642.7	3 845.7	3 478.5	3 922.0
Даатгалаас олгосон нөхөн олговор, сая.төг	1 092.0	323.3	600.9	2 593	2 600


Эх сурвалж: Үндэсний давхар даатгар ХК

Үндэсний давхар даатгал ХК-ний мэдээгээр 2021 онд 34.7 мянган өрхийн 7.4 сая толгой малыг индексжүүлсэн даатгалд хамруулсан байна. Даатгуулсан өрх 2021 онд нийт малчин өрхийн 18.4 хувийг эзэлж, 2020 оноос 22 хувиар буюу 6.1 мянган өрхөөр өссөн байна.

Мөн 2021 онд оны эхний малын 11.0 хувьтай тэнцэх 7.4 сая толгой малыг даатгалд хамруулсан нь 2020 оноос 290.6 мянган толгой буюу 4.0 хувиар өссөн байна.


Малын индексжүүлсэн даатгалд даатгуулсан 34.7 мянган өрх 3.9 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг төлсөн нь өмнөх оноос 12.7 хувь буюу 441.5 сая төгрөгөөр өссөн байна. Нийт 9446 малчин өрхөд, 2600 сая төгрөгийн нөхөн олговрыг 2021 онд олгожээ.

ЗУРАГ 56. МИД-ЫН ОЛГОСОН НӨХӨН ТӨЛБӨР, сая.төг





МОНГОЛ УЛС МАЛЫН ТООГООР ДЭЛХИЙД, эзлэх байраар, сая толгой



VI. ДЭЛХИЙН МАЛЫН ТОО

НҮБ-ын ХХААБ-ын мэдээллийн санд 2020 оны байдлаар дэлхийн хэмжээнд 59.9 сая адуу, 1525.9 сая үхэр, 38.6 сая тэмээ, 1263.1 сая хонь, 1128.1 сая ямаа, нийт 4015.6 сая толгой мал байна.

ХҮСНЭГТ 68. ДЭЛХИЙН МАЛЫН ТОО, малын тоо

	2015	2016	2017	2018	2019	2020
	сая толгой					
Бүгд	3 716.4	3 774.9	3 796.6	3 838.4	3 940.4	4 015.6
Адуу	57.3	58.1	58.1	57.8	59	59.9
Үхэр	1 449.1	1 468.4	1 473.3	1 489.7	1 511.0	1 525.9
Тэмээ	33.1	33.9	34.8	35.5	37.5	38.6
Хонь	1 179.3	1 192.7	1 201.1	1 209.5	1 238.7	1 263.1
Ямаа	997.7	1 021.7	1 029.3	1 045.9	1 094.1	1 128.1
	дүнд эзлэх хувь					
Бүгд	100	100	100	100	100	100
Адуу	1.6	1.5	1.5	1.5	1.5	1.5
Үхэр	39.3	39	38.9	38.8	38.8	38
Тэмээ	0.9	0.9	0.9	0.9	0.9	1.0
Хонь	31.4	31.7	31.6	31.6	31.5	31.5
Ямаа	26.9	26.8	27.1	27.1	27.2	28.1

Эх үүсвэр: НҮБ-ын ХХААБ-ын мэдээлэл

Дэлхийн түвшинд, таван хошуу малын сүргийн бүтцийг авч үзвэл, нийт малын 1.5 хувийг адуу, 38 хувийг нь үхэр, 1.0 хувийг тэмээ, 31.5 хувийг нь хонь, 28.1 хувийг ямаа эзэлж байна.

Манай орны хувьд хонь, ямаа буюу бог мал нийт малын 85.4 хувийг эзэлж байгаа бол дэлхийн хэмжээнд үхэр сүрэг 1.5 тэрбум толгойгоор тоологдож, нийт малын 38.0 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт байна.

Дэлхийн нийт малын 40.5 хувь нь Ази тивд, 33 хувь нь Африк тивд, 17.2 хувь нь Америк тивд, 6.2 хувь нь Европ тивд, 3.2 хувь нь Австрали тив болон далайн орнуудад байна.

ХҮСНЭГТ 69. ДЭЛХИЙН МАЛЫН ТОО, бүс, нутгаар

	2015	2016	2017	2018	2019	2020
	сая толгой					
Дэлхий	3 716.4	3 774.9	3 796.6	3 838.4	3 940.4	4 000.1
Африк	1 134.8	1 168.0	1 188.6	1 215.0	1 267.8	1 319.2
Америк	663.7	670.9	672.4	675.6	682.3	686.3
Ази	1 500.1	1 525.7	1 519.3	1 537.0	1 591.5	1 619.4
Европ	275.3	275.1	275.4	272	266	247.8
Австрали	142.4	135.3	140.9	138.8	131.7	127.4
	дүнд эзлэх хувь					
Дэлхий	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Африк	30.5	30.9	31.3	31.7	32.2	33.0
Америк	17.9	17.8	17.7	17.6	17.3	17.2
Ази	40.4	40.4	40	40	40.4	40.5
Европ	7.4	7.3	7.3	7.1	6.8	6.2
Австрали	3.8	3.6	3.7	3.6	3.3	3.2

Монгол Улс 2020 оны байдлаар дэлхийд адууны тоогоор 4 дүгээрт, тэмээний тоогоор 11, хонины тоогоор 13, ямааны тоогоор 10 дүгээрт, үхрийн тоогоор 52 дугаарт эрэмбэлэгдэж байна.

ХҮСНЭГТ 70. ДЭЛХИЙН МАЛЫН ТОО, 2020 ОН

д/д	Улсын нэр	Адууны тоо	д/д	Улсын нэр	Үхрийн тоо	д/д	Улсын нэр	Тэмээний тоо
	сая толгой							
1	АНУ	10.5	1	Бразил	218,1	1	Чад	8.8
2	Мексик	6.3	2	Энэтхэг	194.4	2	Сомали	7.3
3	Бразил	5.9	3	АНУ	93.7	3	Судан	4.9
4	Монгол	4	4	БНХАУ	61.1	4	Кени	4.6
5	БНХАУ	3.6	5	Этиоп	70.29	5	Нигери	1.8
6	Казахстан	3,1	6	Хятад	61,1	6	Мавритан	1.5
7	Этиоп	2.1	7	Пакистан	49,6	7	Этиоп	1.6
8	Колумб	1.5	8	Мексик	35.6	8	Мали	1.2
9	Чад	1.3	9	Чад	32,2	9	Пакистан	1.1
10	Колумб	1.1	10	Судан	31,7	10	Сауди Араб	0.5
11	Куба	0.9	11	Колумб	28,2	11	Монгол	0.47
12	Судан	0.7	12	Бангладеш	24,3	12	Иемен	0.4
13	Перу	0.7	13	Австрали	23,5	13	Алжир	0.4
14	Мали	0.5	52	Монгол	4.7	14	Хятад	0.4

үргэлжлэл


д/д	Улсын нэр	Хонины тоо	д/д	Улсын нэр	Ямааны тоо
	сая толгой				
1	БНХАУ	173	1	Энэтхэг	150.2
2	Энэтхэг	68	2	БНХАУ	133.5
3	Австрали	63.5	3	Нигери	83.7
4	Нигери	47.7	4	Пакистан	78.2
5	Иран	46.5	5	Бангладеш	60
6	Этиоп	42.9	6	Чад	52.4
7	Турк	42.1	7	Кени	41.1
8	Судан	40.9	8	Судан	32,2
9	Чад	38.7	9	Мали	27.8
10	Их Британи	32.6	10	Монгол	27.7
11	Пакистан	31.2	11	Индонези	19
12	Алжир	30	12	Нигер	18.8
13	Монгол	26	13	Иран	16.6
14	Шинэ Зеланд	25.3	14	Буркино Фасо	16.4
15	Кени	25.3	15	Уганда	15.4
16	Морокко	22	16	Нефал	12.8
17	Бразил	20	17	Бразил	12.1
18	Мали	20	18	Турк	11.9
19	Узбекистан	18	19	Сомали	11.5



Тариалан эрхэлдэг өрх, ААНБ-ын тоо



ХУРААСАН НИЙТ УРГАЦ, ургамлын төрлөөр, мянган тонн



VII. ГАЗАР ТАРИАЛАН

VII.1. Газар тариалангийн салбарын түүхэн тойм

Манай улсад атрын анхны аян өрнөсөн 1959 оноос өмнө хөдөө аж ахуйд газар тариалан бие даасан салбар болж чадаагүй, хязгаарлагдмал тооны хүмүүс хувийн аж ахуйдаа туслах үйлдвэрлэлийн чанартай эрхэлдэг, ердийн хөсөг бүхий зүтгэх хүчтэй, хоцрогдсон багаж хэрэгслэл бүхий гар ажиллагаа зонхилсон үйлдвэрлэл байв. Тухайн үед малчид, иргэд өөрсдийн хэрэгцээндээ гол төлөв арвай, хөх тариа тариалдаг байсан бөгөөд 1950-иад оны үед буудайн тариалалт, хураасан ургацын хэмжээ нь үр тарианы дөнгөж 30-аад хувийг эзэлж байжээ. 1950 онд улсын хэмжээгээр 51.4 мян.га-д үр тариа тариалж байсан нь өнөө үеийн үр тарианы төрөлжсөн хоёр томоохон аж ахуйн эргэлтийн талбайн хэмжээтэй ойролцоо юм.

Манай улсад 1959 онд анх удаа атар газар эзэмших шийдвэр гарч атрын олон сангийн аж ахуй, гурилын үйлдвэрүүд байгуулагдсанаар газар тариалангийн хөгжилд чанарын өөрчлөлт гарч, эх орны гурилын хэрэгцээг дотооддоо хангах нөхцөл бүрдсэн. 1959-1961 онд хэрэгжүүлсэн атрын анхны аянаар 345.0 мян.га атар газар шинээр эзэмшжээ. Атрын анхны аяны дараа жил буюу 1962 онд 1950 онтой харьцуулбал үр тарианы тариалсан талбай 7.4 дахин, хураасан ургац 11 дахин, төмс, хүнсний ногооны ургац хураалт 3.5-4.1 дахин нэмэгдсэн байна.

Атрын хоёр дахь аяныг (1976-1978 он) хэрэгжүүлснээр газар тариалангийн бүтээгдэхүүнээр эх орныхоо дотоод хэрэгцээг хангаад зогсохгүй улмаар экспортод гаргах болов. Ялангуяа 1980-аад оны сүүлийн хагаст ургац хураалтын арвин амжилтаар дүүрэн жилүүд байлаа. 1983-1989 онд жил бүр 800 мянгаас дээш тонн үр тариа хураан авч, Монголд нэг сая тонн үр тариа хураахад бодит ажил болоход ойртон очсон юм. Үүнээс 1985 онд 886.2 мян.тн үр тариа, 1989 онд 155.5 мян.тн төмс хураасан нь одоо хүртэл дээд амжилтын үзүүлэлт болж статистикийн тоо баримтад тэмдэглэгдэн үлджээ. 1989 онд 673.4 мян.га-д үр тариа, 1988 онд 13.1 мян.га-д төмс тариалсан нь хамгийн их талбайд тариалсан он жилүүд болов.

Атрын гурав дугаар аяныг (2008-2010 он) бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж дотоодын хэрэгцээгээ хангах, шинэ техник, технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх зорилгоор эхлүүлэв. Атрын энэ аяны хүрээнд 2010 онд 345.5 мянган тонн улаанбуудай, 168.0 мян.тн төмс, 82.3 мян.тн хүнсний ногоо хураан авсан нь аяны өмнөх жил болох 2007 оноос улаанбуудай 235.9 мян.тн оор буюу 2.2 дахин, төмс 53.5 мян.тн оор буюу 46.8 хувиар, хүнсний ногоо 5.8 мян.тн оор буюу 7.6 хувиар тус тус өссөн байна.

Харин атрын дөрөвдүгээр аяныг 2020 оны 1-р сарын 1-нээс эхлэхээр зарлав. Аяны хүрээнд хөрсний элэгдэл, эвдрэл, үржил шимийн доройтлыг сааруулах, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон газар тариалан хөгжүүлэх, эрсдэл даах чадамжийг дээшлүүлэх, агроэкоосистемийн тогтвортой байдлыг хангаж хүнсний хэрэгцээ, түүний аюулгүй байдлыг хангахаар шийдвэрлэх юм.


Улсын хэмжээнд 2021 онд үр тариа 614.5 мянган тн, таримал тэжээл 293.7 мянган тн, төмс 182.6 мянган тн, хүнсний ногоо 121.7 мянган тн, техникийн ургамал 52.3 мянган тн, жимс жимсгэнэ 2.4 мянган тн тус тус хураасан нь өмнөх оноос үр тариа 184.2 мянган тн-оор (42.8%), таримал тэжээл 111.6 мянган тн-оор (61.3%), техникийн ургамал 29.7 мянган тн-оор (131.4%), жимс жимсгэнэ 0.8 мянган тн-оор (50.0%), хүнсний ногоо 0.5 мянган тн-оор (0.4%) тус тус өссөн бол төмс 61.7 мянган тн-оор (25.2%) буурсан байна.

VII.2. Газар тариалан эрхэлсэн өрх, аж ахуй нэгж байгууллага

Манай улсад 2021 оны эцэст нийт 920.2 мянган өрх бүртгэгдсэний 17.5 мянган өрх буюу 1.9 хувь нь тариалан эрхэлсэн өрх байна.

Улсын хэмжээний нийт өрхөд тариалан эрхэлсэн өрхийн эзлэх хувь 2017-2019 онд 1.8-аас 1.6 болж буурч байсан бол 2020-2021 онд эзлэх хувь 1.8-1.9 хувь болж өссөн байна.

ЗУРАГ 57. УЛСЫН ХЭМЖЭЭНИЙ НИЙТ ӨРХӨД ТАРИАЛАН ЭРХЭЛСЭН ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ



Газар тариалан эрхэлсэн өрхийн тоо 2021 онд 17.5 мянга болж өмнөх оноос 1.2 мянга буюу 7.2 хувиар, аж ахуйн нэгж, байгууллагын тоо 1.6 мянга болж өмнөх оноос 117 буюу 7.8 хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 71. ТАРИАЛАН ЭРХЭЛСЭН ӨРХ, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА, бүс, аймаг, нийслэлээр


Бүс, аймаг, нийслэл	2017		2018		2019		2020		2021	
	Өрх	ААНБ	Өрх	ААНБ	Өрх	ААНБ	Өрх	ААНБ	Өрх	ААНБ
Бүгд	15 985	1 447	15 862	1 422	14 728	1 401	16 292	1 498	17 459	1 615
Баруун бүс	3 166	201	3 239	185	2 850	154	2 910	219	4 014	224
Баян-Өлгий	763	40	721	36	550	31	623	40	617	42
Говь-Алтай	259	36	281	25	259	25	291	17	365	18
Завхан	372	46	411	38	400	32	405	49	1 328	56
Увс	885	62	966	68	782	50	800	94	1 037	105
Ховд	887	17	860	18	859	16	791	19	667	3
Хангайн бүс	3 239	327	2 911	295	2 814	305	3 303	313	3 516	344
Архангай	270	44	300	43	273	45	289	47	370	49
Баянхонгор	269	50	229	21	242	19	233	24	322	26
Булган	662	96	512	94	581	100	699	102	773	113
Орхон	923	11	688	14	757	13	884	11	462	14
Өвөрхангай	628	79	722	73	559	74	669	83	835	87
Хөвсгөл	487	47	460	50	402	54	529	46	754	55
Төвийн бүс	6 834	755	6 785	758	6 352	768	7 249	777	6 959	835
Говьсүмбэр	23	10	30	6	44	9	31	7	23	6
Дархан-Уул	737	65	649	65	509	64	412	56	398	72
Дорноговь	108	18	131	21	101	20	113	11	129	16
Дундговь	109	17	146	13	87	24	116	30	179	19
Өмнөговь	379	24	382	25	302	22	322	14	219	17
Сэлэнгэ	3 703	334	3 386	318	3 312	322	3 698	322	3 397	336
Төв	1 775	287	2 061	310	1 997	307	2 557	337	2 614	369
Зүүн бүс	1 290	129	1 471	127	1 323	126	1 579	131	1 668	156
Дорнод	562	49	689	44	623	41	786	41	796	54
Сүхбаатар	200	34	205	36	184	38	171	37	212	36
Хэнтий	528	46	577	47	516	47	622	53	660	66
Улаанбаатар	1 456	35	1 456	57	1 389	48	1 251	58	1 302	56

Тариалан эрхэлсэн өрхийн 19.5 хувь нь Сэлэнгэ аймагт, 15.0 хувь нь Төв аймагт, 7.6 хувь нь Завхан аймагт, 7.5 хувь нь Улаанбаатар хотод, 5.9 хувь нь Увс аймагт, 4.8 хувь нь Өвөрхангай аймагт байна.

Тариалан эрхэлсэн өрхийн тоог аймгаар өмнөх онтой харьцуулж авч үзвэл, Орхон аймагт 422 өрхөөр буюу 47.7 хувиар, Сэлэнгэ аймагт 301 өрх буюу 8.1 хувиар, Ховд аймагт 124 өрх буюу 15.7 хувиар, Өмнөговь аймагт 103 өрх буюу 32.0 хувиар, Дархан-Уул аймагт 14 өрх буюу 3.4 хувиар, Говьсүмбэр аймагт 8 өрх буюу 25.8 хувиар, Баян-Өлгий аймагт 6 өрх буюу 1.0 хувиар тус тус буурч, бусад аймагт 10-923 өрхөөр буюу 1.3 хувиас 3.3 дахин өссөн байна.

Тариалан эрхэлсэн хамгийн олон өрхтэй аймаг нь Сэлэнгэ аймаг буюу 3397 өрхтэй бол тариалан эрхэлсэн хамгийн бага өрхтэй аймаг нь Говьсүмбэр аймаг буюу 23 өрхтэй байна.

ЗУРАГ 58. ТАРИАЛАН ЭРХЭЛСЭН ӨРХИЙН ТОО, 2021 ОН, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР




Харин тариалан эрхэлсэн аж ахуйн нэгж, байгууллагын 22.8 хувь нь Төв аймагт, 20.8 хувь нь Сэлэнгэ аймагт, 7.0 хувь нь Булган аймагт, 6.5 хувь нь Увс аймагт, 5.4 хувь нь Өвөрхангай аймагт байна.

Тариалан эрхэлсэн аж ахуй нэгж, байгууллагын тоог аймгаар авч үзвэл, Ховд аймагт 16 ААНБ буюу 84.2 хувиар, Дундговь аймагт 11 ААНБ буюу 36.7 хувиар, Улаанбаатар хот 2 ААНБ буюу 3.4 хувиар, Говьсүмбэр аймагт 1 ААНБ буюу 14.3 хувиар, Сүхбаатар аймагт 1 ААНБ буюу 2.7 хувиар буурч, харин бусад аймагт 1-32 ААНБ-аар буюу 5.9-45.5 хувиар өссөн байна.

Тариалан эрхэлсэн хамгийн олон ААНБ-тай аймаг нь Төв аймаг буюу 369 ААНБ-тай бол тариалан эрхэлдэг хамгийн бага ААНБ-тай аймаг нь Ховд 3 ААНБ-тай байна.

ЗУРАГ 59. ТАРИАЛАН ЭРХЭЛСЭН АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, 2021 ОН, аймаг, нийслэлээр



Улсын хэмжээнд 2021 оны байдлаар газар тариалан эрхэлсэн 17.5 мянган өрхөд 65.2 мянган хүн амьдарч нэг өрхөд дунджаар 4 хүн амьдардаг байна.

Нийт тариалан эрхэлсэн өрхийн 77.2 хувь нь 5.0 хүртэлх га талбайд тариалалт хийсэн бөгөөд тариалангийн талбайн хэмжээ ихсэх тусам тариалан эрхэлдэг өрхийн тоо буурч байна.

Тариалан эрхэлсэн өрхийн 1.4 мянга буюу 7.9 хувь нь 5.0-10.0 га-д тариалалт хийсэн бөгөөд нийт 5.5 мянган хүн дээрх бүлэгт хамаарах өрхөд амьдарч байна.

ХҮСНЭГТ 72. ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН АМ БҮЛ, НЭГ ӨРХӨД НОГДОХ ТАРИАЛСАН ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, 2021 ОН, тариалсан талбайн бүлэглэлтээр

Тариалсан талбайн бүлэглэлт, га	Тариалан эрхэлдэг өрхийн тоо	Тариалан эрхэлдэг өрхийн нийт ам бүл	Нэг өрхөд ногдох тариалсан талбай м.кв	Нийт тариалсан талбай га
Бүгд	17 459	65 165	135 416.3	236 423.3
0.01 хүртэлх	1 653	5 845	25.8	4.3
0.01-0.1	2 009	7 304	383.3	77.0
0.1-0.2	1 208	4 540	1 322.3	159.7
0.2-0.4	1 557	5 705	2 646.3	412.0
0.4-0.6	1 050	3 976	4 698.2	493.3
0.6-0.8	666	2 459	6 576.3	438.0
0.8-1.0	456	1 671	8 628.1	393.4
1.0-5.0	4 884	18 806	23 237.9	11 349.4
5.0-10.0	1 385	5 483	65 984.5	9 138.9
10.0-15.0	680	2 522	110 696.7	7 527.4
15.0-20.0	188	669	166 063.9	3 122.0
20.0-50.0	734	2 622	300 643.7	22 067.2
50.0-с дээш	989	3 563	1 832 564.9	181 240.7

¹Эх үүсвэр: Хүн ам өрхийн мэдээллийн сан, газар тариалангийн мэдээллийн сан

VII.3. Газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт

Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт 2021 оны байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 2734 ААНБ бизнес регистрийн санд бүртгэлтэй байгаагийн 1622 ААНБ буюу 59.3 хувь нь газар тариалангийн салбарт байна.

Хөдөө аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлийн 16.9 хувийг газар тариалангийн салбар эзэлж байна.

Газар тариалангийн салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 1470.7 тэрбум төгрөг, 2015 оны зэрэгцүүлэх үнээр 950.9 тэрбум төгрөгт хүрч, 2020 онтой харьцуулахад оны үнээр 561.8 тэрбум төгрөгөөр буюу 61.8 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр 202.6 тэрбум төгрөгөөр буюу 27.1 хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 73. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ

	2017	2018	2019	2020	2021
	тэрбум төг				
Тайлант оны үнээр	463.8	806.6	857.9	908.9	1 470.7
2015 оны зэрэгцүүлэх үнээр	468.5	686.5	717.4	748.4	950.9

Монгол Улсын ГЕГ, ҮСХ-ны албан ёсны статистик мэдээлэлд үндэслэн газар тариалангийн гол нэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тооцож үзэхэд, 2021 онд улсын хэмжээгээр 793.3 мянган тонн улаан буудай, 182.7 мянган тонн төмс, 197.4 мянган тонн хүнсний ногоог дотоодын зах зээлд нийлүүлэгдсэнээс төмсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр 99.9 хувь, улаан буудайн 71.4 хувь, хүнсний ногооны 61.7 хувийг хангаж, үлдсэн хувийг импортоор хангасан байна.

ХҮСНЭГТ 74. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН БҮТЭЭГ ДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, НИЙЛҮҮЛЭЛТ

	Нийт дотоодын зах зээлд нийлүүлэлт = дотоодын үйлдвэрлэл+импорт- экспорт					Дотоодын үйлдвэрлэл				
	2017	2018	2019	2020	2021	2017	2018	2019	2020	2021
	мянган тонн									
Улаан буудай	245.0	668.1	425.8	535.9	793.3	231.4	436.1	411.4	406.1	566.3
Төмс	121.6	171.8	192.6	244.3	182.7	121.8	168.9	192.2	244.3	182.6
Хүнсний ногоо	156.9	186.6	183.0	199.7	197.4	82.1	100.7	99.5	121.2	121.7

үргэлжлэл

	Импорт ¹					Экспорт ¹				
	2017	2018	2019	2020	2021	2017	2018	2019	2020	2021
	мянган тонн									
Улаан буудай	13.6	232.0	14.4	129.8	227.0	-	0.0	-	-	0.0
Төмс	0.4	2.9	0.4	0.0	0.1	0.6	-	-	-	0.0
Хүнсний ногоо	74.8	85.9	83.4	78.5	75.7	0.0	-	0.0	-	0.0

¹Эх үүсвэр: Гаалийн ерөнхий газрын мэдээлэл

ГЕГ-ын статистик мэдээгээр манай улс 2021 онд 227.0 мянган тонн улаан буудай, 75.7 мянган тонн хүнсний ногоо, 0.1 тонн төмс импортолсон нь 2020 оноос улаан буудай 97.2 мянган тонноор буюу 174.8 хувиар, төмс 0.1 мянган тонноор буюу 11.3 дахин тус тус өсөж, харин хүнсний ногоо 2.8 мянган тонноор буюу 3.5 хувиар буурсан байна.

Улаан буудайн нөөцөд дотоодын үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин өмнөх оноос оноос 4.4 нэгж хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 75. ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ НИЙТ НИЙЛҮҮЛЭЛТЭД, ИМПОРТЫГ ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛД ХАРЬЦУУЛСАН ХАРЬЦАА

	Дотоодын үйлдвэрлэл/Нийт дотоодын зах зээлд нийлүүлэлт					Импорт/ Нийт дотоодын зах зээлд нийлүүлэлт				
	2017	2018	2019	2020	2021	2017	2018	2019	2020	2021
	хувь									
Улаан буудай	94.5	65.3	96.6	75.8	71.4	5.9	53.2	3.5	32.0	40.1
Төмс	100.1	98.3	99.8	100.0	99.9	0.4	1.7	0.2	0.0	0.1
Хүнсний ногоо	52.3	54.0	54.4	60.7	61.7	91.1	85.3	83.8	64.7	62.2

Газар тариалангийн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн үнийн индекс 2021 онд өмнөх оноос хадлан 60.0 нэгж хувиар, сонгино 29.7 нэгж хувиар, буудай 17.3 нэгж хувиар өссөн бол байцаа 7.4 нэгж хувиар, манжин 5.7 нэгж хувиар, лууван 5.5 нэгж хувиар, төмс 4.5 нэгж хувиар тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 76. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС, (2015 он=100%), бүтээгдэхүүний төрлөөр, хувь

	2017	2018	2019	2020	2021
хувь					
Буудай	96.4	97.4	95.4	97.4	114.7
Төмс	114.7	120.1	92.6	109.3	104.8
Байцаа	111.7	116.1	106.8	112.9	105.5
Манжин	110.5	114.8	80.5	95.6	89.9
Лууван	121.1	129.5	95.8	116.1	110.6
Сонгино	104.8	106.8	124.3	141.0	170.7
Хадлан	154.5	139.2	129.7	140.5	200.5

VII.4. Тариалсан талбай

Улсын хэмжээгээр 2021 онд нийт 678.2 мянган га-д тариалалт хийсэн нь өмнөх оноос 87.0 мянган га буюу 14.7 хувиар өсжээ. Ургамлын төрлөөр авч үзвэл үр тариа 432.6 мянган га, төмс 21.4 мянган га, хүнсний ногоо 11.2 мянган га, таримал тэжээл 108.3 мянган га, техникийн ургамал 99.7 мянган га, эмийн болон бусад ургамал 1.8 мянган га, жимс, жимсгэнэ 3.1 мянган га-д тариалалт хийжээ.


ХҮСНЭГТ 77. ТАРИАЛСАН ТАЛБАЙ

	2017	2018	2019	2020	2021
мянган га					
Нийт тариалсан талбай	527.0	511.8	526.0	591.2	678.2
Үр тариа	390.9	366.8	369.4	408.0	432.6
Буудай	365.7	342.4	343.5	377.0	392.5
Төмс	15.1	12.9	14.9	19.0	21.4
Хүнсний ногоо	8.4	8.9	8.4	10.6	11.2
Таримал тэжээл	26.2	46.3	43.8	84.5	108.3
Техникийн ургамал	81.0	71.9	86.2	64.6	99.7
Эмийн болон бусад ургамал	2.7	1.1	0.3	1.1	1.8
Жимс, жимсгэнэ	2.7	3.9	3.0	3.3	3.1

Тариалсан талбайг ургамлын нэр төрлөөр 2021 оны байдлаар авч үзвэл, өмнөх оноос, техникийн ургамал 35.1 мянган га буюу 54.2 хувиар, үр тариа 24.6 мянган га буюу 6.0 хувиар, таримал тэжээл 23.8 мянган га буюу 28.1 хувиар, төмс 2.4 мянган га буюу 12.5 хувиар, эмийн болон бусад ургамал 0.7 мянган га буюу 63.8 хувиар, хүнсний ногоо 0.6 мянган га буюу 5.9 хувиар тус тус өссөн бол, харин жимс жимсгэнэ 0.2 мянган га буюу 5.9 хувиар буурчээ.

1961-2021 оны нийт болон үр тариа тариалсан талбайн хувьд 1989 онд хамгийн их талбайд буюу 846.1 га-д тариалалт хийсэн бол 2006 онд хамгийн бага буюу 164.6 га талбайд тариалалт хийсэн байна. 1985-1989 онуудад үр тарианы тариалсан талбай нь нийт тариалсан талбайн дунджаар 78.1 хувийг эзэлж байсан бол 1993-2003 оны хооронд тариалсан үр тариа нь нийт тариалсан талбайн дунджаар 93.0 хувийг эзэлж байжээ. Харин сүүлийн 5 жилд үр тарианы тариалсан талбай нь нийт тариалсан талбайн дунджаар 69.8 хувийг эзэлж байгаагаас харахад зөвхөн үр тариа бус бусад газар тариалангийн бүтээгдэхүүний тариалалт нэмэгдэж байна.

ЗУРАГ 60. ТАРИАЛСАН ТАЛБАЙ, га-гаар



Улсын хэмжээнд 2021 онд нийт тариалсан талбайн 63.8 хувийг үр тариа, 16.0 хувийг таримал тэжээл, 14.7 хувийг техникийн ургамал, 3.2 хувийг төмс, 1.7 хувийг хүнсний ногоо, 0.5 хувийг жимс, жимсгэнэ, 0.3 хувийг эмийн болон бусад ургамал тус тус эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад нийт тариалсан талбайд техникийн ургамлын тариалсан талбайн эзлэх хувь 3.8 нэгж хувиар, таримал тэжээлийн 1.7 нэгж хувиар, эмийн болон бусад ургамал 0.1 нэгж хувиар тус тус өссөн бол, харин үр тариа 5.2 нэгж хувиар, хүнсний ногоо, төмс 0.1 нэгж хувиар буурсан байна.

Нийт тариалсан талбай Улаанбаатар хотод 0.2 мянган га (8.4%), Говь-Алтай аймагт 0.2 мянган га (10.1%), Өмнөговь аймагт 0.1 мянган га-гаар (18.3%) буурч, харин бусад аймагт 0.1-39.7 мянган га-гаар буюу 1.5-67.9 хувиар өссөн байна.


ХҮСНЭГТ 78. НИЙТ ТАРИАЛСАН ТАЛБАЙ, аймаг, нийслэлээр

Бүс, аймаг, нийслэл	2017	2018	2019	2020	2021
	мянган га				
Бүгд	527.0	511.8	526.0	591.2	678.2
Баруун бүс	19.2	26.9	29.4	42.0	57.0
Баян-Өлгий	1.3	2.4	1.2	1.2	1.3
Говь-Алтай	1.4	1.3	1.4	1.5	1.3
Завхан	1.9	2.8	3.4	5.4	8.1
Увс	12.3	18.1	20.9	30.2	42.1
Ховд	2.4	2.3	2.4	3.7	4.1
Хангайн бүс	93.4	92.5	98.2	98.5	118.4
Архангай	11.5	10.6	11.3	14.4	15.7
Баянхонгор	0.8	0.6	0.6	0.6	0.7
Булган	48.8	48.5	50.8	49.6	58.0
Орхон	2.6	3.9	3.0	3.7	5.4
Өвөрхангай	11.0	10.0	10.9	11.4	16.7
Хөвсгөл	18.7	18.9	21.6	18.8	22.0

Бүс, аймаг, нийслэл	2017	2018	2019	2020	2021
	мянган га				
Төвийн бүс	341.7	331.0	339.4	384.7	416.5
Говьсүмбэр	0.0	0.0	0.1	0.0	0.1
Дархан-Уул	22.6	20.6	21.1	20.1	25.3
Дорноговь	0.1	0.1	0.1	0.1	0.1
Дундговь	0.1	0.1	0.1	0.1	0.1
Өмнөговь	0.2	0.3	0.3	0.3	0.2
Сэлэнгэ	209.3	200.0	207.4	221.9	225.2
Төв	109.4	109.9	110.4	142.3	165.6
Зүүн бүс	71.6	60.4	57.9	64.1	84.6
Дорнод	34.3	29.9	33.9	35.9	37.9
Сүхбаатар	9.2	7.0	5.5	6.0	10.1
Хэнтий	28.1	23.5	18.5	22.3	36.6
Улаанбаатар	1.1	1.1	1.1	1.9	1.7

Нийт тариалсан талбайг аж ахуйн төрлөөр нь авч үзвэл, ААНБ-д үр тарианы талбайн 90.4 хувь, таримал тэжээлийн талбайн 56.2 хувь нь ногдож байгаа бол иргэд, өрхийн аж ахуйд хүнсний ногооны 78.6 хувь, төмсний талбайн 79.0 хувь нь тус тус ногдож байна.

ЗУРАГ 61. ТАРИАЛСАН ТАЛБАЙ, ургамлын төрлөөр, мянган га



Үр тариа тариалалт 2021 онд Дундговь, Улаанбаатар хот, Говь-Алтай, Ховд, Сэлэнгэ аймгуудад 1.8 га-гаас 16.5 мянган га-гаар буюу 5.5-32.6 хувиар буурч, бусад аймагт 0.4-9.1 мянган га-гаар буюу 3.8 хувиас 1.8 дахин өссөн байна.

Төмс тариалалт Дундговь, Баянхонгор, Говь-Алтай, Булган, Увс, Улаанбаатар хот, Сэлэнгэ аймгуудад 0.9-242.5 га-гаар буюу 2.6-26.6 хувиар буурч, бусад аймагт 0.6 га-гаас 3.0 мянган га-гаар буюу 0.2-56.7 хувиар өссөн байна.

Хүнсний ногоо тариалалт Баян-Өлгий, Дундговь, Сэлэнгэ, Увс аймгуудад болон Улаанбаатар хотод 0.7-164.9 га-гаар буюу 0.5-38.2 хувиар буурч, бусад аймагт 2.2-482.0 га-гаар буюу 4.9-28.5 хувиар өссөн байна.

Байцаа тариалалт Дундговь, Баянхонгор, Өвөрхангай, Увс, Баян-Өлгий, Булган, Улаанбаатар хот, Сэлэнгэ аймгуудад 0.7-92.6 га-гаар буюу 21.2-53.0 хувиар 3 буурч, бусад аймагт 0.1-47.9 га-гаар буюу 5.4-27.1 хувиар өссөн байна.


Лууван тариалалт Дундговь, Сүхбаатар, Говьсүмбэр, Завхан, Говь-Алтай, Дорнод, Хөвсгөл, Орхон, Увс, Улаанбаатар хот, Дархан-Уул, Төв, Сэлэнгэ аймгуудад 0.2-329.1 га-гаар буюу 7.5-26.9 хувиар буурч, бусад аймагт 0.2-60.9 га-гаар буюу 4.0-26.0 хувиар өссөн байна.

Таримал тэжээл тариалалт Говьсүмбэр, Ховд, Өмнөговь, Сэлэнгэ, Дорнод аймгуудад 3.8 га-гаас 1.5 мянган га-гаар буюу 27.0-38.0 хувиар буурч, бусад аймагт 0.05 га-гаас 5.8 мянган га-гаар буюу 9.9 хувиас 3.4 дахин их өссөн байна.

Техникийн ургамал тариалалт Дорнод, Орхон, Улаанбаатар хот, Архангай, Хөвсгөл, Булган, Өвөрхангай аймгуудад 17.5-843.0 га-гаар буюу 0.9-100 хувиар буурч, бусад аймагт 0.5 га-гаас 20.4 мянган га-гаар буюу 50-74.4 хувиар өссөн байна.

Жимс, жимсгэнэ тариалалт Говьсүмбэр, Дорнод, Баянхонгор, Архангай, Сэлэнгэ, Завхан, Улаанбаатар хот, Хэнтий аймгуудад 1.5-138.2 га-гаар буюу 2.1- 4.9 дахин өсөж, бусад аймагт 0.1-183.6 га-гаар буюу 5.4-30.1 хувиар буурсан байна.

ЗУРАГ 62. НИЙТ ТАРИАЛСАН ТАЛБАЙ, аймаг, нийслэлээр, га



Усалгаатай талбайд ургамлын гарцыг нэмэгдүүлэх зорилгоор тусгай зориулалтын услалтын систем, суваг, шуудуу, цистерн зэргийг ашигласныг хамруулах бөгөөд улсын хэмжээнд 2021 онд усалгаатай талбайн тариалалт 109.4 мянган га болж өмнөх оноос 49.2 мянган га-гаар буюу 81.7 хувиар өссөн байна, усалгаатай талбай нийт тариалсан талбайн 16.1 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оноос 5.9 нэгж хувиар нэмэгджээ.

ХҮСНЭГТ 79. УСАЛГААТАЙ ТАЛБАЙН ТАРИАЛАЛТ, эзлэх хувь

	2017	2018	2019	2020	2021
	мянган га				
Нийт тариалсан талбай	527.0	511.8	526.0	591.2	678.2
Үүнээс усалгаатай талбай	36.0	36.5	47.3	60.2	109.4
Эзлэх хувь	6.8	7.1	9.0	10.2	16.1

Усалгаатай талбайд хийсэн тариалалтын 29.1 хувь нь Сэлэнгэ, 26.1 хувь нь Хэнтий, 7.6 хувь нь Увс, 4.7 хувь нь Төв, 4.6 хувь нь Архангай аймагт тус тус ногдож байна.

Усалгаатай талбайн тариалалтыг аймгаар авч үзвэл Улаанбаатар хот болон Булган аймагт 126.1-731.8 га буюу 12.9-31.3 хувиар буурч, бусад аймагт 20.2 -22.3 мянган га буюу 44.1 хувиас 3.2 дахин өсжээ.

ХҮСНЭГТ 80. УСАЛГААТАЙ ТАЛБАЙН ТАРИАЛАЛТ, бүс, аймаг, нийслэлээр

Бүс, аймаг, нийслэл	2017	2018	2019	2020	2021
	га				
Бүгд	36 024.5	36 500.9	47 304.0	60 188.5	109 354.0
Баруун бүс	9 744.1	11 177.4	24 223.1	12 664.2	18 436.6
Баян-Өлгий	1 222.3	2 316.4	1 134.5	1 149.0	2 090.5
Говь-Алтай	1 316.0	1 204.3	1 272.0	1 420.5	2 391.0
Завхан	636.4	705.0	1 176.1	789.2	1 464.6
Увс	4 312.7	4 708.3	18 301.5	5703.3	8 362.9
Ховд	2 256.7	2 243.5	2 339.0	3602.2	4 127.6
Хангайн бүс	9 392.1	5 198.6	2 771.8	5 381.1	13 179.1
Архангай	722.6	282.7	108.7	327.2	5 025.2
Баянхонгор	666.3	509.1	555.6	556.9	1 143.0
Булган	5 845.2	2 417.6	343.1	2 334.5	1 602.7
Орхон	552.4	642.4	517.1	632.8	1 100.9
Өвөрхангай	1 083.3	583.1	634.5	670.6	1 006.4
Хөвсгөл	522.2	763.6	612.9	859.0	3 300.9
Төвийн бүс	14 629.1	17 152.4	14 064.4	16 199.6	40 297.3
Говьсүмбэр	38.7	40.2	49.2	48.8	88.5
Дархан-Уул	2 429.3	1 937.5	1 638.9	1 730.9	2 646.1
Дорноговь	109.5	90.9	63.4	60.2	167.5
Дундговь	91.7	33.4	35.8	45.9	66.1
Өмнөговь	184.6	249.1	265.2	223.1	348.7
Сэлэнгэ	5 941.5	7 818.4	8 815.4	9 600.3	31 866.1
Төв	5 833.8	6 982.8	3 196.4	4 490.3	5 114.2
Зүүн бүс	1 568.0	2 174.6	5 335.7	24 964.1	36 587.5
Дорнод	1 021.4	1 237.9	509.3	2 074.6	4 004.1
Сүхбаатар	94.2	83.6	94.8	917.3	4 061.4
Хэнтий	452.4	853.1	4 731.6	21 972.1	28 522.0
Улаанбаатар	691.3	798.0	908.9	979.5	853.4

Усалгаатай талбайн тариалалтын 31.8 мянган га буюу 29.1 хувийг өрх, 77.6 мянган га буюу 70.9 хувийг ААНБ-ын тариалалт эзэлж байна.

ХҮСНЭГТ 81. УСАЛГААТАЙ ТАЛБАЙН ТАРИАЛАЛТ, аж ахуйн төрлөөр

	2017	2018	2019	2020	2021
	га				
Нийт	36 024.5	36 500.9	47 304.0	60 188.5	109 354.0
ААНБ	14 983.1	15 197.1	21 808.5	37 941.6	77 569.8
Өрх	21 041.5	21 303.8	25 495.5	22 246.9	31 784.2

VII.5. Хураасан ургац


Манай улс 2021 онд 614.5 мянган тонн үр тариа, 182.6 мянган тонн төмс, 121.7 мянган тонн хүнсний ногоо, 293.7 мянган тонн таримал тэжээл, 52.3 мянган тонн техникийн ургамал, 2.4 мянган тонн жимс, жимсгэнэ хураасан нь 2020 оноос техникийн ургамал 29.7 мянган тонноор буюу 1.3 дахин, үр тариа 184.2 мянган тонноор буюу 42.8 хувиар, жимс, жимсгэнэ 0.8 мянган тонноор буюу 47.3 хувь, таримал тэжээл 111.6 мянган тонноор буюу 61.3 хувиар, хүнсний ногоо 0.5 мянган тонноор буюу 0.4 хувиар өссөн бол харин төмс 61.6 мянган тонн буюу 25.2 хувиар буурсан байна.

Хураасан үр тарианы 92.2 хувь нь улаан буудай, 5.4 хувь нь овьёос, 1.9 хувь нь арвай байна.

ХҮСНЭГТ 82. ХУРААСАН УРГАЦ, ургамлын төрлөөр

	2017	2018	2019	2020	2021
	мянган тонн				
Үр тариа	238.1	453.8	433.3	430.3	614.5
Улаан буудай	231.4	436.1	411.4	406.1	566.3
Арвай	1.7	2.4	2.5	3.2	11.7
Овьёос	3.5	10.0	13.3	16.6	33.2
Төмс	121.8	168.9	192.2	244.3	182.6
Хүнсний ногоо	82.1	100.7	99.5	121.2	121.7
Таримал тэжээл	47.9	123.8	121.1	182.1	293.7
Техникийн ургамал	13.9	23.9	34.0	22.6	52.3
Жимс, жимсгэнэ	1.5	1.7	1.8	1.6	2.4

ЗУРАГ 63. ХУРААСАН УРГАЦ, ургамлын төрлөөр, мянган тонн



Хураан авсан 2021 оны ургацыг “Атрын III аян”-ы өмнөх таван жилийн дундажтай харьцуулж үзвэл хураасан үр тариа 488.0 мянган тонн буюу 4.8 дахин, төмс 89.5 мянган тонноор буюу 1.9 дахин, хүнсний ногоо 57.8 мянган тонноор буюу 90.1 хувиар тус тус өссөн байна. Хураасан үр тарианы хэмжээ “Атрын II аян” хэрэгжүүлсний дараагийн жил буюу 1979 оноос 254.0 мянган тонн буюу 70.5 хувиар, төмс 108.9 мянган тонноор буюу 2.5 дахин, хүнсний ногоо 94.9 мянган тонноор буюу 4.5 дахин нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 83. УРГАЦ ХУРААЛТ, сонгосон онуудаар

	1962	1979	2003-2007 оны дундаж	2017	2018	2019	2020	2021
	мянган тонн							
Үр тариа	326.5	360.5	126.5	238.1	453.8	433.3	430.3	614.5
Төмс	23.9	73.7	93.0	121.8	168.9	192.2	244.3	182.6
Хүнсний ногоо	13.3	26.8	64.0	82.1	100.7	99.5	121.2	121.7

Тайлбар: Атрын I, II аян хэрэгжүүлсний дараах жил буюу 1962, 1979, Атрын III аяны өмнөх 2003-2007 онуудтай харьцуулав.

Аж ахуйн нэгж байгууллага 2021 онд үр тарианы 91.7 хувь, таримал тэжээлийн 34.9 хувь, төмсний 19.7 хувь, хүнсний ногооны 26.0 хувийг тус тус хураасан бол иргэд, өрхийн аж ахуй төмсний 80.3 хувийг, хүнсний ногооны 74.0 хувь, таримал тэжээлийн 52.0 хувь, үр тарианы 8.3 хувийг тус тус хураасан байна.


ХҮСНЭГТ 84. ХУРААСАН УРГАЦ, 2021, аж ахуйн төрлөөр

	Үр тариа	Төмс	Хүнсний ногоо	Таримал тэжээл	Үр тариа	Төмс	Хүнсний ногоо	Таримал тэжээл
	мянган тонн				дүнд эзлэх хувь			
Бүгд	614.5	182.6	121.7	293.7	100.0	100.0	100.0	100.0
ААНБ	563.7	36.0	31.6	152.8	91.7	19.7	26.0	52.0
Өрх	50.7	146.6	90.1	140.9	8.3	80.3	74.0	48.0

Хураасан үр тариа хураалтын хэмжээ өмнөх оноос Дундговь, Баян-Өлгий, Улаанбаатар хот, Хэнтий аймгуудад 3.8 тонноос 4.4 мянган тонноор буюу 21.8-37.7 хувиар буурч, бусад аймагт 12.7 тонноос 79.3 мянган тонноор буюу 1.2- 1.8 дахин өссөн байна (Хавсралт хүснэгт 52).

Улаан буудай хураалтын хэмжээ өмнөх оноос Говь-Алтай, Хэнтий аймгуудад 87.9 тонноос 6.7 мянган тонноор буюу 33.7-69.7 хувиар буурч, бусад аймагт 971.0 тонноос 70.4 мянган тонноор буюу 1.1-1.4 дахин өссөн байна (Хавсралт хүснэгт 52).

ЗУРАГ 64. ҮР ТАРИАНЫ ХУРААСАН УРГАЦ



Төмс хураалт 2021 онд өмнөх оноос Дорноговь, Дорнод, Говьсүмбэр, Баян-Өлгий, Сүхбаатар, Завхан, Ховд, Архангай аймгуудад 23.4-890.9 тонноор буюу 26.9-49.6 хувиар өсөж, бусад аймагт 52.6 тонноос 50.7 мянган тонноор буюу 21.4-32.8 хувиар буурсан байна (Хавсралт хүснэгт 52).

Хураасан хүнсний ногоо 2021 онд өмнөх оноос Өмнөговь, Говь-Алтай, Баян-Өлгий, Дархан-Уул, Увс, Улаанбаатар хот, Сэлэнгэ аймгуудад 20.3 тонноос 3.8 мянган тонн буюу 2.0-9.5 хувиар буурч, бусад аймагт 7.7 тонноос 2.4 мянган тонноор буюу 0.5-18.0 хувиар өссөн байна (Хавсралт хүснэгт 52).

Бэлтгэсэн өвс 2021 онд өмнөх Говьсүмбэр, Өмнөговь, Өвөрхангай, Говь-Алтай, Дундговь, Баянхонгор аймгуудад 0.1-8.5 мянган тонноор буюу 5.7 -49.1 хувиар буурч, бусад аймагт 2.1-117.4 мянган тонноор буюу 23.7 хувиас 1.1 дахин өссөн байна (Хавсралт хүснэгт 52).

Жимс, жимсгэнийн хураалт 2021 онд өмнөх оноос Дорнод, Дорноговь, Ховд, Төв, аймгуудад 0.2-31.1 тонноор буюу 10.0-18.0 хувиар буурч, бусад аймагт 0.6-105.9 тонноор буюу 0.6 хувиас 10.1 дахин өссөн байна. (Хавсралт хүснэгт 52).

Улсын хэмжээнд 2020 онд газар тариалан тариалан эрхэлдэг өрх 50.7 мянган тонн үр тариа, 146 мянган тонн төмс, 90.1 мянган тонн хүнсний ногоо, 140.8 мянган тонн таримал тэжээл, 4.9 мянган тонн техникийн ургамал хураан авсан байна.

Харин аж ахуйн нэгж, байгууллагын хураасан үр тариа 2021 онд 563.7 мянган тонн болж өмнөх оноос 168.0 мянган тонноор буюу 42.4 хувь, таримал тэжээл 50.3 мянган тонноор буюу 49.1 хувиар, хүнсний ногоо 2.2 мянган тонноор буюу 7.1 хувиар тус тус өссөн бол харин төмс 23.3 мянган тонноор буюу 39.3 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 85. ХУРААСАН УРГАЦ, 2021 ОН, өрх, ААНБ-аар, ургамлын төрлөөр, аймаг, нийслэлээр

Бүс, аймаг, нийслэл	Өрх				ААНБ			
	Үр тариа	Төмс	Хүнс-ний ногоо	Тари-мал тэжээл	Үр тариа	Төмс	Хүнс-ний ногоо	Тари-мал тэжээл
	мянган тонн							
Бүгд	50.7	146.6	90.1	140.9	563.7	36.0	31.6	152.8
Баруун бүс	14.0	17.6	20.7	16.8	25.9	1.1	0.6	9.9
Баян-Өлгий	0.0	3.3	1.4	0.4	0.0	0.6	0.2	1.1
Говь-Алтай	0.5	0.4	0.4	1.9	0.2	0.1	0.1	0.3
Завхан	0.1	1.9	1.5	5.9	1.7	0.2	0.1	6.7
Увс	13.1	2.1	1.8	6.5	24.0	0.3	0.3	1.9
Ховд	0.3	9.9	15.5	2.0	0.0	0.0	0.0	0.0
Хангайн бүс	13.8	16.3	13.9	26.1	126.9	3.2	1.3	26.9
Архангай	3.4	2.2	1.0	6.7	10.0	0.5	0.2	3.9
Баянхонгор	0.0	1.5	0.9	0.5	0.0	0.2	0.1	0.6
Булган	4.2	4.1	1.7	11.4	65.5	0.6	0.2	8.2
Орхон	0.2	2.7	5.4	1.4	13.3	0.5	0.4	0.7
Өвөрхангай	0.9	3.0	2.5	3.2	14.8	1.1	0.3	11.3
Хөвсгөл	5.1	2.7	2.4	2.9	23.3	0.2	0.1	2.1
Төвийн бүс	21.1	108.4	50.7	88.1	357.3	28.8	26.9	97.4
Говьсүмбэр	0.0	0.2	0.1	0.0	0.0	0.0	0.1	0.0
Дархан-Уул	1.5	6.0	11.1	0.7	22.0	1.8	6.1	3.0
Дорноговь	0.0	0.1	0.2	0.0	0.0	0.0	0.0	0.0
Дундговь	0.0	0.2	0.2	0.0	0.0	0.0	0.0	0.0
Өмнөговь	0.0	0.4	0.4	0.2	0.0	0.1	0.5	0.0
Сэлэнгэ	7.8	14.4	26.5	5.1	199.5	10.2	10.0	25.4
Төв	11.8	87.2	12.2	82.0	135.8	16.6	10.1	68.9
Зүүн бүс	1.8	3.8	2.9	8.9	53.6	2.1	1.5	17.7
Дорнод	0.4	1.4	1.2	0.1	34.3	0.5	0.3	2.3
Сүхбаатар	0.0	0.5	0.2	0.1	4.9	0.3	0.1	4.0
Хэнтий	1.4	1.9	1.4	8.8	14.3	1.3	1.1	11.4
Улаанбаатар	0.0	0.6	1.9	1.0	0.0	0.8	1.4	0.9

VII.6. Га-гийн ургац

Нэг га-гаас дунджаар 2021 онд 14.2 центнер үр тариа, үүнээс 14.4 центнер буудай, 8.9 центнер арвай, 14.7 центнер овьёос, 85.3 центнер төмс, 108.5 центнер хүнсний ногоо, 16.9 центнер таримал тэжээл, 5.3 центнер техникийн ургамал хураан авсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад нэг га-гаас авсан таримал тэжээл 4.7 центнер, хүнсний ногоо 6.2 центнер, төмс 43.1 центнерээр тус тус буурсан бол, үр тариа 3.7 центнер, улаан буудай

3.7 центнер, арвай 1.4 центнер, техникийн ургамал 1.8 центнер, овъёос 4.9 центнерээр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 86. ГА-ГИЙН УРГАЦ, ургамлын төрлөөр

	2017	2018	2019	2020	2021
	центнер				
Үр тариа	6.1	12.4	11.7	10.5	14.2
Улаан буудай	6.3	12.7	12.0	10.8	14.4
Арвай	5.1	7.6	8.6	7.5	8.9
Овьёос	5.2	9.0	9.1	9.8	14.7
Төмс	80.4	130.7	128.7	128.4	85.3
Хүнсний ногоо	98.2	113.6	118.0	114.7	108.5
Таримал тэжээл	18.3	26.7	27.7	21.5	16.9
Техникийн ургамал	1.7	3.3	3.9	3.5	5.3

Манай улсын түүхэнд 1989 онд хамгийн их буюу 673.4 мянган га-д үр тариа тариалж, 1985 онд хамгийн их буюу 886.2 мянган тонн үр тариа хураан авч, 2014 онд хамгийн өндөр буюу 16.5 центнер үр тариаг нэг га-гаас хураан авч байжээ.

ХҮСНЭГТ 87. ХУРААСАН УРГАЦ, ТАРИАЛСАН ТАЛБАЙ, ГА-ГИЙН УРГАЦЫН ДЭЭД ХЭМЖЭЭ, ургамлын төрлөөр


	Хураасан ургац		Тариалсан талбай		Га-гийн ургац	
	он	мянган тонн	он	мянган га	он	центнер
Үр тариа	1985	886.2	1989	673.4	2014	16.5
Буудай	1985	688.5	1990	532.9	2014	16.8
Төмс	2012	245.9	2012	16.8	2012	146.2
Хүнсний ногоо	2014	104.8	2016	9.1	2019	118.0
Таримал тэжээл	1987	607.9	1988	169.5	2019	33.5
Хадлан	1958	1 781.0	-	-	-	-

Төмсний тариалалт 2012 онд хамгийн их буюу 16.8 мянган га талбайд тариалж, хамгийн их ургац болох 245.9 мянган тонн, нэг га-гаас хамгийн их ургацын хэмжээ буюу 146.2 центнерийг хураан авч байжээ.

Хүнсний ногооны тариалалт 2016 онд хамгийн их буюу 9.1 мянган га талбайд тариалж, 2014 онд хамгийн их буюу 104.8 мянган тонн ургац авч, 2019 онд хамгийн их га-гийн ургац буюу 118.0 центнерийг хураан авчээ.


Үр тарианы хувьд түүхэндээ 1985 онд хамгийн их буюу 886.2 мянган тонн үр тариа хурааж байх үед га-гаас 13.9 центнер үр тариа авч байсан дээд үзүүлэлт 2014 онд 16.5 центнер болж шинэчлэгдсэн бол 2020 онд нэг га-гаас авсан ургацын хэмжээ 10.5 центнер болж буурсан байна.

ЗУРАГ 65. ҮР ТАРИАНЫ ГА-ГИЙН УРГАЦ, центнерээр




Нэг га-гаас 2021 онд хураан авсан үр тариаг өмнөх онтой харьцуулбал Хэнтий, Орхон, Завхан, Дархан-Уул, Сүхбаатар аймгуудад 1.5-8.7 центнерээр өсөж, харин Сэлэнгэ аймаг өөрчлөлтгүй бол, бусад аймаг болон Улаанбаатар хотод 1.1-43.8 центнерээр буурсан байна.

ЗУРАГ 66. ҮР ТАРИАНЫ ГА-ГИЙН УРГАЦ, центнер, аймаг, нийслэлээр




Нэг га-гаас хураан авсан хүнсний ногоо Баян-Өлгий, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Төв, Хэнтий, Архангай, Ховд аймгууд болон Улаанбаатар хотод 2.4-79.0 центнерээр буурч, бусад аймагт 2.0-35.7 центнерээр өссөн байна.

ЗУРАГ 67. ХҮНСНИЙ НОГООНЫ ГА-ГИЙН УРГАЦ, центнер, аймаг, нийслэлээр



Нэг га-гаас хураан авсан төмс Завхан, Дорнод, Дорноговь, Баянхонгор, Өвөрхангай, Сэлэнгэ, Архангай, Ховд аймгууд болон Улаанбаатар хотод 0.2-50.9 центнерээр буурч, бусад аймагт 2.8-46.2 центнерээр өссөн байна.

ЗУРАГ 68. ТӨМСНИЙ ГА-ГИЙН УРГАЦ, центнер, аймгаар



Аж ахуйн нэгж, байгууллагын нэг га-аас хураасан үр тариа 2021 онд 14.4 болж 2020 оноос 3.8 центнерээр буюу 35.8 хувиар өсөж, өрхийн нэг га-аас хураасан үр тариа 12.1 центнер болж 2.2 центнерээр буюу 22.2 хувиар өссөн байна. Харин аж ахуйн нэгж, байгууллагын нэг га-аас хураасан төмс 2021 онд 80.0 болж 2020 оноос 47.2 центнерээр буюу 37.1 хувиар, өрхийн нэг га-аас хураасан төмс 86.7 центнер болж өмнөх оноос 42.1 центнерээр буюу 32.7 хувиар тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 88. ГА-ГААС ХУРААСАН ҮР ТАРИА, ТӨМСНИЙ УРГАЦ, аж ахуйн төрлөөр

	Үр тариа					Төмс				
	2017	2018	2019	2020	2021	2017	2018	2019	2020	2021
	центнер									
Нийт	6.1	12.4	11.7	10.5	14.2	80.4	130.7	128.7	128.7	85.3
ААНБ	6.2	12.7	12.0	10.6	14.4	82.0	143.2	135.4	127.2	80.0
Өрх	5.2	9.1	8.8	9.9	12.1	79.7	127.0	126.8	128.8	86.7

VII.7. Хүлэмжийн тариалалт

Хүлэмжийн тариалалт 2021 онд 578.3 га болж, өмнөх оноос 179.2 га-гаар буюу 44.9 хувиар өссөн байна. Бүтцийн хувьд 80.4 хувийг өрх, 19.6 хувийг ААНБ-ын тариалалт эзэлж байна.

Нийт хүлэмжийн тариалалтын 18.2 хувь нь Сэлэнгэ аймагт, 17.9 хувь нь Улаанбаатар хотод, 10.4 хувь нь Төв, 8.1 хувь нь Хөвсгөл аймагт, 5.9 хувь нь Өвөрхангай аймагт байна.

Өрхийн хүлэмжийн тариалалт өмнөх оноос 222.9 га-гаар буюу 92.1 хувиар өссөн байхад ААНБ-нх өмнөх оноос 43.7 га-гаар буюу 27.8 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 89. ХҮЛЭМЖИЙН ТАРИАЛАЛТ, аж ахуйн төрлөөр

	2017	2018	2019	2020	2021
	га				
Нийт	246.5	220.7	239.6	397.2	578.3
ААНБ	103.6	72.0	65.7	156.6	113.3
Өрх	143.0	148.7	173.9	240.6	465.0

Хүлэмжийн ногоо 2021 онд 4.3 мянган тонн болж өмнөх оноос 2.0 мянган тонноор буюу 31.4 хувиар буурсан байна. Нийт хүлэмжийн ургацын 1.1 мянган тонн буюу 25.4 хувийг Сэлэнгэ аймгаас, 1.1 мянган тонн буюу 24.6 хувийг Улаанбаатар хотоос, 0.8 мянган тонн буюу 17.4 хувийг Төв аймгаас, 0.4 мянган тонн буюу 9.5 хувийг Хөвсгөл аймгаас хураан авчээ.

Хүлэмжийн ургацын өсөлтөд Ховд, Төв, Орхон, Баянхонгор, Хөвсгөл, Өвөрхангай, Говь-Алтай аймгуудад 1.8-24.2 тонноор буюу 9.4 хувиас 1.7 дахин өсөж, бусад аймагт 0.2-46.3 тонноор буюу 0.3-68.6 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 90. ХҮЛЭМЖЭЭС ХУРААСАН УРГАЦ

Бүс, аймаг, нийслэл	2017	2018	2019	2020	2021
	ТОНН				
Бүгд	3 069.6	3 107.4	4 485.4	6 296.0	4 318.2
Баруун бүс	154.5	185.1	275.5	219.4	200.3
Баян-Өлгий	-	6.3	143.6	82.9	48.9
Говь-Алтай	22.0	42.2	16.5	13.9	38.2
Завхан	28.5	27.7	27.5	31.0	20.1
Увс	92.5	84.4	67.6	72.4	72.2
Ховд	11.7	24.5	20.3	19.2	21.0
Хангайн бүс	300.1	417.6	477.2	678.4	908.7
Архангай	24.5	75.6	174.9	67.6	21.2
Баянхонгор	16.5	17.1	42.0	27.9	52.8
Булган	37.7	64.3	62.0	121.8	41.1
Орхон	72.5	121.4	94.8	209.3	249.2
Өвөрхангай	139.6	121.0	92.9	57.8	133.9
Хөвсгөл	9.2	18.3	10.5	194.1	410.4
Төвийн бүс	1 372.7	1 505.1	2 597.3	4 196.9	2 101.4
Говьсүмбэр	4.4	9.7	13.7	14.6	12.9
Дархан-Уул	13.7	83.0	29.7	197.8	102.7
Дорноговь	8.9	18.1	20.8	38.1	26.9
Дундговь	25.0	17.2	27.2	45.6	41.9
Өмнөговь	74.1	92.8	59.2	147.5	68.3
Сэлэнгэ	757.4	558.6	1 747.8	3 080.2	1 096.1
Төв	489.2	725.7	698.8	673.0	752.7
Зүүн бүс	69.5	67.6	60.3	93.9	46.7
Дорнод	1.8	13.4	20.5	11.7	9.8
Сүхбаатар	24.5	22.7	18.7	20.0	16.2
Хэнтий	43.2	31.4	21.1	62.3	20.7
Улаанбаатар	1 172.8	932.0	1 075.3	1 107.4	1 061.3

VII.8. Уринш

Улсын хэмжээнд 2021 онд 278.4 мянган га талбайд уринш хийсэн нь өмнөх оноос 48.8 мянган га-гаар буюу 14.9 хувиар буурсан байна. Завхан, Хөвсгөл, Орхон, Булган, Сүхбаатар аймгуудад 0.3-5.5 мянган га-гаар буюу 20.0-100.0 хувиар өсөж, харин бусад аймагт 2.4-23.7 мянган га-гаар буюу 30.3-100.0 хувиар буурсан байна.


ХҮСНЭГТ 91. УРИНШ БОЛОВСРУУЛАЛТ

Бүс, аймаг, нийслэл	2017	2018	2019	2020	2021
	мянган га				
Бүгд	370.7	346.3	350.6	327.2	278.4
Баруун бүс	2.0	4.7	6.2	7.5	7.5
Завхан	1.1	2.2	1.7	1.5	1.8
Увс	0.9	2.5	4.5	6.0	2.5
Хангайн бүс	79.0	70.8	77.5	78.2	78.2
Архангай	9.6	9.7	10.8	12.3	7.8
Булган	42.0	40.6	42.5	39.9	41.3
Орхон	3.8	-	3.7	3.4	4.3
Өвөрхангай	7.2	5.1	7.0	8.0	5.6
Хөвсгөл	16.3	15.5	13.5	14.6	15.0
Төвийн бүс	222.7	239.2	229.3	206.1	206.1
Дархан-Уул	13.9	12.0	11.6	14.9	9.5
Сэлэнгэ	128.5	139.4	135.9	110.0	110.0
Төв	80.4	87.9	81.8	81.2	70.0
Зүүн бүс	67.0	31.6	37.7	35.4	35.4
Дорнод	34.5	12.5	25.8	23.7	-
Сүхбаатар	8.9	9.0	4.1	-	5.5
Хэнтий	23.6	10.1	7.8	11.7	5.0

¹Эх үүсвэр:Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Атрын III аяны өмнөх таван жил буюу 2003-2007 онуудад жилд дунджаар нийт тариалсан талбайд дунджаар 72.8 хувьд уринш хийж байсан бол 2020 онд тариалсан талбайн 41 хувьтай тэнцэх талбайд уринш хийж, 2003-2007 оноос буурсан байна.

ЗУРАГ 69. ТАРИАЛАЛТ, УРИНШ ХИЙСЭН ТАЛБАЙ



ДҮГНЭЛТ

Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д Хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 2021 оны байдлаар 13.0 хувь (үүнээс мал аж ахуйн салбар 11.6 хувь, газар тариалангийн салбар 1.3 хувь, ХАА-н бусад салбар 0.1 хувь), экспортын орлогын 6.0 хувийг хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт бүрдүүлж, нийт ажиллах хүчний 25.9 хувь нь энэ салбарт ажиллаж байна.

Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 7.2 их наяд төгрөг, 2015 оны зэрэгцүүлэх үнээр 4.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад оны үнээр 14.2 хувиар өсөж, зэрэгцүүлэх үнээр 8.1 хувиар буурсан байна.

Газар тариалангийн салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 1470.7 тэрбум төгрөг, 2015 оны зэрэгцүүлэх үнээр 950.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад оны үнээр 61.8 хувиар, зэрэгцүүлэх үнээр 27.1 хувиар тус тус өссөн байна.

Аймаг, орон нутгийн хувьд эдийн засгийн дийлэнх буюу дунджаар 40 хувийг МАА-н салбар бүрдүүлж байна. Тухайлбал аймгийн эдийн засагт мал аж ахуйн салбарын эзлэх хувь Архангай, Дундговь, Говь-Алтай аймагт хамгийн их байхад уул уурхай, үйлдвэрлэл ихтэй Өмнөговь, Орхон, Дархан-Уул аймагт бага байна.

Мал аж ахуй

Мал, тэжээвэр амьтдын тооллогын 2021 оны жилийн эцсийн дүнгээр малын тоо толгой 67.3 сая болж, өмнөх оноос 275 мянган толгойгоор өссөн малын төрлөөр нь авч үзвэл, адуу 4.3 сая, үхэр 5.0 сая, тэмээ 454.0 мянга, хонь 31.0 сая, ямаа 26.4 сая толгой тоологдлоо.

Тооллогоор малтай 246.3 мянган өрх, 188.6 мянга нь малчин өрхийн 305.4 мянган малчид бүртгэгдсэн. Амьжиргааны гол эх үүсвэр нь мал аж ахуй болсон малчин өрхийн эзэмшилд 2021 оны байдлаар нийт малын 90.4 хувь буюу 60.9 сая толгой мал байгаа бөгөөд нэг малчин өрхөд дунджаар 323 мал, харин бодод шилжүүлснээр тооцвол 87 бод мал ногдож байна.

Малчин өрхийг малын тоо толгойгоор нь бүлэглэвэл, 2021 онд нийт 188.6 мянган малчин өрхийн 22.3 мянган өрх буюу 11.8 хувь нь 100 хүртэл малтай, 40.1 мянган өрх буюу 21.3 хувь нь 101-200 хүртэл малтай, 59.6 мянган өрх буюу 31.6 хувь нь 201-500 малтай, 28.8 мянган өрх буюу 15.3 хувь нь 501-999 малтай, 10.5 мянган өрх буюу 5.6 хувь нь 1000-аас дээш малтай байна

Мах, сүүн бүтээгдэхүүнийг орон нутагт үндсэндээ гар аргаар боловсруулсан хэвээр байна. Харин арьс, шир, ноос, ноолуурын маш багахан хувийг дотоодын үйлдвэрт боловсруулж, ихэнх хэсэг нь нэмэгдсэн өртөг шингээгүй, боловсруулалт хийлгүйгээр угаасан, самнасан байдлаар гадаад зах зээлд гаргаж байна. Иймд бүс нутгийн тулгуур төв болон шаардлагатай газруудад нь мал аж ахуйн түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрүүдийг барьж байгуулах нь хүлээгдэж байгаа зорилт хэвээр байна.

Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлд гарч байгаа өсөлт нь үндсэндээ малын тооноос хамаарч байна. Цаашид нэг малын ашиг шим, чанарын үзүүлэлтэд анхаарлаа хандуулж, энэ чиглэлээр үе шаттайгаар үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Тухайлбал:

- малын тоо толгойг газар тариалангийн үйлдвэрлэлтэй зөв харьцаатай хөгжүүлэх,
- газар тариалангийн бүс нутагт ашиг шим өндөртэй мал өсгөж үржүүлэх
- малыг чанаржуулахад чиглэсэн үржлийн бодлогыг эрчимтэй явуулах,
- малчдын хөдөлмөрийг хоршуулах, бэлчээрийг усжуулахад чиглэсэн арга хэмжээ ихээхэн чухал байна.

Сүүлийн 18 жилд буюу 2003-2021 онд хадлан, бэлчээрийн талбай 113.1-111.3 сая га болж 1.8 сая га-гаар багасаж, хонин толгойд шилжүүлсэн нийт малын тоо 46.2-117.6 сая толгой болж 71.4 саяар буюу 2.5 дахин өссөн.

Бэлчээрийн даацын хэтрэлт, цөлжилтийн нөхцөлтэй уялдуулж Улсын Их Хурлаас Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг баталсан нь 2021 оноос хэрэгжиж эхэлсэн билээ. Цаашид татварын орлогоор орон нутагт шаардлагатай төсвийг бүрдүүлэн, мал аж ахуйн бодлогод чиглэсэн үйл ажиллагаанд зарцуулалт хийх эрхтэй болсон билээ.

Газар тариалан

Улсын хэмжээгээр 2021 онд нийт 678.2 мянган га-д тариалалт хийсэн нь өмнөх оноос 87.0 мянган га буюу 14.7 хувиар өсжээ.

Тариалсан талбайг ургамлын нэр төрлөөр 2021 оны байдлаар авч үзвэл, өмнөх оноос, үр тариа 24.6 мянган га-гаар буюу 6.0 хувиар, төмс 2.4 мянган га-гаар буюу 2.4 хувиар, таримал тэжээл 23.8 мянган га-гаар буюу 28.1 хувиар, эмийн болон бусад ургамал 0.7 мянган га-гаар буюу 1.6 дахин, хүнсний ногоо 0.6 мянган га-гаар буюу 5.6 хувиар тус тус өссөн бол, харин техникийн ургамал 35.1 мянган га-гаар буюу 54.3 хувиар өсчээ. Жимс, жимсгэнэ 0.2 мянган га-гаар буюу 6 хувиар буурсан байна.

Манай улс 2021 онд 614.5 мянган тонн үр тариа, 182.6 мянган тонн төмс, 121.7 мянган тонн хүнсний ногоо, 293.7 мянган тонн таримал тэжээл, 52.3 мянган тонн техникийн ургамал, 2.4 мянган тонн жимс, жимсгэнэ хураасан нь өмнөх оноос үр тариа 184.2 мянган тонноор буюу 42.8 хувиар, техникийн ургамал 29.7 мянган тонноор буюу 2.3 дахин, жимс, жимсгэнэ 0.8 мянган тонноор буюу 1.5 дахин тус тус өсчээ. Мөн таримал тэжээл 111.6 мянган тонноор буюу 61.2 хувиар, хүнсний ногоо 0.5 мянган тонноор буюу 0.4 хувиар тус тус өссөн байна. Харин төмс хураалт 61.7 мянган тонноор буюу 25.2 хувиар буурсан байна.

ХАВСРАЛТ ХҮСНЭГТ

ЭНД дарж (мөн QR кодыг уншуулж)
хавсралт хүснэгтүүдийг татаж авах боломжтой

